

СПАЛАТО ХОТЫН ТОМАС АРХИДИАКОНЫ *HISTORIA SALONITANA* ХЭМЭЭХ XIII ЗУУНЫ МОНГОЛЧУУДЫН ТҮҮХТЭЙ ХОЛБОГДОХ НЭГЭН ЛАТИН СУРВАЛЖ

Б. Чинзориг

Товч утга: XIII-XIV зууны үед Их Монгол улс болон латин хэлт Христийн шаашинт улсууд харилцаж байсныг гэрчилэх ховор чухаг нэгэн бүлэг түүхэн баримт бол Унгар, Хорватын эрхүүд нэрийн бичиж үлдээсэн цөөн хэдэн тэмдэглэл, захидлууд юм. Тэдгээрээс Адриатын тэнгисийн зүүн эргийн хот Спалатогийн христийн шаашны гол сүмийн архидиакон Томас хэмээгчийн латин хэлнээ бичсэн *Historia Salonitana* хэмээх тэмдэглэлийн дөрвөн бүлэг 1241-1242 онд монголчуудын Унгарын вант улсыг байлдан дагуулсан түүх төдийгүй 1237-1242 онд монголчуудын Европт хийсэн довтолгооны тухай үнэтэй сурвалж болдог. Монголын түүхбичлэгт тэр болгон ашиглагддаггүй энэхүү анхдагч сурвалжийг задлан шинжилж, орчуулж тайлбарлах нь уг өгүүлэлийн зорилго болно.

Түлхүүр үг: *Historia Salonitana*, архидиакон Томас, XIII зууны монголчуудын Европт хийсэн аян дайн, дундад зууны монголчууд ба латин хэлт христийн шаашны ертөнцийн харилцаа

Зохиогчийн тухай. XIII зууны үеийн Газар дундын тэнгисийн нэгэн хэсэг Адриатын дорнод эрэг болох Далмацийн чухал төв - Спалато хотын кафедрал сүмийн архидиакон Томас харъяат сүмийнхээ эртнээс нааш өөрийн үе хүртэлхи албан ёсны түүхийг бичсэн нь *Historia Salonitana* юм. *Historia Salonitana* хэмээгдэх сүмийн түүхийн сүүлийн 18 бүлэг зохиогчийн намтрыг үндсэндээ бүрдүүлнэ. Зохиогч эдгээр бүлгүүдийг бичихдээ үзэж сонссон буюу биечлэн оролцсон хэрэг явдлуудаараа голчлон холбон найруулж туурвисан байдаг ч ганц, хоёрыг эс тооцвоос бараг бүх тохиолдолд өөрийгөө гуравдугаар биед хандан бичсэн онцлогтой. Архидиакон Томасыг амьдарч байсан хийгээд түүний бичиж тэмдэглэсэн үйл явдлууд бодитой болж өрнөсөнийг гэрчилэн нотолсон эдийн болон бичгийн ул мөр эдүгээ тун цөөн үлдсэн байдаг тул бүхэл амьдралын намтрыг нь бичиж үлдээсэн энэхүү цорын ганц бүтээлээс нь л сэргээн тогтоох боломж олддог юм.

Томас архидиаконы *Historia Salonitana*-гийн дундах өөрийн намтрын эхлэлд дурдсан мэдээнээс өөр түүний хэдүйд төрснийг нотлох баримт огт байхгүй байна:

Post hec autem anno Domini millesimo duecentesimo tricesimo vacante archidiaconatu capitulum et universus clerus in summa concordia elegerunt Thomam canonicum in archidiaconum suum tricesimo etatis sue anno... [Үүний дараа 1230 онд сүмийн хурал болон санваартны хүрээ бүрэн санал нэгдэн эзгүй буй архидиаконы суудалд Томас каноныг гучин насанд нь сонгов...]¹

Энэ мэдээг үндэслэвэл тэрээр 1200 онд төрсөн болох нь тогтоогдож буй ч чухам нийгмийн болон угсаатны ямар гаралтай болох тухайд судлаачид ерөнхийдөө сурвалжийн үйл явдлуудын контекстэд тулгуурлан адилгүй таамаглал дэвшүүлжээ. *Historia Salonitana*-ийг сурвалжийн хувьд анхлан шүүмжлэлтэйгээр задлан шинжилсэн Хорватын түүхч Франжо Рачки (Franjo Rački, 1824-1894) түүнийг ямар гэр бүлээс гаралтай нь мэдэгдэхгүй байна гэсэн бол тус бүс нутаг Иллирийн шашны түүхийн тухай найман боть нэвтэрхий толь бичгийг XVIII зууны сүүл XIX зууны эхэн үед туурвисан Италийн шашны түүхч Даниелэ Фарлати (Daniele Farlati, 1690-1773), XX зууны эхэн үед Томас архидиаконы намтрыг анхлан сэргээн босгосон Хорватын түүхч Керубин Сэгвич (Cherubin Segvić, 1867-1945) нар XIII зууны католик христийн шашны сүмийн ноёрхол давамгайлж байсан тухайн цаг үед сүм хийдийн ийм том албан тушаалд язгууртан (патрици) гаралтай хүнийг тохоон томилдог байсан бөгөөд тэр үед хотын олон нийтийн амьдралд Томас шиг идэвхитэй оролцох бололцоо зөвхөн дээд давхрагын баян гэр бүлд л байсан гэж тайлбарласантай² ерөнхийдөө судлаачид санал нэгтэй байна³. Харин түүний гэр бүлийн угсаа гарлын

-
1. Thomæ Archidiaconi Spalatensis - Archdeacon Thomas of Split. *Historia salonitanorum atque spalatinorum pontificum - History of the Bishops of Salona and Split*, latin text by Olga Perić, ed., trans. and annotated by Damir Karbić, Mirjana Matijević Sokol and James Ross Sweeney, Budapest and New York: Central European University Press, 2006, 198-199 (үүнээс хойш Sweeney/HS); Thomas, Archidiaconus. *Historia Salonitana*, digessit Franjo Racki, Zagrabiae, in taberna libraria eiusdem societatis typographicae, 1894, 107 (үүнээс хойш Racki/HS).
 2. Farlati, Daniele. *Illyricum sacrum: Ecclesia Spalatensis olim Salonitana*, Vol. 3, Venetiis, 1765, 258; Šegvić, Cherubino. *Tommaso Arcidiacono: il suo tempo e la sua opera*, Supplemento al *Bullettino di Archeologia e storia dalmata*, Spalato: Tipografia Leonina, 1914, n. 2, 23.
 3. Sweeney/HS, xxiii; Mirjana, Matijević Sokol. "Archdeacon Thomas of Split (1200-1268) – A Source of Early Croatian History," in *Review of Croatian History* 3, 2007, 251-252. Just-Verdus, Antonio. "Biografia di Tommaso," in *Atti e memorie della Società Dalmata di Storia patria* 5, 1966, 67; Cocci, Alfredo. "Venezia e il Medio-Adriatico nella "Historia Salonitanorum Pontificum atque Spalatensium" (1245-1251) di Tommaso da Spalato L'Arcidiacono," in *Clio* 34/2, 1988, 365.

тухайд, Европ дахь христийн шашны хэл, соёлын үндсэн дамжуулагч хэрэгсэл болох латин хэл, үзэл санаагаар тэмдэглэлээ бичихдээ зохиогч хорват зэрэг славын угсаатны олон бүлгүүд, мөн тэрчилэн унгаруудад ч гэсэн таагүй хандаж байдагаа олонтаа илэрхийлсэн байдагаас үүдэн зарим судлаачид түүнийг хорват бус харин латин гаралтай байж болох тухай саналтай байгааг баттай нотлох давхар баримт үгүй, энэ нь чухамдаа Баруун Европын латин хэл, шашинд үндэслэн хүчтэй хөгжиж байсан нийгмийн шинэ хэв маягийн зохион байгуулалт болох хотжих үйл явц Зүүн Европын уламжлалт аж ахуйд тулгуурласан хөдөөгийн нийгмийн хөрсөнд нэвтэрч эхлэх үед тэр цагийн Далмацийн нийгмийн гишүүдийн дунд үүссэн үзэл санааны зөрчилтэй яах аргагүй холбоотой юм.⁴

Зохиогчийг өсч хүмүүжихэд Италийн Тоскано мужаас залагдаж ирсэн христийн католик шашны хоёр санваартан Бернард (Bernardus), Трегуан (Treguanus) нар ихээхэн үүрэг гүйцэтгэсэн болох нь *Historia Salonitana*-аас дам мэдэгдэж байна. Бернард бол дундад зууны үеийн энэ цаг үеийн хамгийн том их сургуулиудын нэг Болонийн их сургуульд 30 гаруй жил эрдэм мэдлэгт суралцсан хүн байв. Тэрээр ойролцоогоор 1192 оноос хойш III Целестин (Celestine III, 1191-1198) папын Унгарын ванд илгээсэн элчийг даган Унгар, Далмацийн нутагт ирж, улмаар Унгарын хаан III Бела (Béla III, 1173-1196) болон түүний гэр бүл, ордныхонтой дотно харилцаа тогтоон, ууган хүү залуу Емирикийг нь (Emeric, 1174 төрсөн, 1196-1204) сурган хүмүүжүүлж байв. Спалато хотынхон Унгарын шинэ хаан Эмерикд ойр дотно энэхүү Бернардыг өөрсдийн гол сүмийн эзгүй буй архишопын албанд томилуулж болох эсэхийг христийн католик шашин түгсэн тухайн цаг үеийн газар орны уламжлал ёсоор шашны тэргүүн III Иннокент папд (Innocent III, 1198-1216) элч илгээн айлтган хүссэнийг Томасын төрсөн он буюу 1200 онд зөвшөөрөн батлаж томилсон байна. Томилогдсон даруй Спалато болон Трогир хотоос тэрээр тэрс үзэлтнүүдийг цэвэрлэн хөөсөн явдлыг нь пап сайшааж байжээ. Мөн Унгарын хаан Эмерик амьд ахуйдаа нуган хөвүүн Ладисласыг (Ladislas III, 1199 онд төрсөн, 1204 хаан ширээнд суусан) 1204 онд ширээнд залах ёслол үйлдүүлэн, энэ ёслолд бяцхан хүүд титэм зүүлгэх эрхэм хүндтэй үүргийг Бернардад оноож байсан, мөн 1205 онд хаан ширээг шинээр эзлэн авсан Эмерикийн дүү Эндрю (Andrew II, 1205-1235) хаан ширээнд суух ёслолдоо урьж байсан, 1202 онд Загалмайтны IV аян дайнд оролцох зорилгоор Венецид цугларан дайнд мордсон загалмайтнууд замдаа Хорватын Задар хотыг дайран тонон дээрэмдсэний дараа Задар

4.Хорватын үндэсний түүхчдийн дундах холбогдох маргааны тухай товч хэлэлцүүлгийг Sweeney/HS, xxiii-xxiv; Mirjana, 2007, 251-252-т үзнэ үү.

хотынхон Бернард эрхүүний хүч чармайлтын ачаар эргүүлэн хотоо аварч чадсан, хожим нь 1215 онд Ромад зохион байгуулагдсан шашны дээд хурал Латераны IV чуулганд биечлэн оролцсон зэргийг үзвэл Томасын хүүхэд ахуй цагт амьдарч байсан хорватын хамгийн хүндтэй шашны зүтгэлтэн байж, Томасын латин хэл, соёл эзэмших замыг нээхэд ихээхэн нөлөөлсөн бололтой байна. Харин Трегуан нь Флоренц хотоос гаралтай, анх Бернардыг дагалдан Унгараас Спалато хотод ирж санваартнуудад латин хэл бичиг зааж, хожим нь Хорватын өөр нэг хот болох Трогирыг хариуцсан бишоп болон дэвшиж байсан, хорватуудын дунд латин соёл түгээн дэлгэрүүлсэн анхны хүмүүсийн нэг байв. Томас бүтээлдээ эдгээр хүмүүст ихэд хүндэтгэлтэй хандан бичсэн байдаг.⁵ Папын тэргүүлсэн Христийн католик шашны орон нутгийн өндөр тушаалтан эдгээр хүмүүсийн нөлөөгөөр латин хэл бичигт суралцан хүмүүжиж өссөн Томас тухайн үедээ Европ даяар Ромын төрийн болон шашны хууль, цаазын сургалтаар тэргүүлэх Италийн Болонийн их сургуулийг зорин суралцсан нь түүний цаашдын амьдрал, үзэл санаанд гүнзгий нөлөө үзүүлжээ.

Болонийн их сургууль бол 1100 оны орчим байгуулагдан хууль эрхзүйн боловсрол дагнан олгодог хамгийн анхны их сургууль болон хөгжиж тухайн цаг үедээ христийн шашны онолын сургалтаар мэргэжсэн Парисийн их сургуулийн хамт Европын дундад зууны их сургуулийн тогтолцоо, сургалтын загвар бүрэлдэн бий болоход хамгийн чухал нөлөө үзүүлсэн юм. Тус их сургуулийн багш хуульч Ирнериус (Irnerius, 1050-1125) болон түүний шавь нар Ромын эзэнт гүрний үеийн хууль эрхзүйн бичгүүдийг шинэ хэв маягаар тайлбарласнаар уг сургуульд дундад зууны Европын хууль эрхзүйн системт судалгааны үндэс тавигджээ. 1155 онд Ариун Ромын эзэнт улсын хаан болсон Фредерик Барбаросса *Constitutio Habita* хэмээх хуулийг 1158 онд гаргаснаар тус их сургууль улс төр, шашны ямар ч эрх мэдлээс ангид хууль эрхзүйн судалгаа явуулах төв болох, мөн түүний багш, оюутнууд эзэнт улс даяар хуулийн онцгой их эрх мэдэл эдлэх боломжтой болжээ. Ингэснээр тус их сургууль XII зууны хоёрдугаар хагаст цэцэглэн хөгжиж, энд Европын өнцөг булан бүрээс янз бүрийн үндэстний асар олон тооны оюутнууд ирж суралцах болсон ажээ.⁶

5. Бернардын Спалато хотын сүмийн түүхэнд оруулсан хувь нэмрийн тухай бичихэд Томас бүхэл бүтэн хоёр бүлэг зориулсан байна: Sweeney/HS, chs. 23-24, 134-157. Трегуаны тухай *ibid*, 154-157-д үзнэ үү.

6. Verger, Jacques. "The Universities and Scholasticism," in *The New Cambridge Medieval History*, ed. by David Abulafia, Vol. 5, Cambridge: Cambridge University Press, 1999, ch. 10, 256-276; Clark, David S. "The Medieval Origins of Modern Legal Education: Between Church and State," in *The American Journal of Comparative Law* 35/4, 1987, 672-678.

Спалато хотын архбишоп Бернард 1217 оны орчим нас барсны дараа Томас яг хэдийд Италийн хойгийн зүүн эрэгт орших Болонийн их сургуульд суралцахаар явсан нь⁷ тодорхойгүй боловч 1210-аад оны сүүл 1220-оод оны үед эх нутгаасаа хөдөлсөн болов уу гэж таамаглаж болохоор байна. Томасыг сургуульд сурч байх үед Баруун Европын түүхийн гол үйл явдлууд Италийн хойгт өрнөж, Италийн хот улсуудын нийгэм, улс төр, шашны амьдралд ихээхэн өөрчлөлт орж байсан цаг байв. Баруун Ромын эзэнт улсын ноёрхож байсан Баруун Европын газар нутгуудад XI зуунаас эхлэн эдийн засаг, улс төрийн шинэ бүтэц тогтон хүн амзүйн хувьд огцом тэлж, энэ процесс XII зууны турш эрчимтэй үргэлжилсний үр дүнд Баруун Европт олон улсын худалдаа наймаа нэмэгдэн, хотын амьдрал эртний сонгодог үеэс өөр шинэ хэлбэрээр эдийн засаг, улс төрийн хувьд харьцангуй бие даасан байдалтай хөгжин цэцэглэх болжээ.⁸ Энэ хөгжил Газар дундын тэнгисийн бүсэд хальж цэрэг дайны түрэмгий хэлбэрээр ч тэлэх болов. Норманчууд Сицилийн арлыг исламын гараас салгаж, төд удалгүй Умард Европын христийн шашны Загалмайтнууд цэргийн хүчээр Сири, Палестинд франкуудын эзэмшил газруудыг байгуулав. Латин хэлт христийн шашинт ертөнцийн шинэ өсөлт тэлэлт далайн тээвэр, худалдаанд түшиглэсэн Италийн хойгийн хот улсуудад ихээхэн эд баялаг авчирч, Газар дундын тэнгисийн дорнод хэсэгт ноёрхолоо тогтоож чадсан байна.

Тус хойгийн умард-төв хэсэгт хүчээ аван шинээр хөгжсөн хотуудын нийгмийн дотор худалдаачид, хуульч, эмч зэрэг тодорхой мэргэжлийн бүлэглэлүүд бие даасан шинэ язгууртны давхрагыг шинээр буй болгон,

7. Хотууд хөгжин цэцэглэсэн явдал өөр ондоо газруудаас олон тооны оюутнууд их сургуулиудыг зорин удаан хугацаанд суурьшин суралцах нөхцлийг бүрэлдүүлсэн бөгөөд үүнд Европын худалдаа, эдийн засгийн өсөлтийг даган олон улсын зээл, мөнгөний зохицуулалт улам сайжирсан нь оюутнууд зээл тусламжаар эх нутгаасаа алс хол газар амьдран суралцах өргөн боломжыг олгож байв. Олон улсаас ирсэн оюутнууд латин хэл мэдэж байх шаардлагатай байсан бөгөөд хичээл заалгасныхаа төлөө багшдаа тодорхой хэмжээний мөнгө төлөх чадвартай байх ёстой, хэрвээ оюутан ядуу бол орон нутаг, төрөлх хот, эсвэл хувийн ивээн тэтгэгч, заримдаа сүм, сүмийн тэргүүнүүд санхүүжүүлдэг байжээ. Ирж буцах зардал, хичээл заалгах, шалгалт өгөх, амьдрах, сурах бичиг, ном сударт асар их зардал гардаг, тиймээс сүм, орон нутгийн удирлага ивээн тэтгээгүй бол язгууртан хөрөнгөтэй гэр бүлээс гаралтай хүн л сургуульд сурах боломжтой байв (Clark, 681-682). Томас чухам ямар санхүүгийн эх үүсвэрээр Болонид суралцсан нь мэдэгдэхгүй боловч ямартаа ч ийнхүү суралцсан явдал нь түүнийг хөрөнгө бүхий язгууртан гэр бүлээс гаралтай болов уу хэмээн таамаглахад хүргэж байна.

8. Дундад зууны Италийн хот улсууд бүрэлдэн бий болсон явцын тухай Giorgio Chittolini. "The Italian City-State and Its Territory," in *City States in Classical Antiquity and Medieval Italy*, ed. by Anthony Molho et al., Ann Arbor: University of Michigan Press, 1991, 589-602-г үзнэ үү.

хуучин сурвалжит язгууртнуудын адил, зарим тохиолдолд тэднээс ч илүүтэйгээр христийн шашны сүм хийдүүд болон эрдэм ухаан, урлалыг дэмжин тэтгэх болжээ. Энэ шинэ давхрагынхан урьд өмнөхөөс их шилжилт хөдөлгөөн, өрсөлдөөн дунд, олон зууны хэвшиж тогтсон ёс заншлаас харьцангуй ангид, сул чөлөөтэй амьдран, мөн илүү их аминч, хувийн үзэлд тулгуурласан улс төрийн шийдвэр бодлого баримтлахын зэрэгцээ хотын нийгмийн уламжлалт оюун санааны итгэл үнэмшил, шашны болон төрийн тогтож хэвшсэн байгуулалд шүүмжлэлтэй хандах сэтгэлгээтэй болж байв. Италийн ийм шүүмжлэлт сэтгэлгээтэй хот-улсын иргэд хотын засаглалыг зөвхөн хотын албан ёсны иргэдийн бүрэлдэл бүхий шинэ зохион байгуулалтаар хэрэгжүүлэх болов. Ялангуяа XIII зууны эхэн гэхэд Италийн умард-төвийн хот улсууд Европын бусад хэсгээс хотын засаглалын шинэ хэлбэрээр онцгой ялгарах болсон байв. Эдгээр хотуудад засаглалыг шашны болоод төрийн хүмүүс аль аль нь удирдах нь хэвээр байсан ч зохион байгуулалтын хувьд өөрчлөгдөн хотыг удирдах тусгай захиргааны газар байгуулан түүнийг урьдын дархан эрх мэдэлтэй дээд язгууртан бус харин оронд нь иргэний болон шашны хууль цаазын чиглэлээр их сургуульд боловсорсон, бичгийн харилцааны чадвартай харь гаралтай буюу өөр хотын иргэн тодорхой хугацаанд, ихэвчлэн жилийн хугацаатайгаар, цалинтай удирдах болжээ. Хот-улсуудын иргэний болон цэргийн бүхий л хэргийг захиран шийтгэх эрх бүхий ийм албанд томилогдсон хүнийг *podestà* хэмээн нэрлэж байв. Томасын их сургуульд сурсан Болони хот бол 35000, 40000 хүн амтай бие даасан хот-улс байсан бөгөөд *podestà* хэмээх алба Италид хамгийн анх буюу 1151 онд чухам энэ хотод хэрэгжсэн юм. Чөлөөт бие даасан хотуудын дотоод хэргийг гадаад, харь хүнээр удирдуулан шийтгэх энэхүү удирдлагын тогтолцоог XII зууны хоёрдугаар хагаст Италийн хамгийн чухал хот-улсууд хэрэгжүүлсэн байна: Верона 1163, Падова 1174, Парма 1175, Лоди 1183, Фиренци буюу Флоренци 1184, Милан 1186, Пиза 1190, Женова буюу Генуа 1191 онд.

Үүний хажуугаар нийгмийн дунд эдийн засаг, баялгийн өсөлтөөс буй болсон ёс суртахуун, боловсролын доройтлыг өөрчилөн шинэчлэх үзэл санааг хүлээж авахад бэлэн хүмүүс ч буй болов. Чухам шашны оюун санааны ийм хөрсөнд нэг бол уламжлалт хэв маягаас өөр салан тусгаарлах, “тэрс үзэл санаа” баримтлах юм уу эсвэл сүсэг бишрэлийн хувьд шинэчлэн өөрчлөх оролдлогууд газар аван тархах болсон байна. Шашны дотоод үйл ажиллагаанд өөрчлөлт оруулсан хөдөлгөөнүүдийн тод жишээ бол XIII зууны 20-оод оны үед Ромын христийн шашины дотор папын зөвшөөрлөөр үйл ажиллагаагаа албан ёсоор явуулах

болсон Доминикан болон Францискан ёс юм.⁹ Томас Болони хотод суралцах хугацаандаа эдгээр урсгал ёсуудын тэргүүн нар алсын аян замд гаран өөрсдийн үзэл номлолыг биечлэн айлдаж, ингэхдээ ялангуяа оюун санааны гол төвүүд болох их сургуулиуд бүхий хотуудаар түгээн дэлгэрүүлж эхэлж байсантай таарч, зарим тохиолдолд номлол сургаалыг нь биечлэн сонсох боломж олдож, энэ туршлага нь эргээд түүний цаашдын үзэл бодолд ихээхэн нөлөө үзүүлж байжээ:

Eodem anno in die assumptionis Dei Genetricis, cum essem Bononie in studio, vidi sanctum Franciscum predicanem in platea ante pallatium publicum, ubi tota pene civitas convenerat. Fuit autem exordium sermonis eius: angeli, homines, demones. De his enim tribus spiritibus rationalibus ita bene et diserte proposuit, ut multis litteratis, qui aderant, fieret admirationi non modice sermo hominis ydiote nec tamen ipse modum predicantis tenuit, sed quasi contionantis. Tota vero verborum eius discurrebat materies ad extinguendas inimicitias et ad pacis federa reformanda. Sordidus erat habitus, persona contemptibilis et facies indecora. Sed tantam Deus verbis illius contulit efficaciam, ut multe tribus nobilium, inter quas antiquarum inimicitiarum furor immanis multa sanguinis effusione fuerat debachatus, ad pacis consilium reducerentur.. [Мөн тэр жил Эзний Эхийг хутаг олсны өдөр, Болонид сурч байхдаа би нийтийн ордны урд талбайд хотынхон бараг бүгдээрээ цугларан Гэгээн Франческо номлол айлдахыг харсан бөлгөө. Тэрээр “Эзний элч, хүн, чөтгөр”-ийн тухай номлож эхлэв. Тэнд ирсэн бичиг боловсролтой олон хүмүүс энэ эгэл хүмүүний хэлсэн үгсэд өчүүхэн ч гайхшрахааргүй тийм сайн, сэцэнээр эдгээр гурван рациональ сүнсний тухай сургаал номлолыг тэрбээр айлдаж амуй. Түүнд ямар нэг номлон сургагчийн байдал байсангүй, харин ч ил тод илтгэн яригч нэгэн шиг байсан билээ. Хэлсэн бүх үгс нь дайсагналыг арилгаж, энхийн холбоог эргэн тогтоох сэдвээр хэлэлцэн ярьж байв. Хувцас нь нооройсон, байгаа байдал нь дорой муу, царай нь үзэмжгүй муухай ч гэсэн хэлсэн үгс нь их цус урсгаж хилэгнэн уурласан эртний өст дайснуудыг агуулсан олон язгууртан овгуудыг эргэж найрамдуулах их увдисыг Эзэн Тэнгэр түүний хэлсэн үгсэд өгсөн байжээ.]¹⁰

Гэгээн Францескогийн Болони хотын нийт иргэдэд 1222 оны 8-р сарын 15-нд айлдсан номлолыг Томас үзсэнээ амьдралынхаа гол үйл явдлуудад тооцож байсан гэдэг нь ийн үзэж харсанаа дурссан тэмдэглэлийнхээ энэ хэсэгт анх удаа өөрийгөө нэгдүгээр биед төлөөлүүлэн бичсэнээс нь тод мэдэгдэнэ.

9. Доминикан ёс буюу *Мөргөлч ахан дүүсийн ёсыг* (Ordo fratrum praedicatorum) Доменико дэ Гузман (Domenico de Guzmán, 1170-1221) хэмээгч христийн санваартан 1216 оны III Иннокент папын хуралдуулсан Латераны IV Чуулганы дараахан III Онориус папын зөвшөөрлөөр албан ёсоор Болони хотод байгуулсан. Харин Францискан ёс буюу *Бага ахан дүүсийн ёсыг* (Ordo Franciscanus Saecularis) үндэслэгч Италийн Ассиси хотоос гаралтай Франческо (St. Francesco, 1182-1226) өөрийн байгуулсан ёсыг 1223 онд албан ёсоор папаар зөвшөөрүүлэхээсээ өмнө Болонид саатан номлол сургаалиа айлдаж байв.

10. Sweeney/HS, 178-179.

Христийн шашны дотор гарсан оюун санааны өөрчлөлт хөдөлгөөн нь III Иннокент, III Онориус нарын зэрэг Ромын христийн шашны төв удирдлагаас шашны бодлогыг ариутган шүүх, чангатгах, даяар олонд түгээн дэлгэрүүлэх, аливаа төрт улс, хот тосгодыг, тэр дундаа *Ариун Нутгийг* (Terra Santa) христийн шашны туганд нэгтгэсэн христийн шашинт хүчирхэг ертөнцийг байгуулах зорилгыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр болох учиртай байв. Жишээ нь, папууд хөгжин дэвшиж буй их сургуулиудыг шашны үйл хэрэгт ашиглах хамгийн гол хэрэгсэл болгож байв. Ялангуяа сүмийн хууль эрхзүйн тогтолцоог улам боловсронгуй болгох, папын гаргасан зарлиг, цаазыг нь хүчин төгөлдөр болгож даяар олонд тайлбарлан таниулж эрх мэдлийг нь баталгаажуулан өргөтгөн тэлэхэд хуулийн сургуулиуд хамгийн их үүрэгтэй байв. 1210 онд III Иннокент пап гаргасан зарлигуудаа Болонийн их сургуульд илгээх болов. Тэнд папын зарлигийг багш эрдэмтэд улам боловсронгуй тайлбарлан найруулан бичиж хэвлэдэг, тэдгээрийг нь оюутнууд хуулан тараах болов. Мөн оюутнууд сургуулиа төгсөөд папын бичгийн алба, христийн сүмийн шашны үйл хэргийг шийтгэх газруудад ажиллах болсноор Христийн шашны ертөнц даяар папын эрх мэдлийг үнэнчээр хэрэгжүүлэх боловсон хүчинг бэлдэх чухал үүрэг их сургуульд оногдох болсон байна. Томас их сургуулиа төгсөн эх орондоо буцаж харьсны дараа удалгүй төрөлх хотынхоо шашны хамгийн чухал албанд томилогдсоны учир чухам үүнтэй шууд холбоотой.¹¹

III Иннокент папын баримталж байсан шашны хаант улсыг байгуулах гэсэн энэ бодлого түүнийг 1216 онд нас барсны дараа пап болон Ариун Ромын эзэнт улсын залуу хааны хоорондох буюу шашин, төрийн хоорондох олныг хамарсан зөрчилт, хямралт тэмцлийн хэлбэрээр Италид үргэлжилсэн юм.¹² XII зууны төгсгөл, XIII зууны эхээр хот улсуудын аливаа төвлөрсөн эрх мэдлээс хараат бус оршин тогтнохын төлөөх эрмэлзэл, мөн христийн шашны тэргүүн пап хийгээд төрт улсуудын тэргүүнүүдийн хооронд улс төрийн эрх мэдлийн ноёрхлыг тогтоохын тэмцэл чухамдаа Томасыг Италийн Болони хотын их сургуульд байх үед явагдаж байсан тул эдгээр бүх өөрчлөлт хөдөлгөөнийг үзэж мэдэрсэн туршлага нь эргээд түүнийг сургуулиа

11. Lawrence, C.H. *The Friars: the Impact of the Mendicant Orders on Medieval Society*, New York: Longman, 1994, 12-15; Moore, John C. *Pope Innocent III (1160/1161-1216): To Root Up and to Plant*, Leiden and Boston: Brill, 2003, 185-186. Болонийн их сургуулийн хуулийн эрхзүйн сургалт хэрхэн үүсэж, хөгжсөн, түүнд пап, эзэн хааны тэмцлийн хэрхэн нөлөөлж байсан тухай дэлгэрэнгүй судалгааг Clark, 653-719-д үзнэ үү.

12. Төр, шашны хууль, эрхзүйн боловсрол олгодог хамгийн том их сургууль (*studium*) орших Болони хот нь пап (*sacerdotium*), эзэн хааны (*imperium*) хоорондох өрсөлдөөн тэмцлийн гол талбар болж байсан хотуудын нэг байв.

төгсөөд төрөлх хот Спалатод буцаж ирсний дараа зорьж хэрэгжүүлэхийг оролдож байсан улс төрийн үйл ажиллагаа, үзэл баримтлалд нь гүнзгий нөлөөлсөн байдаг. Ерөөс хууль эрхзүйн хамгийн нэр хүндтэй их сургууль - Болонийн их сургуулийг амжилттай төгссөн оюутнууд нэг бол шашны хийгээд төрийн бичгийн, шүүх албанд, эсвэл хотын захиргааны албанд шүүгч, нотариатч, дипломатч, дарга, зөвлөгчийн алба хашдаг байсан байна.

Томас их сургуулиа яг хэзээ төгсөж ирсэн нь тодорхойгүй ч 1227-1230 оны хооронд Спалато хотод нотариатчаар буюу хотын хууль бичгийн албан хаагчаар ажиллаж байсан нь бусад сурвалжуудаар нотлогддог.¹³ Энэ хугацаанд түүний шашны зэрэг ч гэсэн энгийн санваартнаас дэд диакон болж дээшилсээр, эцэст нь эзгүй байсан архидиаконы албанд¹⁴ томилогдов. Томас тус албыг хүлээн авч папаас албан ёсны зөвшөөрлийг хүртсэний дараа Унгарын хааны ордноос урьд өмнө Хорватын Спалато хотын сүмийн архибишопт томилогдсон Гунцеллиус (Guncellius) болон түүнийг тойрон хүрээлсэн язгууртан, сүмийн мяндагтнуудын зүгээс нэлээд эсэргүүцэлтэй тулгарч, үүссэн маргааныг хоёр тал Италийн Перужиа хотод сууж асан III Онориус папд биечлэн айлтган мэдүүлж хэрэг шийтгүүлэхээс аргагүйд хүрсэн байна. Энэхүү маргаан нь яг үнэн хэрэгтээ хувь хүмүүсийн албан тушаалтай гэхээсээ илүү Дундад зууны тухайн цаг үеийн Баруун Европын эдийн засаг, нийгэм, соёлын хувьд харьцангуй хөгжсөн латин хэлт Италийн хойгийн умард-төвийн бие даасан хот-улсуудын бүтэц, шашны төвлөрсөн эрх мэдлийн үзэл санаа Зүүн Европын уламжлалт соёлд тулгуурласан сул бүтэцтэй жижиг слав хэлт нийгэмд түгэн дэлгэрэхэд үүссэн бэрхшээл, зөрчилтэй холбоотой юм.

Латин хэлт соёл, нийгмийн өөрчлөлт хөгжлийг идэр залуудаа үзэж мэдэрч, латин хэл, төрийн болон шашны хууль эрх зүйд боловсрон үзэл бодол нь төлөвшсөн Томас бээр шашны эрх мэдэл бүхий албанд томилогдсон даруй Далмацийн Спалато хотын дотоодод ужгирсан хямрал, эмх замбараагүй байдлыг тогтворжуулахын тулд тус хотын улс төр, олон нийтийн амьдралд идэвхитэй оролцох болжээ. Үүний нэг жишээ бол латин хотуудын засаглалын загварыг Спалато хотод нэвтрүүлэн турших гэсэн түүний санаачлага, хичээл зүтгэл байв.

13. Томас энэ үеийн тухай өөрийн бүтээлд дурсан бичсэнгүй, харин Спалато хотын тухайн үеийн хуулийн баримт бичгүүдээс Томасын үйлдсэн бичиг баримтууд ганц хоёрхон төдий үлдэж хоцорсныг Хорватын эрдэмтэд судлан бичжээ: Šegvić, n. 1, 29; Selem, Alessandro. *Tommaso Arcidiacono e la storia medioevale di Spalato*, Zara: Tipografia E. de Schönfeld, 1933, 51; Mirjana, ns. 22-23, 255-256.

14. Архидиакон бол Католик христийн шашны сүмд архибишопын доорх зэрэг юм.

Тухайн үед шашны үзэл санаагаа түгээн дэлгэрүүлэхээр Спалато хотод ирээд байсан францискан ёсны санваартнуудын тусламжтайгээр Томас хотын иргэд, дээд эрх мэдэлтнүүдийг ятгаж харь газраас, тодруулбал Италийн хойгийн хот-улсуудаас *podestà* залж хотыг удирдуулахаар болжээ. Ингээд тухайн үеийн хууль ёсны уламжлал дагуу¹⁵ хотын удирдлагаас албан ёсны зөвшөөрлийг авч Адриатын тэнгисийн эсрэг эрэгт байрлах Анкона хотыг зорин, тэндэхийн *podestà* болон францескан ламын зөвлөснөөр тохирох хүнийг хайсаар Гаргано дэ Аршендис (Gargano de Arscendis) хэмээгчийг олж урьсан байна. Гаргано дэ Аршендис 1239 оны 5-р сард Спалато хотод ирж Италийн хот улсуудын загвараар хотын захиргааг зохион байгуулж, хотын хямрал, зөрчлийг тохинуулах арга хэмжээ авч эхэлсэн байна. Үнэндээ энэ нь хорватуудын дунд анх удаа латин нийгмийн бүтэц түгэн дэлгэрсэн явдал байсан бөгөөд энэ түүхэн үйл явдлыг гардан зохион байгуулсан хүний хувьд архидиакон Томас өөрийн тэмдэглэлдээ үүнийг тайлбарлахын тулд хэд хэдэн бүлгийг зориулсан байдаг.¹⁶ Хэдийгээр Монголчуудын довтолгоо Томасын зорьсон энэ үйл хэргийг тасалдуулсан ч Гаргано дэ Аршендис гурван жил 1242 оныг дуустал Спалато хотыг улиран захирч чадсан ажээ.

Томасын тэмдэглэлийн түүний өөрийн биечлэн оролцсон үйл явдлуудын тухай бичвэрээс түүний хувь хүний зан чанар, үзэл баримтлалыг тоймлон тодорхойлж болохоор байна. Юуны түрүүнд Томас бол христийн шашны гүн бат итгэл үнэмшилтэй, тиймээс папын тэргүүлэх ромын христийн шашны үзэл санааг хатуу тууштай баримтлагч, сүмийн үйл хэрэгт үнэнчээр зүтгэгч хүн байсныг дурдах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл сүмийн хэрэг явдлыг шашны хуулийн тогтсон ёсноос гадуур, папын тогтоосон шашны засаглалыг зөрчин буруу явуулах юм уу сүмийн хэрэг явдалд төрийн зүгээс хөндлөнгөөс оролцож буй хэн бүхнийг, эсвэл ямар нэг байдлаар шашин сүмийн үйл хэргийг тасалдуулагч, эвдлэн бусниулагч аливаа хүчин зүйлийг тэвчиж чаддаггүй, үзэн яддаг нэгэн байсан ажээ. Монголчууд уг Унгар, Хорват, түүний гол төвүүдийн нэг болох Спалатог довтлон эзэлж, орхин явсны дараа тэрээр төрөлхи Спалато хотын сүмийн архиепископ зэрэгт дэвшин бууж, IV Иннокент, IV Александр папуудын түүнд даалгасан үүргийн дагуу орон нутгийн түвэгтэй асуудлуудыг амжилттай шийтгэн шүүж шашны хэрэгт насан өөд болтлоо үнэнчээр зүтгэсээр байв. Нөгөө талаар тэрээр Унгарын хааны Далмаци, Хорват дахь ноёрхлыг шүүмжлэлтэйгээр үнэлэн цэгнэдэг хүн байсан нь *Historia Salonitana-*

15. Marasco, G. "Tommaso da Spalato: storiografo e uomo di stato," in *Renovatio* 4/1, 1969, 118;

16. Sweeney/HS, chs. 26-35, 166-252; Racki/HS, chs. 26-35, 92-132.

аас тодорхой мэдэгддэг. Судлаачдын тайлбарлаж байгаагаар, энэ нь Спалато зэрэг Далмацийн хотуудыг христийн шашны үзэл санаа бүхий бие даасан чөлөөт хот-улсын жишгээр удирдан зохион байгуулахын төлөө олон нийтийн үйл ажиллагаанд идэвхитэй оролцож байсантай нь Унгарын хааны эл бүс нутгийг уламжлалт засаглалын дагуу эрхэндээ байлган ноёлох гэсэн бодлого илт зөрчилдөж байснаас шалтгаантай байж болно.¹⁷ Юутай ч Унгарын уламжлалт XII зууны эхэн үед Хорват, Далмаци Унгаруудад эзлэгдсэн үе, мөн монголчууд довтлон дайрсан, үүний дараах үеийн Хорватын хотуудын хоорондох дотоодын хямрал, Спалато болон Унгарын хоорондох зөрчил хагаралын тухай тэрээр тайлбарлан бичихдээ гол буруутанг Унгарын эрхэм дээдэс мөн болохыг нуулгүй илэрхийлжээ.

Томас 1268 оны 5-р сарын 8-нд Спалато хотод өөд болсон. Түүний оршуулга эдүгээ төрөлх хотынх нь францискан ёсны сүмд хадгалагдаж байгаа ба бичсэн тэмдэглэл, нотариатчаар ажиллаж байх үед үйлдсэн цөөн хэдэн хууль эрхзүйн баримт, оршуулгын чулуун дээрхи латин бичээсээс¹⁸ өөр түүнийг хэн байсныг гэрчлэх дурсгал өнөө үлдэж хоцорч чадсангүй.

Historia Salonitana*-гийн гар бичмэл, хуулбар эх. *Historia Salonitana сурвалжийн мэдэгдэж буй эхүүдийг судлаачид том (*maior*), бага (*minor*) хоёр хэсэг болгон бүлэглэдэг. *Historia Salonitana Maior* бүлэг эхүүд нь бүрэн бус, хэсэгчилсэн агуулгатайн дээр он цагийн хувьд нэлээд хожуу XVI зуунаас наашхи үед холбогдох тул судалгааны үнэ цэнэ багатай. Харин *Historia Salonitana Minor* бүлэг нийт 11 эхээс бүрдэж, эдгээрээс үндсэн дөрвөн янзын гар бичмэл дундад зууны үед холбогдож байна.

1880-1890-ээд оны үед олдсон гэх хамгийн эртнийхд тооцогдож буй гар бичмэл нь элдэж боловсруулсан малын арьсан дээр дундад зууны үед Адриатийн тэнгисийн баруун, зүүн эргээр дэлгэрч түгсэн үсгийн хэв маягийн нэг болох беневертан (*beneventan*) хэлбэрээр дармалдаж бичсэн гар бичмэл юм. Энэ эх эдүгээ Спалато хотын кафедрал сүмийн архивт MS/KAS Nr.623 В дансны дугаартай хадгалагдаж байна. Уг гар бичмэлийг нарийвчлан шинжилсэн эрдэмтдийн тодорхойлолтод уг бичвэрийн ерөнхий гадаад байдлаас үзвэл Далмацийн Спалато болон түүний ойролцоох бүс нутгаас олдсон христийн шашны судар бичгүүдэд нийтлэг ажиглагддаг палеографийн шинжтэй, тиймээс Спалато хотод үйлдэгдсэн болохыг онцлон тэмдэглэсэн (Зураг 1-ийг

17. Šegvić, 50; Mirjana, 258.

18. Šegvić, 68, 98 (Tav. VIII); Mirjana, 252-253.

үзнэ үү).¹⁹ Зарим эрдэмтэд энэ гар бичмэлийг Томас архидиакон өөрийн гараар бичсэн байх өндөр магадлалтай хэмээн дүгнэсэн.²⁰ Гэвч уг эхийн эхний болон төгсгөлийн хуудас үрэгдсэн тул уг эх чухам хэний гараар хэзээ, хаана бичигдсэн, яг ямар нэртэй байсныг шууд мэдэх аргагүй. Ямартаа ч энэ гар бичмэл Томасыг амьд байх цаг үе болох 13-р зууны хоёрдугаар хагаст үйлдэгдсэн гэдэгт эрдэмтэд санал нэг байх агаад уг эхийг “Codex Spalatensis” нэрээр буюу “S” эх хэмээн тэмдэглэдэг. Дэвтэрлэж хэвлэгдсэн уг эх нь 49 бүлэгт хуваагдсан. Эхний хуудас зэрэг арав гаруй хуудас үрэгдсэний зэрэгцээ зарим хуудсууд дээр XIV-XVII зуунд холбогдох нэмэлт тайлбарууд бичигдсэн байдаг. Европын дундад зууны бичгийн ёсны дагуу төгсгөлийн үгс үйлдээгүй байх тул судлаачид зохиогч тэмдэглэлээ нэг мөр дуусгаагүй хэмээн үздэг ажээ. Харин хамгийн сүүлийн хуудасны эцэст хорватын язгууртнууд Унгарын хаанд дагаар орсон гэрээний хувилбар бичвэр бичсэн байдаг. Мөн бүлгүүдийн эхэлсэн бичвэрийн эхний үсгийг улаан бэхээр томоор үйлдсэн. Бусад үгсийг ерөнхийдөө хүрэн өнгийн бэхээр, гэвч зарим тохиолдолд улаан, ногоон, хөх, шар, алтан шар, хүрэн өнгийн бэхээр хослуулан бичсэн байдаг аж.

Болонийн гот үсгээр дармалдаж үйлдэгдсэн “S” эхийн хуулбар эх эдүгээ Будапешт хотод Шжэчэнийн нэрэмжит Үндэсний Номын Санд (National Széchényi Library) Cod Lat. Nr.440 дансны дугаартай “Codex Traguriensis” нэрээр хадгалагдаж байгаа ба энэ нь сайн хадгалагдаж үлдэж чадсан зурагт эх юм. Анх Трогир хотын язгууртан айлын гэрийн номын сангаас олдсон тул Трогирын эх хэмээн нэрлэгдсэн ба “T” эх хэмээн ялган тэмдэглэгдэнэ. Он цагийн хувьд 1380-аад оны сүүлээс XV зууны хооронд хэвлэгдсэнд тооцогдож Унгарын вангууд болон Спалато хотын түүхэнд холбогдох түүхэн баримт бичгийн хувилбартай хамт хэвлэгдсэн байдаг ажээ.

Ватиканы номын санд (Biblioteca Apostolica Vaticana) нийт гурван хуулбар гар бичмэл хадгалагдаж байгаагаас MS Vat. Lat. Nr.7019 дансны дугаартай гот хэлбэрээр бичсэн бичмэл эх (Codex Vaticanus) нь бусдаасаа хамгийн эртнийхд тооцогдох ба нийт байгаа гар бичмэлүүдээс хамгийн урт 51 бүлэгтэй (20, 35 дахь бүлгүүдийг хоёр

19. “Il carattere locale del contenuto, unitamente all’aspetto generale del testo, indica Spalato come luogo d’origine. Il codice accoglie alcune caratteristiche paleografiche apparentemente comuni alla regione in generale, dato che si ritrovano anche nell’Evangeliario e nell’Epistolario di Traù” (Brown, Virginia. “Tommaso Arcidiacono. Historia Salonitana,” in *Tesori della Croazia restaurati da Venetian Heritage Inc.*, Venice: Edizioni Multigraf, 2001, 166-167).

20. Brown, 166-167; Sweeney/HS, xv; Mirjana, 267; Хорватын түүхч Кэрубин Сэгвич уг эхийг Томас өөрийн гараар бичсэнд огт эргэлзээгүй (Šegvić, 1).

хэсэгт салгаж бүлэглэсэн). Энэ эхийг “V” хэмээн тэмдэглэдэг бөгөөд XIV зууны хоёрдугаар хагаст “S” эхээс хуулсан болох нь мэдэгджээ. Бусад хоёр хуулбар эхийн Vat. Lat.6958 дугаартай нь XVII зууны үед хуулбарлагдсан, тус номын санд хорватын орчин үеийн түүх бичлэгийн эцэг хэмээгддэг Иоханнес Лучиус (Iohannes Lucius, 1604-1679) хандивласан ажээ. Нөгөө Urb. Lat.910 дугаартай нь XVII юм уу XVIII зуунд үйлдэгдсэн бичмэл хуулбар юм.

Загребийн Их сургуулийн номын санд MS R 3311 дансны дугаартай хадгалагдаж буй гар бичмэл нь хоёр өөр хүнээр XV, XVII зуунд хуулбарлагдсан байдаг. Эрдэмтэд “Z” нэртэй энэ бичмэлийг Спалато хотын кафедрал сүмийн архивт хадгалагдаж буй эхийн хуулбар эх гэж үздэг. Түүхбичлэгийн хувьд дээрх дөрвөөс харьцангуй бага үнэ цэнэтэй боловч дундад зууны сүүл үе XV зуунд холбогдох “M” нэртэй бас нэг өөр хуулбар Cl.IX, cod.LXXV, MSS latini 3290 дансны дугаартай Италийн Венеци хотын Үндэсний Марчиана номын санд (Biblioteca Nazionale Marciana) хадгалагдаж буй болно.

Хорватын Томас архидаконы тэмдэглэлийн хамгийн түгэж дэлгэрсэн дээр дурдсан эхний дөрвөн гар бичмэл ерөнхийдөө Адриатын тэнгисийн зүүн, баруун эргийн бүс нутгуудаас олдсоныг тэмдэглүүштэй.

Historia Salonitana-гийн хэвлэл, орчуулга. Иоханнес Лучиус V эх болон өөр нэг эдүгээ үлдэж хоцроогүй V, T эхүүдээс хуулсан гар бичмэлийг баримтлан нэгэн хувилбарыг үйлдэж 1666 онд Амстердам хотноо *De regno Dalmitae et Croatiae libri sex* номондоо оруулан хэвлэсэн.²¹ Дараа нь энэ хэвлэлийг бага зэрэг үсгийн алдааг бага зэрэг засварлан хуулж 1748 онд Вена хотноо И.Г.Швандтнер (Johann Georg Schwandtner) *Scriptores rerum Hungaricarum, Dalmaticarum, Croaticarum et Slavonicarum* нэрт цувралын 3 дахь ботид хэвлэжээ.²² Хожим нь энэ нь бүрэн бус байдлаар XVIII, XIX зуунд хэд хэдэн удаа хэвлэгдэж байсан байна. Эдгээр нь Даниелэ Фарлати *Illyricum Sacrum* найман боть цувралын тавдугаар ботид Венеци хотноо 1772 онд²³, удаах нь Рома болон Парист 1866, 1867 онд *Acta sanctorum* цувралд багтан

21. Lucius, Iohannes. *De regno Dalmatiae et Croatiae libri sex*, Amsterdam: Blaeu, 1666, 310-370.

22. Schwandtner, J. G. *Scriptores rerum Hungaricum, Dalmaticarum, Croaticarum et Slavonicarum*, Vol. 3, Lipsiae, 1746, 532-635.

23. Farlati, Daniele. *Illyricum sacrum*, Vol. 3, Venetiis: apud Sebastianum Coleti 1765. Энэ хэвлэл нь *Historia Salonitana Maior*-т үндэслэгдсэн.

хэвлэгджээ.²⁴ Мөн 1892 онд Германы Ханофер хотноо Лотар фон Хайнэманн (Lothar von Heinemann) V эхэд тулгуурлан Монголчуудын тухай хэсэгчилэн *Monumenta Germaniae Historica* цувралын *Scriptores* хэсгийн 29 дэхь ботид²⁵ хэвлэсэн байдаг. XX зуунаас өмнө хэвлэгдсэн эдгээр эхүүд бүгд V эхэд тулгуурласнаараа онцлог юм.

Харин XIX зууны сүүлээр Ф.Рачки S эхийг голлон баримталж T, V, Z эхүүдийг харгуулж эмхтгээд өөрийн гэсэн тайлбартай сэргээлтийг бэлдэн гаргахаар завдаж байсан боловч амьд ахуйдаа хэвлүүлж чадаагүй ажээ. Энэ чухал шүүмжлэлт судалгааг хожим нь Загребын Өмнөд Славын Судалгааны Академи гэгч эрдэм шинжилгээний байгууллага 1894 онд *Monumenta Spectantia Historiam Slavorum Meridionalium* цувралын 26 дахь ботид тус тус хэвлүүлсэн нь эрдэм шинжилгээний эргэлтэд нэлээд орсон юм.²⁶ Энэ судалгааг эрж олохуйд нэн бэрхтэй болсныг харгалзан Италийн Венеци хотод орших Società Dalmata di Storia Patria нийгэмлэгийн эрдэм шинжилгээний цувралын тусгай дугаарт анхны байдлаар нь 1988 онд ахин нийтэлсэн буй.²⁷ Харин 10-аад жилийн өмнө 2003 онд хорват түүхчид төрөлх хэлээрээ шинэ шүүмжлэлт судалгааг үйлдэн хорват хэлээр орчуулж анх удаа S эхийн гэрэл зурагтай хамт 2 ботиор хэвлэн гаргасан нь судалгаа шинжилгээнд нэн тустай ажил болжээ.²⁸ Ерөнхийдөө XIII зуунд бичигдсэн энэхүү *Historia Salonitana* хэмээх сурвалж бичиг нэлээд хожуу буюу бичигдсэнээсээ хойш олон зуун жилийн дараа олон нийтийн анхааралд өртөж судлагдан орчуулагдах болсон байна.

24. “April 11: De Sanctis Martyribus Dalmatis,” in *Acta sanctorum quotquot toto orbe coluntur, vel a catholicis scriptoribus celebrantur*, vol. 11, Parisiis et Romae: apud Victorem Palme bibliopolam 1866; “August 4: Sanctus Raynerius,” in *Acta sanctorum quotquot toto orbe coluntur, vel a catholicis scriptoribus celebrantur*, vol. 35, editio novissima, Parisiis et Romae: apud Victorem Palme bibliopolam 1866. Эдгээрт Лучиусийн хэвлэлээс христийн итгэлд үнэнчээр амиа золигч далмаци хүмүүсийн тухай хэсэг, гэгээн Райнерийн тухай хэсгийг түүвэрлэн нийтэлсэн ажээ.

25. Thomas Spalatensis. *Ex Thomae historia pontificum Salonitarum et Spalatinorum*, edidit L. de Heinemann, Hannoverae, 1892, 568-598. Энэ хэвлэлд монголчуудын довтолгооны тухай 36-39 дэхь бүлэг, мөн 16-35, 40-49 дэхь бүлгээс түүвэрлэн нийтэлсэн.

26. Racki/HS.

27. Thomae Archidiaconi Spalatensis. *Historia Salonitanorum pontificum atque Spalatensium a S.Domnio usque ad Rogerium (1266)*, in *Atti e memorie della Società Dalmata di Storia patria*, Supplemento al Volume 16, Padova: Società Cooperativa Tipografica 1988.

28. Toma Arhidakon. *Historia Salonitana: povijest salonitanskih i splitskih prvosvećenika Thomae Archidiaconi Historia Salonitanorum atque Spalarinorum pontificum*, ed. by Olga Perić et al, Vols. 2, Split: Književni krug 2003.

Уг түүхэн сурвалжийн дээр дурдсан латин эхүүд миний мэдсэнээр итали, унгар, серби-хорват (хуучнаар югослав), герман, орос, англи, мажар хэлээр орчуулагдсан байна. Хэсэгчилсэн байдлаар хамгийн анх итали хэлээр 1843 онд Венеци хотод орчуулагдаж байжээ.²⁹ Харин хамгийн анхны бүрэн орчуулгуудыг 19-р зууны сүүлээр орос хэлээр³⁰, дараа нь бараг зуун жилийн дараа Италийн эрдэмтэн П.Фонтана (P. Fontana) Рачкийн дээр дурдсан хэвлэлд тулгуурлан итали хэлээр үйлдсэн байх агаад энэ орчуулгаа *Archivio storico per la Dalmazia* сэтгүүлийн 1939-1940 оны дугааруудад цувралаар нийтлүүлсэн.³¹ П. Фонтана итали орчуулгыг тус сэтгүүлд нийтлэхдээ Томасын товч намтрыг бичиж хавсаргасан байх агаад харин орчуулгад ямар нэг тайлбар сэлт хийгээгүй байна.

Уг сурвалж герман хэлнээ бүрэн орчуулагдаагүй, зөвхөн монголчуудтай холбогдох дөрвөн бүлгийг америкийн эрдэмтэн Жэймс Росс Свийнэй, германы эрдэмтэн Ханс Герд Гөкэняан нар орчуулан тайлбарын хамт 1985 онд *Der Mongolensturm: Berichte von Augenzeugen und Zeitgenossen, 1235-1250* хэмээх XIII зууны монголчуудын Европ дахь аян дайны эхэн үед холбогдох сурвалжуудын орчуулгуудын эмхэтгэлд багтаан нийтэлжээ.³² Монголчуудын XIV зуунд баруун Европын христийн шашинт ертөнцөд хийсэн аян дайн болоод тухайн үеийн Зүүн Европын ард түмнүүдийн түүхийн тухай сонирхон судалдаг нэн ялангуяа Европ, Америкийн эрдэмтэд энэ бүтээл хэвлэгдэн гарснаас хойш олон жилийн турш өөрсдийн эрдэм шинжилгээний ажилд ашиглаж байсан билээ.³³ Жэймс Росс Свийнэй 2003 онд хорватын

29. Thomas, Spalatensis. *Notizie di Salona antica citta della Dalmazia estratte dalla "Cronaca Latina" inedita di Tommaso arcidiacono della Chiesa di Spalato che fioriva nel 1266*, Venezia: Alvisopoli 1843

30. Krasovskii, A. "Istoriia salonskikh i spletskikh episkopov Fomi arkhidiakona Splitskogo," in *Trudi Kievskoi dukhovnoi akademii*, Kiev, t. 3, 1876, 557-622; t. 4, 73-117; t. 5, 703-747; t. 1, 1877, 504-549; Үүнээс 120-оод жилийн дараа 1997 онд орос хэлээр Ольга А. Акимова Рачкийн хэвлэлийн шүүмжлэлт эхэд тулгуурлан ахин орос хэлнээ хөрвүүлэн хэвлэсэн (Foma Splitskij. *Istoriia arkhiepiskopov Saloni i Splita*, ed. by Olga A. Akimova, Moscow: Institut slavianovedeniia i balkanistiki 1997).

31. Fontana, P. "Tommaso Arcidiacono di Spalato: Storia dei vescovi salonitani e spalatini," in *Archivio Storico per la Dalmazia* 27, 1939; 28, 1939; 29, 1940.

32. *Der Mongolensturm: Berichte von Augenzeugen und Zeitgenossen, 1235-1250*, übersetzt, eingeleitet und erläutert von Hansgerd Göckenjan und James R. Sweeney, Styria: Graz, Wien und Köln 1985 (үүнээс хойш *Mongolensturm*). П.Фонтанагийн итали орчуулга Свийнэйн үйлдсэн герман, англи эхүүдийг бодвол илүү утгачилсан орчуулга болно. Өөрөөр хэлбэл зарим латин үг, өгүүлбэрийг итали, герман, англи орчуулгуудад ялгаа зөрүүтэй ойлгож хөрвүүлсэн байдаг.

33. *A tatárjárás emlékezete*, ed. by Katona Tamás, Budapest: Európa Könyvkiadó, 1987, 211-239; Klopprogge, Axel. *Ursprung und Ausprägung des abendländischen Mongolenbildes im 13. Jahrhundert: ein Versuch zur Ideengeschichte des Mittelalters*,

судлаачдын бэлтгэж хэвлүүлсэн анхны, найдвартай эхэд тулгуурлан англи хэлээр бүрэн хэмжээний хадмал орчуулгыг 2006 онд хэвлүүлсэн.³⁴ Энэ эрдэм шинжилгээний ажил эдүгээ олон улсын судлаачдын барьдаг гол хэвлэл болсон байна.

***Historia Salonitana*-гийн Монголын түүхтэй холбогдох хэсгийн судалгааны байдлын тойм.** Уг түүхэн сурвалжийн Монголын түүхтэй холбогдох мэдээ сэлтийг Европын дундад зууны түүхбичлэгт ашигласан тухайд өгүүлбэл Спалато хотын цөөн түүхчдээс гадна XIV зуунд Италийн Венеци хотын түүхч Андрэа Дандоло (Andrea Dandolo, 1306-1354) Венецийн он дараалалын түүхээ бичихдээ IV Бела вангийн Унгараас Далмаци руу зугтсан, түүнийг монголчууд мөшгин хөөсөн тухай, вангийн Клисс, Трогир цайзд хоргодсон тухай Томасын тэмдэглэлээс шууд авч ашигласан нь мэдэгддэг.³⁵ Түүнээс хойш XIV, XV зуунд Ватикан зэрэг газруудад хуулбар үйлдэгдэж байснаас дүгнэвэл Личиусийн хэвлэл нийтлэгдэх хүртэл энэ сурвалж зөвхөн Адриатын тэнгисийн эргийн баруун, зүүн нутгуудаас нэг их халилгүй түгэн дэлгэрч байсан бололтой байдаг. Ер нь уг түүхбичлэгийн бүтээл анх XIII зуунд зохиогдсноосоо хойш XIX зууны дунд үе хүртэл дан ганц латин хэлээр л тархаж байсан тул нийт олонд харьцангуй бага танигдахад нь нөлөөлсөн байх. Тиймээс Монголын эзэнт гүрний үед монголчуудын аян дайн, ахуй амьдралыг нүдээр үзэж харсан латин хэлт христийн шашинт ертөнцийн гэрчүүдийн үлдээсэн адил төстэй сурвалжуудтай харьцуулбал латин хэлээр бичигдсэн эл сурвалжийн судалгаа нэлээд хожуу хийгдсэн юм. Анх бичигдснээс нь хойш 400 жилийн дараа V хуулбар эхийг үндэслэн үйлдсэн Личиусын хэвлэл уг сурвалж Европт даяар танигдахад гол хувь нэмэр үзүүлсэн, түүнээс хойш XIX зууны дунд үеэс л сая түүхчид уг сурвалжийг судлан Европын янз бүрийн хэлээр орчуулж эхэлсэнийг дээр өгүүлсэн. XIX зууны дунд үе бол Европт түүх шинжлэх ухаан, сурвалжийн

Harrassowitz Verlag, Wiesbaden 1993; Róna-tas, András. *Hungarians and Europe in the Early Middle Ages: An Introduction to Early Hungarian History*, Budapest: Central European University Press 1999; Routsala, Antti, *Europeans and Mongols in the Middle of the Thirteenth Century: Encountering the Other*, The Finnish Academy of Science and Letters: Helsinki 2001; Balázs, Nagy. *Tatárjárás*, Budapest: Osiris Kiadó, 2003, 52-65 гэх мэт. Ер нь 1940 онд итали хэлнээ бүрэн хэмжээгээр орчуулсан П.Фонтанагийн орчуулгыг эс тооцвол түүний герман тайлбартай орчуулга олон жилийн турш монголын түүхийг судлагч гагц германаар зогсохгүй олон улсын эрдэмтэн судлаачдын уг сурвалжтай танилцах гүүр болж байсан ажгуу.

34. Sweeney/HS.

35. *Andreae Danduli ducis Venetiarum Chronica per extensum descripta: aa. 46-1280 d.C.*, in L. A. Muratori (a cura di). *Raccolta degli storici italiani dal Cinquecento al Millecinquecento*, vol. 12/1, Bologna: N. Zanichelli, 1938-1958.

шүүмжлэлт судалгаа үүсэн боловсорч үндэстэн-улсын ухамсар өнгө төрхөө олж байсан үзэгдэл тархсан цаг байсан билээ. Тодруулал Австри-Унгарын хаант улс бүрэлдэн бий болж үүнд хорват үндэстэн нэгдэх тухай асуудал тавигдах үед Хорватын Унгарт нэгдсэн үеийн тухай өгүүлсэн хуучин түүхэн сурвалжуудыг эрж олох, тэдгээрт шүүмжлэлт задлан шинжилгээ хийсний үндсэн дээр үндэслэл, нотолгоо бүхий улс төрийн асуудал дэвшүүлэх боломжийг олох шаардлага орон нутгийн түүхчдэд тулгарсан ажээ. Чухам ийм шалтгаанаар дундад зууны Хорват-Унгарын харилцааны тухай нэн чухаг сурвалж болохынх нь хувьд *Historia Salonitana*-ийг сонирхон судлах оролдлогууд гарч эхэлсэн байна. *Historia Salonitana*-гийн шүүмжлэлт задлан шинжилгээг орон нутгийн түүхчдээс санаачилан анхлан хийсэн нь (Рачкийн 1894 оны судалгаа) энэ үүднээс тохиолдлын бус хэрэг байсан гэж хэлж болно. Хэдийгээр Рачки, Сэгвич, Сэлем зэрэг хорват үндэстний түүхчдийн судалгаанд тулгуурлан Монголчуудын аян дайны талаар мэдэхийг хүссэн ялангуяа итали, герман, оросын олон нэрт эрдэмтэд зохих хувь нэмрээ оруулсан боловч яг монголчуудын түүхтэй холбогдуулан тухайн үеийн бусад сурвалж бичгүүдтэй харьцуулан нарийн тодорхой задлан шинжилсэн судалгааг 1974 онд германы түүхч Жиан Андри Беццола³⁶ гаргасан юм. Беццолагаас хойш Аксел Клоппроже, Шмийдер Феличитас нарын нэгэн сэдэвт зохиолуудад тус сурвалжийг тухайн үеийн латин хэлнээ бичигдсэн бусад сурвалж баримтуудтай харьцуулан шинжилж монголчуудын Христийн шашинт улсуудад хийсэн аян дайны үйл явц, түүх бичлэгийн хүрээнд зохих үнэлэлт дүгнэлтүүдийг хийжээ.³⁷ Гэвч 1985 онд судлаач Жэймс Росс Свийнэй уг сурвалжийг орчуулахаас өмнө герман хэлт уншигчид энэ эх сурвалжтай төрөлх хэлээрээ танилцах боломжгүй байсан юм.

Эрдэмтэн Свийнэй орчуулахын зэрэгцээ уг латин сурвалжид тулгуурлан Монгол, Унгарын харилцааг авч үзсэн эрдэм шинжилгээний дорвитой дүгнэлт хийсэн өгүүлэлүүдийг бичсэн.³⁸ Свийнэйн Олга Перич, Миряна Матиевич Сокол зэрэг хорватын эрдэмтэдтэй хамтран

36. Bezzola, Gian Andri. *Die Mongolen in abendlandischer Sicht (1220-1270): ein Beitrag zur Frage der Volkerbegegnungen*, Francke Verlag: Bern and München 1974.

37. Kloppe, Axel. *Ursprung und Ausprägung des abendländischen Mongolenbildes im 13. Jahrhundert: ein Versuch zur Ideengeschichte des Mittelalters*, Wiesbaden: Harrassowitz Verlag 1993; Schmieder, Felicitas. *Europa und die Fremden: Die Mongolen im Urteil des Abendlandes vom 13. bis in das 15. Jahrhundert*, Sigmaringen: Thorbecke 1994.

38. Sweeney, J.R. "Thomas of Spalato and the Mongols: A Thirteenth-Century Dalmatian View of Mongol Customs," in *Florilegium* 4, 1982, 156-183; Sweeney, J.R. "Spurred on by the Fear of Death": Refugees and Displaced Populations during the Mongol Invasion of Hungary," in *Toronto Studies in Central and Inner Asia* 1, 1994, 34-62.

2006 онд туурвисан эрдэм шинжилгээний ажил Томасын сурвалжид оруулсан хамгийн сүүлийн бөгөөд хамгийн жинтэй хувь нэмэр болж байна.

Монголын түүхийн судалгааны хувьд энэ сурвалжийн хувьд, ерөөс XIII зуунд Монголчуудын Европтой харилцсан харилцааг түүхэн эх сурвалж бичгүүдэд тулгуурлан шүүмжлэлтэйгээр судлах явдал өнөө хэр үгүйлэгдэж байна. XX зууныг дуустал монголчууд Бат, Сүбээдэйн Европт явуулсан аян дайны тухай эх хэлээрээ голчлон оросын эрдэмтдийн судалгааны орчуулгуудаар дамжуулан танин мэдэж байсан, харин сүүлийн арваад жил монголын судлаачдын энэ талаарх сонирхол харьцангуй ихэссэнийг оросоос өөр Европын улсуудын бусад англи, франц, герман гэх мэт хэлээрх судалгаануудыг орчуулах, Европ дахь монголчуудын цэрэг дайны үйл ажиллагааны талаар үнэлж дүгнэсэн судалгааны ажлууд, хэлэлцүүлгүүд хийгдэх болсноос ажиглагдана. Харин Томасын тэмдэглэлийн монголчуудын аян дайнтай холбогдох мэдээ сэлтийг ашигласан нь цөөн бөгөөд монголын дипломатч, түүхчдийн бичсэн Бат хааны намтруудад ашигласан байх³⁹ боловч латин эхээс зөрөөтэй ойлгогдож бичигдсэн байна. Тиймээс Монголын түүх судлаачдын хувьд эл анхдагч сурвалжийг нарийвчлан судлан шинжилж, эрдэм шинжилгээний эргэлтэд оруулах шаардлага бидэнд нэн их байна.

***Historia Salonitana*-гийн нэр, түүх бичлэгийн онцлог.**

Historia

Salonitana-гийн одоогоор мэдэгдэж буй хамгийн эртний эхийн эхний хуудас үрэгдсэн, мөн төгсгөлийн хуудсанд өмнө өгүүлснээр дундад зууны христийн шашинтнуудын латин хэлний бичгийн ёсны дагуу он цаг, зохиогчийн нэрийг дурдсан төгсгөл байдаггүй. Түүнээс хуулбарлан бичсэн дараа дараагийн хуулбар эхүүдэд ч энэ тухай магадлан тодорхойлсон нь үгүй, гагцхүү бага сага нэмэлт оруулга тайлбар хийн хуулсан байдаг.⁴⁰ Тиймээс зохиогч өөрөө сурвалжийг чухам юу гэж нэрлэсэн хийгээд яг хэдийд зохиож дуусгасныг мэдэх боломжгүй, үүнийг эрдэмтэд сурвалжийн дотор бичигдсэн үйл явдлуудын контекстэд задлан шинжилгээ хийх замаар янз бүрээр магадлан тогтоосон байна. Спалато хотын кафедрал сүмийн архивт буй бичигдэж бүрэн дуусгаагүй хэмээн үздэг тэрхүү S буюу *Codex Spalatensis* нэрээр хадгалагдаж буй эх “*incipit historia Salonitanorum atque Spalatinorum pontificum*” хэмээн эхэлдэгээс ихэвчлэн Салона, Спалато хотын

39. Жишээ нь, Чойсамба, Ч. *Бат хааны байлдан дагуулал*, Улаанбаатар: Битпресс 2006 [Түүхийг бүтээсэн хүмүүс цуврал].

40. Энэ эхийн үрэгдсэн хуудас, төгсгөлийн үгийн тухай тухай дэлгэрэнгүй хэлэлцүүлгийг Šegvić, 1-4; Sweeney/HS, xiv-xv-д үзнэ үү.

бишопуудын түүх гэсэн утга бүхий нэрийн ийм оноолтоор олонд түгж дэлгэрсэн байх ажээ. Харин Ватиканд хадгалагдаж буй V эхийг XIX зууны сүүлээр хэсэгчилэн хуулбарлаж хэвлэхдээ Лотар Фон Хайнэманн *Ex Thomae Historia pontificum Salonitanorum et Spalatinorum* хэмээн нэрлэжээ. 1894 онд хорватын эрдэмтэн Рачки архидиакон Томасын уг зохиолыг *Historia Salonitanorum pontificum, atque Spalatensium* нэрээр хэвлүүлсэн бөгөөд энэ хэвлэл хожим олон хэлнээ орчуулагдах явцад хэвээр хадгалагдаж үлдсэн бололтой. Хэдий дээрх маягаар судлаачид эл түүхэн зохиолыг хоорондоо үл ялиг зөрүүтэй нэршиж ирсэн ч ерөнхийдөө *Historia Salonitana* хэмээн товчлон нэрлэдэг байна.

Архидиакон Томасын эл түүхэн хүүрнэлээ бичих уг шалтгаан нь төрөлх нутгийн Салона хотын нийт Хорватын газар нутагт христийн шашны үйл хэргийг явуулах хууль ёсны эрхийг Спалато хотын сүм залгамжилсан түүхийг өөрийн гол чухал гэж үзсэн шашны тэргүүнүүд болон нэр нөлөө бүхий дэв зэрэгтнүүдээр төлөөлүүлэн он дарааллын дагуу бичих, түүний өнгөрсөн түүхийг алдаршуулахын зэрэгцээ орон нутгийн сүм, олон нийт, ул төрийн хэрэг явдлуудад өөрийн оролцсон байр сууриа зөвтгөн тайлбарлах явдал байсан юм. Тиймээс *Historia Salonitana* нь нэг талаар өнгөрсөн үйл явдлуудыг дүгнэсэн түүхэн шинжтэй, нөгөө талаар зохиогчийн амьдарч байсан, хамт хийж оролцож байсан тухайн цаг үеийн үйл явдлуудыг тэмдэглэсэн *дурсамж, дуртгал, өөрийн намтар* шинжтэй бичигдсэн байна.

Томас архидиакон дундад зууны Европын христийн сүм хийдийн тэргүүнүүдийн намтарт холбогдох үйл явдлуудыг он дарааллын дагуу хэлхэн шашин дэлгэрсэн түүхэн тэмдэглэлийг үйлддэг *gesta episcoporum* төрлийн түүхбичлэгийн бүтээлийг бичдэг тогтсон жаягийн дагуу тэмдэглэлээ бичсэн байх бөгөөд ийнхүү бичихдээ агуулгын хувьд гурван ерөнхий хэсэгт хувааж нэгдүгээрт, Христийн эхэн цаг үеийн Салона хотын сүм хийдийн түүхийг тухайн үеийн сүм хийдийн хутагт, эрхүүд нэрийн бүтээлийг ашиглан бичсэн (1-10 дахь бүлэг), хоёрдугаарт Спалато хотын сүм хийдийн бий болж байгуулагдсан түүхийг ихэвчлэн дипломат албан бичиг ашиглан сэргээн босгож бичсэн (11-22 дахь бүлэг), гуравдугаарт Томасын өөрийн цаг үеийн онцгой үйл явдал, дурсамж дуртгалыг аман уламжлал дээр тулгуурлан тайлагнаж бичсэн (23-49 дэхь бүлэг) байх ажээ. Ийнхүү бичихдээ тэрээр хорват, слав, унгарын улс төр, нийгмийн түүхэнд холбогдох олон чухал үйл явдлуудын тухай өөр бусад түүхэн сурвалжуудыг ашиглан бичсэн тул энэ бүс нутгийн дундад зууны түүхийн нэн чухал мэдээ сэлт бүхий бичгийн үнэт дурсгалд тооцогддог ажээ.

Зохиогч тухайн цаг үеийн хамгийн том их сургуульд латин хэл, яруу илтгэх урлаг буюу реторикт олон жил суралцсан шашны гүн бат итгэл үнэмшилтэй хүн байв. Тэрээр Библи, Севиллийн Исидор зэрэг эртний Ромын үе, дундад зууны үеийн христийн шашны агуулгатай латин хэлээрх уран зохиол, бичгийн дурсгалуудын найруулга, зүйрлэл, харьцуулал, адилтгал, ёгтлол, өвөрмөц хэллэгүүдийг аливаа үзэл санаа, итгэл үнэмшлээ илэрхийлэхдээ хүч оруулах үүднээс ахин дахин давтан хуулж бичих маягаар чадамгай ашигладаг байсан нь бүтээлээс нь, ялангуяа түүнд өгүүлэх хүүрнэлүүд дундаас монголчуудтай холбогдох хэсгээс тод ажиглагддаг юм. Тиймээс түүний талаар судалгаа хийсэн судлаачид бүгд зохиогчийн бүтээлийг *уран зохиолын хэл найруулгаар бичигдсэн түүхэн бүтээл* гэсэн дүгнэлт хийсэн байдгийг онцлон тэмдэглүүштэй.

XIII зуунд Далмаци нутаг угсаатны хувьд слав буюу хорват, унгар, латинчуудаас бүрдэж байжээ. Эдгээрээс зохиогчийн төрөлх хот Спалато хот орчмын хүн амын дээд, доод давхрагынхан ялгалгүй хорват хэлээр (*lingua vulgaris*) ярьдаг, нэлэнхүйдээ хорватын соёлтой ард түмэн байсан аж. Томасын түүхэнд гарч буй хүний нэр, газар усны нэр үүнийг батлана. Гэхдээ слав буюу хорватууд нь, Томасын өгүүлсэнчилэн, Далмацийн уугуул иргэд байгаагүй юм. Далмаци буюу “Уулсын нутаг”-т байсан уугуул хүмүүсийг ХТӨ IV зуунд грекүүд эзлэн авч колони хот-улсуудыг байгуулсан. Хожим нь Грек Ромын эзэнт гүрэнд эзлэгдэхэд эртний Ромын бүгд найрамдах улсын харъяанд шилжин орж Салона хот Далмацийн нийслэл болов. Анхны гурвалсан засаглал (*triumviratus*) эвдрэхэд Салони хот Цезарийн эсрэг Помпейн талд нэгдэж байсан бол хоёрдугаар гурвалсан засаглалын дараа Ромын эзэнт гүрний эзэмшилд багтан Далмацийн нутагт латин хэлтнүүд суурьших болсон байна. Баруун Ромын сүүлчийн эзэн хаан үгүй болсны дараа Далмаци герман гаралтай гот удирдагчдын эрхэнд орж албан гувчуурын хүнд дарамтанд орсон байна. Далмацид энэ үеэс эхлэн гот (*gothi*) хэмээх нэр “зэрлэгүүд”, “тэрсүүд” зэрэг үгсийн утгатай адил болж⁴¹, хожим нь VI зуунд тус бүс нутагт шинээр нэвтрэн орж ирсэн слав хэлтэн ард түмнүүдийг нэрлэх нэр болж хувирсан болохыг Томасын бүтээлээс тодорхой мэдэж болно.⁴² Хорват зэрэг слав хэлтнүүдийн дараагаар нүүдэлчин аварууд VII зуунаас Далмацийн нутагт нэвтрэн латин хэлтнүүдийн төв болсон Салона хотыг сүйрүүлэх үед дүрвэн зугтагсад Ромын цэргийн бэхлэлт байсан Спалатод шилжин суурьших болсноор Спалато дундад зууны эхэн үеийн хот болон хөгжсөн юм. Голчлон ортодокс христийн шашныг итгэл үнэмшлээ

41. Praga, Giuseppe. *History of Dalmatia*, Pisa: Giardini, 1993, 35-36.

42. Sweeney/HS, 35-39.

болгосон хорватууд аажим аажмаар давамгайлах болсон энэ үед ч гэсэн Спалато хотод Ромын христийн шашны нөлөөгөөр латин хэл албан ёсны буюу дипломат хэлний үүргээ гүйцэтгэсээр байлаа. XIII зуунд монголчууд тус хотод довтлох үед латин хэл нь шашны хүмүүс болон язгууртнуудаас бүрдсэн дээд давхрагынхны оюун санааны хэл байж, харин доод давхрагынхан хорват хэлээр ярьдаг байжээ. Томас өөрөө латин хэл соёлд бага наснаасаа суралцсан тул бүтээлийнхээ бүхий л хэсэгт слав буюу хорват хэл, хорватуудад таагүй хандаж бичиж байв.

Эзэмшсэн латин хэл соёлдоо Томасын эсрэгцүүлэн тавьсан өөр нэг хэл соёл бол “урьд Хүннүчүүд (*Hunni*) хэмээн нэрлэгдэж байсан, хожим нь Унгарууд (*Hungari*) гэгдэх болсон” Мажар байв:

Энэ цаг үе орчим Массажетын (*Massagetum*) улсууд Мажериа (*Mageria*) хэмээгдэх нутгаа орхин нүүж замдаа тааралдсан бүгдийг хөнөөн сүйрүүлсээр үй олноороо довтлон ирэв. Тэд Дунай мөрний хоёр эрэгт Паннониаг бүхэлд нь эзлэв. Энэ нутгийн уугуул суурьшигчдыг алж хядан үлдсэнийг нь зарц боол болгож тархай бутархай хүн амтай, ялангуяа тэдний олонх нь амь залгуулдаг мал адгуулахад тохиромжтойн тул тэр хээр талд нутагшив. Эрт цагт энэ нутаг Ромчуудын мал адгуулдаг бэлчээр нутаг байсан гэдэг. Тэгээд Массажетууд ойролцоох хавийн газруудыг байнга дайтан довтолж сүм хийдийг устган, христийн шашинтнуудыг зовоон тарчилгаж эхлэв. Учир нь тэд хамгийн хэрцгий догшин тэрсүүд номтнууд (*pagan*) байв... Тэдгээр үеүүдээс өмнө удирдагч нь (*dux*) Аттила байсан, тэрээр Христийн шашинтнуудыг хамгийн хэрцгийгээр хядан устгагч байв...⁴³

Мажарууд хэлний хувьд фин-угор гаралтай, соёлын хувьд түрэг, монголчуудтай адил нүүдэлчин байсан бөгөөд Томасын итгэж байсанчилан угсаатны хувьд өвөг дээдэс нь Хүннүчүүдтэй шууд холбоогүй, харин V зууны төгсгөлд Хүннүгийн бүрэлдэхүүнд багтаж байсан юм. IX зуунд тэд Карпацийн уулсын сав газарт нүүдэллэн ирж өөрсдийн улсыг байгуулан 1000 оны орчим христийн шашинд орж XII зууны эхэн үед Арпадын хаадын угсаа залгамжлагч Коломан Византын эзэнт гүрний нэг хэсэг болж байсан хорватуудын язгууртнуудтай гэрээ хийн улсдаа нэгтгээд өөрийгөө 1108 оноос “Унгар, Хорват, Далмацийн хаан”-аар өргөмжлөх болов. Хэдий Унгарын хаадын эрхшээлд орсон ч нийт Далмаци даяар тархан суурьшаад байсан хорватууд өөртөө эзэрхэх онцгой эрх эдэлж харьцангуй бие даасан байдалтай XIII зууныг хүргэсэн ажээ.⁴⁴ Тиймээс *Historia Salonitana*-д илэрхийлэгдсэн

43. Эхийг Sweeney/*HS*, 62-д үзнэ үү.

44. Мажаруудын угсаа гарвал, Хорват, Далмацийг эзэлсэн тухай сүүлийн үеийн судалгааны үр дүнг дараах эрдэм шинжилгээний бүтээлүүдээс үзнэ үү: Róna-tas, András. *Hungarians and Europe in the Early Middle Ages: An Introduction to Early Hungarian History*, Budapest: Central European University Press 1999; Kontler, László. *A History of Hungary: Millennium in Central Europe*, New York: Palgrave Macmillan, 2002,

зохиогчийн хандлага дийлэнх хорватуудын адил Унгарын хаадын эрх баригч хаадын бодлогыг үл таалан, Далмаци нутаг, Спалато хот монголчуудын дайралтад өртсөний гол бурууг IV Бела тэргүүтэй харь гарал бүхий унгар язгууртнуудад тохоож, унгаруудын хулчгар, аймхай занг монголчуудын хэрцгий догшин байдалтай харьцуулан улам тодотгон бичсэн байдаг. Энэ нь ялангуяа унгар ихэс дээдсүүд монголчуудын дайралтаас зугтаж латин *podestà* засаглалтай Спалато хотод ирэхэд хотынхон хүссэн ёсоор завь бэлтгэж өгөөгүй тухай өгүүлдэг 38 дахь бүлгээс бүр тод мэдэгддэг.

Монголын түүхтэй холбогдох хэсгийн бүтэц, эх сурвалж, зохиогдсон он цаг. Томасын монголчуудтай холбогдох хэсэг нь түүний бүтээлийн 36-39 дэхь бүлгийг хамрана. Өөрөөр хэлбэл монголчуудын довтолгооны тухай бүлгүүд нь Томасын тэмдэглэлийн түүний нүдээр үзэж, харсан үйл явдлуудыг өгүүлсэн гурав дахь хэсэгт хамаарч байгаа юм.

36	<i>De peste tartarorum</i>	Тартарын тахал
37	<i>De natura tartarorum</i>	Тартаруудын тухай
38	<i>De fuga hungarorum</i>	Унгарууд зугтсан тухай
39	<i>De sevitia tartarorum</i>	Тартаруудын харгислалын тухай

Historia Salonitana-гийн Монголчуудын тухай өгүүлсэн эдгээр дөрвөн бүлэг нийт зохиолын 14 орчим хувь, зохиогчийн өөрийн оролцсон үйл явдлын тухай хэсгийн 22 орчим хувийг эзэлнэ. Тиймээс эдгээр дөрвөн бүлэг *Historia Salonitana*-гийн агуулгад нэлээд чухал байр суурь эзэлдэг, зохиогчийн бичсэн гол үйл явдлуудын нэг гэж хэлж болох юм. Дурдсан дөрвөн бүлгийн үйл явдлуудын өгүүлэмж хоорондоо ерөнхийдөө он цагийн дэс дараагаар зохион байгуулагдсан. Өөрөөр хэлбэл зохиогч бүтээлээ он цагын дагуу үйл явдлууд хэрхэн өрнөсөнийг тоочин бичсэн байна. Гэвч монголчуудын дайралтыг он цагийн дагуу бичсэн энэ бүтэц нь үе үе зохиогчийн дүрслэн бичиж буй үйл явдлуудаа дүгнэсэн сэтгэлзүйн өнгө аяс бүхий тайлбаруудаар, мөн 37 дахь бүлгийн эхний хэсэгт Монголчуудын тухай өөрийн үзэж харсан, дуулж мэдсэнээ дүрслэн бичсэн хэсэгт тасалдсан байдаг. Зохиогч латин бичгийн соёл сайтар эзэмшсэн хүн байсан тул эдгээр тайлбаруудаа Библий зэрэг христийн шашны эртний судар бичгүүдэд тохиолддог шашны тогтсон хэллэгүүдийг ашиглан хүч оруулж чадварлаг бичсэн байх ажээ.

41-78; Engel, Pál. *The Realm of St. Stephen: A History of Medieval Hungary, 895-1526*, London and New York: I.B. Tauris, 2005, 1-36.

Бүлгүүдийн нэршил гар бичмэлийн эхүүдэд тогтвортой байдаг ч эхүүдийн бүлгүүдийн зохион байгуулалтаас шалтгаалан бүлгийн дугаар зөрөх явдал ажиглагдана.⁴⁵ Мөн эдгээр дөрвөн бүлгээс гадна 33 дахь *Хотын захирагч подеста Гарганогийн тухай* бүлгийн нар хиртэж гай гамшиг ёрлосон төгсгөл хэсэг, 46 дахь архбишоп Рожериогийн тухай бүлгийн Рожериогийн монголчуудад баригдсан тухай мэдээнд монголчуудын тухай цухас өгүүлдэг.

Эдгээр дөрвөн бүлгийг агуулгын хувьд янз бүрээр задлан шинжилж болно. Хронологийн дагуу үйл явдлын өрнөлийг товч хураангуйлан бичвэл:

Эхний 36 дахь бүлэг 1230-аад оны үед Монголчууд Оростой тулалдан байлдаж буй цуу яриа сонсогдож, улмаар Суздалийн ван Юрийг ялан 1241 онд намар өвлийн заагаар Унгарын вант улсын хилд ойртон ирсэн тухай мэдээ Унгаруудад хүрч муу ёрын зөгнөл татаж эхэлнэ. Энэ үед Унгарын ихэс дээдэс зугаа цэнгэл гэсээр урагшгүй хойрго хандан цаг алдсан, хэдий хуралдан чуулсан ч эвлэлдэн нэгдэж чадсангүй. Монголчуудын өвлийн хүйтэн дөнгөж цаашилмагц гэнэт дайрч хил нэвтрээд ах дүү Бат, Хайдан нарын удирдлагаар шууд гол төв хотыг чиглэн довтолж Тиза мөрний нэг салаа Саёо голын хөвөөнд стратегийн чухал байрлал сонгон буудалсан явдал монголчууд дайныг маш нарийн төлөвлөгөөтэй эхлүүлснийг илтгэдэг. Бат уулын орой дээр гаран дайны тактик боловсруулна. Шөнө нь нэгэн орос цэргийн хэл дуулгасны ачаар унгар цэргүүд монголчуудын гүүр гатлан довтолхыг мэдэж эхний дайралтыг тогтоож чадна. Гэвч үүрээр монголчууд урвуур ашиглан ахин довтолж христ ертөнцийн цэргүүдийн буудлыг хүрээлэн бүслээд улмаар монгол цэргийн түгээмэл хэрэглэдэг дайтах аргыг хэрэглэн бүслэлтийг нээж зам тавиад зугтан гарагсдийг элдэн хөөж намагт хиар цохидог. Унгарын Бела ван Австри руу зугтан, дүү Коломан нь Пест хот руу зугтана. Монголчууд Пест хотыг эзлэсний дараа Доминикан сүм хийдэд хоргодсон 10000 орчим дүрвэгсдийг түймэрдэн шатааж харгислал үйлдээд, улмаар Дунай мөрнийг гатлан Трансилваниа хүрч тэндээ 1241 оны зун, өвлийг өнгөрүүлнэ. Энэ хооронд Бела ван Австриас эргэж Хорватын Загреб хотод ирнэ.

37 дахь бүлэг хоёр хэсэгт хуваагдана. Эхний дийлэнхи хэсэг нь монголчуудын тухай дүрслэн өгүүлдэг. Зохиогчийн монголчуудын

45. 20-р зууныг хүртэл нэлээд тархаж байсан V хуулбарт эхэд тулгуурласан хэвлэлүүдэд, жишээ нь 1892 онд *Monumenta Germaniae Historica* цувралд багтсан хэвлэлд монголчуудтай холбогдох хэсэг 37-40 дэхь дөрвөн бүлгийг хамрана. Энэ өгүүлэлийн сурвалжийн гар бичмэл эхүүдийн тухай хэсгийг лавлан үзнэ үү.

тухай дүрслэл дорноос ирсэн Манголичуудын (монгол) хаан нь Чекарканус (Чингис), түүний ертөнцийг байлдан дагуулсан тухай домог, Чекарканусын хоёр хөвүүн Бат, Хадан хоёр гучин жил умардын улсыг эзлэн Орос, Унгарт ирсэн, Тартар, Татар нэрийн утга учир, монголчуудын байлдааны дийлэгдэшгүй ур чадвар, итгэл үнэмшил, дипломат харилцаа, дүр төрх, зэвсэг агсамж (arma) – хуяг (tegmen), дуулга (cassis), илд (falcatus), нум (arcus), сум (sagitta), зэв (tenus sagittarum), ховд (faretras), туг сүлд (vexillum), монгол агт морьдын онцлого, агт морьдоо гаршуулах байдал, идэш ууш, цэргийн бүрэлдэхүүн, цэргийн онцлого, тулалдааны сэтгэл зүйн шаардлага, оршуулгын ёс, гол гатлах арга, гэр сууц зэргийн талаар мэдээ сэлт өгдөг. Удаахь хоёр дахь хэсэг он цагийн дарааллыг үргэлжлүүлэн Бела ван хорватын хотуудаас тусламж хүсэж хатан, хүүхдүүдээ хоргодуулаад өөрөө ойролцоох Клисс цайзноо хорогдсон, түүний дүү Коломаннус өөд болсон тухай өгүүлдэг. Энэ хоёр хэсгийг хооронд нь монголчуудаас дэлхий дахин, тэр дундаа христийн ертөнц айн дагжиж, монголчууд бол Антихристийг ирэхээс урьтаж ирэх ёстой хүмүүс мөн тухай багахан өгүүлэмж холбодог.

38 дахь бүлэгт 1242 оны дүн өвлөөр Хаданы цэрэг ванг мөшгиж замдаа Унгар, Хорватын хэд хэдэн хотыг ээлж дараалан дайрч, заримыг нь эзлэнэ. Бела ван тэргүүтэй Унгарын ихэс ноёд тэднээс зугтан Адриатын тэнгисийн эрэгт Далмацийн Спалато хотод дайжиж ирнэ. Хотынхон вангийн хүслээр завь бэлдээгүй тул цааш илүү сайн хамгаалалт бүхий Трогир хотноо одно.

39 дэхь бүлэг Хадан Бела ван зугтсанд ихэд хилэгнэн мөшгиж тэнгист гарч зайлахаас урьтаж “нэг ч цэргийн хүч өмнө нь давж чадаагүй эзгүй ээрэм газар, эгц цавчим уулсыг... нисэх мэт дүүлж” Спалато хотод хүрч ирээд ванг байхгүйг мэдэн Клисс цайзыг нэгжин дайрна. Тэндээс вангийн мөрөөр цааш мөшгин Трогир хот руу хүрнэ. Монголчууд Трогир хотод ванг хоргодож буй хэмээн бодож хотынхноос цус урсгалгүй ванг гаргаж өгөхийг шаардав. Ванг тэнгист зайлж зугтсаныг мэдэн 1242 оны гуравдугаар сарыг Далмацийн нутагт өнгөрөөн улмаар Босни, Серб, Болгарыг дайран нутаг буцахдаа олзны хүмүүсийг сул тавин хядна. Бела ванг монголчуудыг явсанг мэдэж эргэж Далмацид ирнэ. Энэ бүлэг монголчуудын дайралтын дараа Далмацийн хүн ард өлсгөлөнд нэрвэгдэж, араатан чононд бариулсан тухай өгүүлж дуусдаг.

Дээрхээс үзвэл Томас хүүрнэлээ монголчууд Унгарын вант улсын хилд тулж ирснээр эхэлж, Унгараас гарч явж байгаагаар дуусгасан байна. Бүлгүүд хүүрнэлийн уртаар харилцан адилгүй. Хамгийн урт нь

36 дахь *Тартаруудын хөнөөлийн тухай* бүлэг байх агаад хамгийн богино нь *Унгарын вангийн зугтсан тухай* 38 дахь бүлэг байна. Хэдий хүүрнэлийн урт богино судалгаанд ач холбогдолгүй мэт байж болох ч зохиогчийн мэдээлэлтэй байдлыг, эсвэл хүүрнэлийн бүрэн эсэхийг үнэлэн тодорхойлоход тус нэмэр болж болох юм. Гэвч миний бодлоор 36, 38 дахь бүлгүүд хүүрнэлийн хэмжээгээр эсрэгээр байх ёстой мэт санагдана. Өөрөөр хэлбэл зохиогчийн хамгийн муу мэдэх, нүдээр үзэж хараагүй үйл явдлууд хамгийн урт 36 дахь бүлэгт өрнөх бөгөөд эсрэгээр зохиогчийн хамгийн сайн мэдэж байх, нүдээр үзэж харсан үйл явдлууд хамгийн богино 38 дахь бүлэгт өрнөдөг. 38 дахь бүлгийн өгүүлэмжид дурдснаар Унгарын ихэс дээдсүүд Спалато хотод ирэхэд Томас архидиакон байж, Унгарын ванг хотын латин засаг даргач нар хүлээж авсан үйл явдлыг нүдээр үзэж харсан байх учиртай, тиймээс энэ бүлгийг маш дэлгэрэнгүй бичиж болох байсан. Гэвч энэ бүлэг бол нийт дөрвөн бүлгээс хамгийн богино. Үүний учрыг дараах байдлаар тайлбарлаж болох юм. Нэгдүгээрт, энэ нь зохиогчийн латин боловсрол хүмүүжилтэй, түүнийгээ хорват, унгар соёл, нийтлэгээс дээгүүр тавьж үздэг байсантай холбоотой. Хоёрдугаарт, Томасын биечлэн оролцож байгуулсан латин засаглалын төлөөлөгчид монголчуудын довтолгооны хамаг бурууг Унгарын ихэс дээдэст оноон, ерөөс Унгаруудад таагүй ханддаг байсантай холбоотой юм. Иймд 38 дахь бүлгийн Унгарын вангийн зугтсан тухай өгүүлсэн нь үнэн хэрэгтээ ван Спалато хотод ирээд хорогдолгүй цааш зугтсан тухай өгүүлсэн хэрэг болно.

Historia Salonitana-гийн монголчуудтай холбогдох хэсгийг зохиогч ямар эх сурвалж дээр тулгуурлан бичив? Энэхүү түүхэн хүүрнэл, дуртгал тэмдэглэлийн монголчуудын хэсэгт хамаарах бүлгүүдийн баримтын эх сурвалж нь үндсэндээ аман уламжлал байв. Нэг талаар зохиогч өөрөө тухайн үйл явдлуудыг өрнөж буй цаг үед идэвхитэй амьдарч байсан тул нүдээр үзэж харсанаа тэмдэглэн бичсэн, нөгөө талаар тэдгээр үйл явдалд оролцсон гэрчүүдийн буюу монголчуудын дайралтад өртөн амьд үлдсэн, зугтаж дүрвэсэн хүмүүсийн ам дамжин түгсэн ярианаас сонсож дуулсанаа тэмдэглэн тайлагнасан байна. Үүнд 36 дахь бүлэгт бичигдсэн үйл явдлуудад зохиогч биеэр оролцоогүй, зөвхөн монголчуудын дайралтаас зугтаж дүрвэсэн хүмүүсийн ам дамжсан ярианд тулгуурлан бичсэн нь мэдэгдэнэ:

Үдэш болоход эцэж цуцсан Тартарууд амрахаар буцсан ч дутаан одохыг хүсэгчдэд оргон зайлах зам олдсонгүй билээ. Түнэр харанхуйн дунд хаашаа л хөдөлнө, амь нь тасрахгүй амьсгалж буй шархандаа тарчлан гасалж буй золгүйсын хүүр цогцсонд бүдчин байв. Үхдэл хүүрийн дийлэнх нь үлээсэн тулам шиг хөөж хавдаад тэрийн хэвтэнэ. Анхны тэр шөнө талаар нэг тархсан мод, чулуу мэт гулдайх тийм олон цогцос хүүрийг харахаас нүд хальтрам аймшигтай байжээ. Аюумшигт дассан хүлээлт дараах өдөр нь амь биеэ

хоохойлох арга болон хувирлаа. Өдөр оргон зайлахыг зүрхлээгүй зарим нь үхэгсдийн цусанд хөрвөөж цогцос хүүрнүүдийн дунд нуугдан хэвтсэнээр шарилын дунд амь хоргодвой.⁴⁶

Тэрээр өгүүлэн буй зугтагч, дүрвэгч нарынхаа амсаж мэдэрсэн айдас түгшүүр, гуниг зовлонг аль болох бүрэн дүүрэн, хүч оруулан уран яруу илэрхийлэн бичсэн, зарим тохиолдолд хэд хичнээн нь хэрхэн, хаана олноороо хядуулсан хийгээд хоргодсон, зарим тохиолдолд хэрхэн амь мултарсан, хэрхэн зовж тарчилсныг хүртэл дэлгэрэнгүй бичсэн байдаг. Тэр ч бүү хэл түүний өгүүлсэн зугтагсдын дунд Унгарын ван өөрөө, ихэс ноёд ч багтаж байна. Энэ нь эргэн тойрондоо болж буй үйл явдлын учир шалтгааныг ойлгон ухаарах гэхээсээ илүү харийн түрэмгийлэгчдийн дайралт довтолгоогоор нөмрөн ирж буй аюул гамшгийг үзэж мэдэрсэн анхны туршлагаа хуваалцах нь зохиогчийн гол зорилго нь байжээ гэдгийг илтгэж байна. Тиймээс зохиогчийн монголчуудын харгис хэрцгийг тоочин дүрсэлсэн болгоныг түүхэнд болсон бодитой үйл явдлууд гэж үзэх аргагүй, аливаа “эго” сурвалжуудын адил зөвхөн нэг л өнцгөөс ойлгон ухаарч бичсэн гэдгийг онцлон тэмдэглэвэл зохино. Үүнийг Монголчуудын Европт хийсэн аян дайны тухай зохиогчийн мэдээлэл тун хязгаарлагдмал байгаа нь давхар нотолж байна. Жишээ нь, эрдэмтэн Свийнейн ажигласанчилан, Томас монголчуудын дайралтын эхэн үед Куманууд Унгарт дүрвэж ирсэн тухай болон түүний үр дагаврын тухай огт өгүүлсэнгүй, мөн Монголчуудын Польш, Морави болон Унгарт хийсэн аян дайнууд нэгэн зэрэг олон маршрутаар явагдаж байсныг огт төсөөлөөгүй, мөн түүнчлэн Бела вангийн Ариун Ромын эзэнт улсын хаан II Фредериктэй хийсэн уулзалт, Монголчуудын Трансилванийг эзлэн авсан тухай тун бага мэдээлэл өгсөн байдаг.⁴⁷

Томасын монголчуудтай холбогдох бүлгүүдийг тулгуурлан бичсэн өөр эх сурвалж түүний өөрийн биеэр үзэж харсан зүйлс юм. Ялангуяа IV Бела вангийн болон монголчууд Спалато хотод хүрч ирсэн тухай хүүрнэн бичсэн 38 дахь бүлэг бүхэлдээ, 39 дахь бүлгийн эхний хэсгүүд архидиаконы нүдээрээ үзэж харж бичсэн зүйлсүүд байна. Үзэж харсан зүйлсээ зохиогч христийн шашны итгэл үнэмшлийнхээ үүднээс шашны ариун ном судруудын хэллэгээр хүч оруулан олон янзаар илэрхийлэн бичсэн байдаг явдал дан ганц монголчуудын тухай хэсэгт гардаггүй, мөн хорват, унгаруудын тухай бичсэн хэсгүүдэд ч гэсэн түгээмэл хэрэглэгддэг хэллэгүүд болж байдаг. *Historia Salonitana*-гийн өгч буй

46. Эхийг Sweeney/HS, 270-271-д үзнэ үү.

47. Sweeney, 1982, 161.

монголчуудын цэрэг, дайны тухай зарим мэдээ зангиуд зохиогчийн өөрийнх нь хувийн туршлага дээр тулгуурласан болов уу гэмээр байдаг:

Тэдний сум манайхаас дөрвөн хуруу урт бөгөөд төмөр, яс, эврэн үзүүр бүхий зэвээр ялгагдана. Сумнуудын онь нь бидний нумын хөвч орохооргүй нарийн байдаг.⁴⁸

Түүнчлэн архидиаконы өгч буй ийм мэдээлэлүүд тухайн үеийн болон түүнээс хожуу үеийн гэрчүүд, түүхчдийн мэдээ болон өнөөгийн археологийн судалгааны үр дүнтэй тохирч байдаг.

Historia Salonitana-гийн зохиогдсон хугацаа эх гар бичмэлүүдэд дурдагдсангүй, тиймээс уг хүүрнэлийн дотоод буюу ерөнхий агуулга, бүтэц, үйл явдлын дэс дарааг анхааралтай шинжилсний үндсэн дээр сурвалж бүхэлдээ яах аргагүй XIII зуунд бичигдснийг судлаачид санал нэгтэй зөвшөөрч байдаг. Сурвалжийн гадаад судалгаа ч гэсэн энэ зууны хоёрдугаар хагаст бичигдсэн болохыг баталж буй юм. Энэ он цагийг 1985 онд бичсэн Свийнэй 1245 оноос 1251 оны хооронд бичигдэж эхэлсэн, түүнээс хойш тодорхой материалуудыг хэсэг хэсгээр нэмж оруулсан гэж бичсэн боловч үүнийгээ баттай дэлгэрүүлэн нотлоогүй⁴⁹, мөн энэ тухайд 2006 оны хэвлэлдээ огт дурдаагүй байна.

Харин Монголчуудтай холбогдсон бүлгүүдэд дурдагдсан мэдээнүүдийг анхааралтай задлан шинжилбэл сурвалжийн Томас архидиакон энэ дөрвөн бүлгийг монголчуудын довтолгооны дараах 2-5 жилд бичсэн болов уу гэсэн сэтгэгдэл төрнө. Жишээ нь, *Historia Salonitana*-гийн монголчуудын довтолгоотой холбогдох бүлгүүдийн төгсгөлд монголчуудын довтолгооны дараа Унгарын вант улс даяар их өлсгөлөн, түүнийг дагалдан араатан амьтад хүмүүс рүү дайрч нийгэм, эдийн засгийн их сүйрэл болсон тухай өгүүлдэг:

Licet autem barbarica rabies totum regnum Hungaricum immoderato gladio attrivisset, e vestigio tamen famis subsecuta pernitie miserabilem plebem tabo inedia devastavit... Post hec vero rabidorum luporum multitudo, quasi de diaboli caverna emersit, qui nonnisi humanum sanguinem sitientes, non iam occultis insidiis, sed palam irrumpebant in domos et de matrum gremiis parvulos rapiebant... Tribus ergo cladibus antedictis, videlicet ferro, fame, fera totum regnum Hungarie continuato triennio flagellatum ex divino iudicio penam suorum expendit non mediocriter peccatorum. [Зэрлэгүүдийн хилэн догшин илдээрээ Унгар орныг бүхэлд нь түйвээсэн ч түүний араас золгүй ард аймшигт өлсгөлөнд нэрвэгдэн турж үхэхэд хүрсэн билээ... Тэгээд тэнд отож нуугдахаа байгаад ил задгай гэр орон руу дайран орж эхийнх нь хөхнөөс нялх нярайг хулгуулах болсон цуснаас өөр юунд ч үл цадах догшин хэрцгий чонос чөтгөр шуламын

48. Эхийг Sweeney/HS, 282-285-д үзнэ үү.

49. Sweeney, 1982, 159.

үүр агуйнаас гарч ирсэн мэт асар олноороо ирсэн билээ... Тийнхүү төмөр, өлсгөлөн, араатан хэмээх дээр дурдсан гурван түйтгэр Унгарын вант улсыг тэр чигт нь гурван жилийн турш тасралтгүй сүйтгэсэн бөгөөд Эзэн Бурханы таалалаар үйлдсэн гэм нүглийнхээ төлөөсийг өчүүхэн төлөөгүй ажгуу.]⁵⁰

Дээрхи догол мөрний *Эзэн Бурханы таалалаар үйлдсэн гэм нүглийнхээ төлөөсийг өчүүхэн төлөөгүй ажгуу* (*divino iudicio penam suorum expendit non mediocriter peccatorum*) гэсэн хэллэгийг хоёр янзаар ойлгож болно. Нэгдүгээрт, монголчуудын өдөөсөн дайн, түүнийг дагалдаж гарсан өлсгөлөн, араатан чоно ихэссэн явдал эдгээр гурван гамшгийн хор уршиг хэзээ ч арилахгүй нь хувь тавилан байсан, тиймээс бурханы шийдвэрээр болох ёстой хувь заяа дайраад өнгөрчээ гэж ойлгогдож байна. Нөгөө талаар эдгээр гурван гамшгийн хор уршиг бүрэн арилаагүй хэвээр байна хэмээн ойлгогдоно. Хүүрнэлийн дараагийн хэсгүүдэд Томас орон нутгийн хүмүүс эдгээр сүйрлийг даван туулсан тухай огт дурдсангүй байдаг. Хэрвээ уг хүүрнэлд өрнөж буй явдлын хам өгүүлэмжээс үүдэн ийнхүү сүүлийнхээр ойлговол, хэдий нотлох өөр төрлийн баримт сэлт байхгүй байсан ч монголчуудтай холбогдох хэсэг 1242 оноос эхлэн бичигдэж түүнээс хойшхи цөөн хэдэн жилийн дотор бичигдсэн болов уу гэсэн таамаглал төрүүлж байна.


Үүнээс гадна, *Historia Salonitana*-гийн 38 дахь бүлэгт монголчуудаас зугтан дүрвэж буй Унгарын ванг дагалдан Спалато хотод 1242 оны хавар ирсэн хүмүүсийн цол хэргэмийг нэрлэн дурдсан байдлыг үзвэл дээрх таамналыг дэмжих баримтыг олж болохоор байна. Жишээ нь, тэдгээр хүмүүсийн дотор Бенедиктус хэмээгчийн зэрэг дэвийг зохиогч "Албарежиагийн провост, вангийн ордны сайд, Колоценсийн бишопд сонгогдож буй"⁵¹ хэмээн нэрлэжээ. Судлаач Свийнэй уг сурвалжийг англи, герман хэлнээ орчуулахдаа энэ Бенедиктусийн тухай нэмэлт тайлбар хийсэн байна. Тэрхүү тайлбарт тодорхойлсноор Бенедиктус 1239 оны 2, 3 дугаар сараас 1240 оны 7 дугаар сарыг хүртэл Буда, мөн Албарежиа хотын провост, вангийн дэд сайд байжээ. Харин монголчуудтай Мохид хийсэн тулалдааны үеэр Колоциум хотын тэргүүн бишоп Угринус амь эрсэдсэн тул оронд нь 1241 оны 9 дүгээр сарын 23-нд Бенедиктусийг уг хотын бишопд сонгохоор нэр дэвшүүлсэн (*electus Colocensis*) ажээ. Үүнийг пап IV Иннокент бараг хоёр жилийн дараа буюу 1243 оны оны 7 дугаар сарын 15-нд баталгаажуулсан байна. Тэгэхээр эндээс "Колоценсийн бишопд сонгогдож буй" Бенедиктусийн тухай өгүүлж буй хэсгийг Томас архидиакон 1243 оны 7 дугаар сарын 15-аас өмнө бичжээ гэсэн дүгнэлт

50. Sweeney/HS, 302-305.

51. "Benedictus Albensis prepositus, aule regie cancelarius et idem ad Colocensem sedem electus" (Sweeney/HS, 290-293; *Mongolensturm*, n. 43, 268)

гаргаж болох юм. Энэ дүгнэлтийг Томасын яг энэ хэсэгт дурдсан өөр бусад хүмүүсийн зэрэг дэвийн нэршлээс батлаж болохоор байна. Жишээ нь түүний дурдсан Ахиллэс провост нь дээрх Бенедиктусыг залган дор хаяж 1240 оны 7 дугаар сараас эхлэн 1243 оныг хүртэл Албарежа хотын провост, Винценциус провост нь 1242-1244 оны хооронд Нагиварад хотын провост, Томас провост нь мөн дээрх Бенедиктусийг залгамжлан Буда хотын провост болсон ажээ. Тэгэхээр Томас Монголчуудтай холбогдох дөрвөн бүлгийг биш юм аа гэхэд 38 дахь бүлгийн энэ хэсгийг судлаачдын үзэж байсан шиг 1245-51 онд биш, харин Монголчуудын дайны дараахан удалгүй буюу 1243 оны 7 дугаар сарын 15-аас өмнө бичсэн байх магадлалтай хэмээн үзэж болох юм.

Эцэст нь дүгнэхэд, Далмацийн Спалато хотын архидиакон Томасын *Historia Salonitana* хэмээх энэхүү түүхэн тэмдэглэл, дуртгал нь Монголчуудын Европт хийсэн аян дайны дайралт довтолгоог нүдээр үзэж харсан гэрчүүд аман уламжлал болон зохиогчийн хувийн ажиглалт дээр тулгуурлан бичигдснээрээ XIII зууны эхэн хагасын Монголын эзэнт гүрний байлдан дагуулалын түүхэн үйл явдлыг судлаж, сэргээн босгоход нэн чухал олон мэдээ занги өгч чадах түүхийн үнэт сурвалж болно.



Зураг 1. *Historia Salonitana* сурвалжийн S эхийн нэгэн хуудас (Brown, Virginia. "Tommaso Arcidiacono. Historia Salonitana," in Tesori della Croazia restaurati da Venetian Heritage Inc., Venice: Edizioni Multigraf, 2001, 166-аас авав)

ualir tñ quo pacto dicit se Chroates regi hungarie.

uolamus tñ gñ filius vladislau t
regis hungarie. stans in regno loco pa
tris sui. et quia multa strenuitate iuge
bat pposuit totā Chrouaciaz usq; ad ma
re dalmatici sub suo dñio subiungere. Vēit cū suo
exercitu usq; ad flumen draue. Chroates uō audien
tes de aduentu regis congregauerūt exercitū suū t ppe
parauerūt se ad pugnaz. Rex uō audita cōgregatiōe
ipōr. misit suos nūcios uolens ipōs gratoſe tractāre
et pacti tñ eſſet ut uoluerūt ordiare. Chroates
audita legatiōe dñi regis inito cōſilio omis i simul
acceptauerūt et miſerunt. xij. nobiles ſapientiores
de. xij. tribub; Chroacie. Siliet. comitez Gūm. de ge
nere. clacitor. Comitez Igrinū. de gñe. chuchator.
Comitez arimagnaz. de gñe Subichor. Comitē pu
biſlauū. de gñe. Cudominitor. Comitez Gorgium.
de gñe. Snaſitor. Comitez Jarm. de gñe. munitor.
Comitez paulu. de gñe. Guſſitor. Comitez marti
niz. de gñe. karneſiuz. et de gñe. Iapcanor. Comitē.
pubiſlauū. de gñe. politor. Comitez obradū. de gñe.
Iacnicor. Comitez Joſem. de genere. Jamometor.
Comitē aruogum. de genere. Tugomitor. Qui ue
nientes ad dñm regem ei debitā reuerentiā ex
hibuerūt. dñs uero rex ad osculū pacis eos recipi
ens et honoriffice tractans ad tales cōcordiaz deue
nerūt. q omis pdicti teneant ſuas poſſeſſiones ac
bona cum omib; ſuis pacifice t quiete. Et quod
nō teneatur aliqua pccāz generatio nec eor; hoies
ſoluere cenſum ſeu tributum regie maieltati ppa
te. n̄ tñuz teneāt pccā dño regi qñ aliq; i uaderet
ſua oſſia. Quē ſi dñs rex miſſerēt p eis tñc ire dñat
admiu. cū. x. eqū armigerū oqualibet gñatiōe pccāz
ſuis expenſis usq; ad flumē draue. t de uſ; hūganiam
ad expen dñi regis usq; q erat durauit dñat pmanē.
et ſic extant ordinatuz. De anno dñi. m. c. ij. et c.)

1102

Зупар 1. *Historia Salonitana* сурвалжийн S эхийн нэгэн хуудас (Šegvić, Cherubino. Tommaso Arcidiacono: il suo tempo e la sua opera, Supp. al Bullettino di Archeologia e storia dalmata, Spalato: Tipografia Leonina 1914-aac aab)

Abstract: Two different worlds, nomadic and sedentary originated in the eastern and western hemispheres of the Earth. Both of them encountered each other on the Danube Plateau in the first half of the thirteenth century, namely the Mongol Empire and the Hungarian Kingdom so-called “Shield of Latin Christendom.” Reports and letters mainly of Hungarian Christians might be considered as the most significant, unbiased information in order to scrutinize questions concerning the reason and pretext of Mongols’ conquest that was bound for the Danube Plateau. Of reports and letters of Hungarian Christians who witnessed and participated in contemporary historical events between the Mongols and the Hungarians, four chapters of the *Historia Salonitana* written in Latin by archdeacon Thomas of Spalato represents an invaluable primary source to study the incursion of the Mongols into Europe in 1237-1242. Thomas (1200-1268), the author was native of Spalato. As an archdeacon of Spalato he possessed well Latin culture and education. He personally experienced the Mongols’ invasion when the Mongol army pursued Hungarian king IV Bela to Dalmatian coast. Being an eyewitness and based on oral traditions of informed refugees, he gives a description of the Mongols’ conquest of the Danube Plateau in his historical account-autobiography consisted of 49 chapters. As some researchers suggest, the date of his account is attributed to 1245-1251. As I argue, the 36-39th chapters concerning the Mongols’ invasion were written within 2-5 years since 1242. Especially there is a high probability that the 38th chapter was written before 15 July 1243. Thus the account can be considered appropriately as one of the primary sources that were written on the Mongols’ origins and their customs before Plano Carpini. As an historical source, the report has been hitherto studied only by European researchers. This article aims to introduce this historical source to Mongolian audience by translating it into Mongolian and commenting on its four chapters regarding the Mongols.

Спалато хотын Томас архидиаконы *Historia Salonitana* хэмээх сурвалжийн 36-39 дэхь бүлгийн монгол орчуулга¹

36. Тартарын тахал

Унгариа улсын² ван Андрегийн³ хөвүүн Бэлагийн⁴ ван суусан тавдугаар он буюу Гарганогийн⁵ засагласан хоёрдугаар онд Тартар хэмээгч хөнөөлт улс⁶ Унгарын газарт дөхөж ирлээ. Олон жилийн туршид энэхүү ард түмний тухай цуу яриа, айдас хүйдэс бүх дэлхий даяар тархсан байв.⁷ Тэд дорнын нутгуудаас хөдлөн ирж Рутениагийн⁸ хязгаар хүртэл зам зууртаа тааралдсан газар орнуудыг хядаж устгасан юм. Гэвч Рутенчууд эрэлхэгээр эсэргүүцсэний учир тэд урагш алхаж

1. Энэхүү орчуулгыг 2006 онд Свийнэй тэргүүтэй эрдэмтдийн сэргээн хэвлэсэн S эх, түүнд холбогдох тайлбарт тулгуурлан англи, итали, герман орчуулгуудтай харьцуулан гүйцэтгэв. Дөрвөлжин хаалтад утгыг тодруулах зорилгоор орчуулагчийн нэмж оруулсан үгсийг тэмдэглэсэн болно.
2. Унгарын вант улс.
3. Унгарын вант улсын ван хаан II Андрей (лат. Andrea, унг. András, 1177-1235)
4. II Андрейгийн ууган хөвгүүн IV Бэла ван (лат. Bela, 1206-1270). 1235-1270 оны хооронд Унгар, Хорватын ван байв.
5. Италийн Анкона хотын уугуул Гаргано дэ Аршиндис (лат. Gargano de Arscindis) 1239-1242 оны хооронд Спалато хотын захирагч подеста байв. Гарганогийн тухай энэ өгүүлэлд бичсэн зохиогчийн тухай хэсгээс тодорхой үзнэ үү.
6. Томас архидиаконы уран яруу бичлэг, бодитой дүрслэлийн аль алинд монголчууд бол юуны түрүүнд өөр ямар ч улс түмэн эгнэшгүй ер бусын дайнч чадвартай, хэрцгий догшин, өршөөл энэрэлгүй зан авиртай дайснауд юм гэсэн ойлголтыг төрүүлэхийг хичээсэн байдаг нь тодорхой ажиглагддаг. Тиймээс хамгийн эхний өгүүлбэртээ л үүнийгээ илэрхийлж “genus pestifera Tartarorum” буюу Тартар хэмээгч хөнөөлт улс хэмээн нэрлэж байна. Энэхүү Тартарус хэмээх ард түмний хөнөөл Пест хот, Унгарын вант улс төдийгүй, ерөөс христийн шашинт Европын улс түмнүүдийг "тахал" мэт нэрвэж байна гэсэн санаагаар Томас бичжээ. 24-р тайлбарыг үзнэ үү.
7. Монголчуудын тухай Европчуудын төсөөлөл гол төлөв домгийн шинжтэй цуурхал дээр үндэслэж байжээ. III пап Онориус (лат. Onorius, папын албанд 1216-1227) 1221 онд Кардинал Пелагиус (анг. Cardinal Pelagius) болон Витрийн Жэймс (анг. James of Vitry) нараас Давид вангийн Перс руу довтлон Европт дөхсөөр *Ариун Нутгийг* (Terra Santa) чөлөөлөхөөр ирж байгаа тухай мэдээлэл удаа дараа авч байсан байна. Хоёр жилийн дараа 1223 онд Унгарын ван II Андрей Прэстер Жон хэмээгдэгч Давид ван олон иргэдтэйгээ хамт Оросын нутагт нэвтрэн орж ирсэн тухай папд мэдээлжээ. Энэ мэдээлэл Давид ван долоон жилийн өмнө Энэтхэгээс гарч Христийн сурталыг номлогч Томас апостлын цогцсыг тээж авч яваагаар үргэлжилж улмаар нэг өдрийн дотор түүний цэргүүд 200000 Орос, Комануудыг алсан тухай өгүүлдэг. Мөн тэр жил нь Гүржийн хатан Русудан (анг. Rusudan, 1223-45) папд захидал илгээсэн байдаг бөгөөд түүнд монголчуудын тухай бодит гэхээсээ илүү хагас зохиомол шинжтэй дүрслэн бичсэн байдаг (de Rachewiltz, Igor. *Papal Envoys to the Great Khans*, London: Faber and Faber, 1971, 59).
8. Рутения гэж Киевийн Оросуудыг хэлж буй.

чадаагүй билээ⁹. Тэд Рутен ардтай олонтаа тулалдаж аль аль нь их хэмжээний цус асгаруулсаны эцэст Рутенчууд тэднийг хөөжээ. Ийнхүү хулжин зугтсан тэд умар зүгийн нутгуудаар хэрэн дайтсаар хорь гаруй жил болсон ажээ. Хожим нь байлдан эзэлсэн өөр олон ард түмнээр, тухайлбал Кумануудаар¹⁰ цэргийн хүчээ зузаатган сэлбээд буцаж Рутенд очжээ. Эхлээд Христийн хамгийн том хотуудын нэг Суздалиумыг¹¹ хүрээлэн бүслэв. Удаан бүслэгдсэн хотыг гагц цэргийн хүчээр бус харин арга мэхээр эзлэн авч сүйтгээд Жеоржиум¹² хэмээгдэх ванг нь тонилгон хүн ардыг нь алж хяджээ. Эндээс тэд Унгарын зүг жолоо эргүүлж замдаа учирсан бүгдийг хиаруулав.¹³ Яг энэ үед буюу

9. Энд Калка голын тулалдааныг (1223 оны 5 дугаар сар) хэлж буй. Калка голын тулалдааны талаарх Томасын төсөөлөл алдаатай байсан бөгөөд үнэндээ энэ тулаанд Сүвээдэй, Зэв жанжины удирдсан монголын цэргүүд ялагдаж хөөгдсөн бус, харин ялсан билээ. Калка голын тулалдаан нь Томас архидиаконы дурдсан цаг үеээс 20 гаруй жилийн өмнө бус, харин 13 жилийн өмнө болсон юм.

10. Куманууд нь Дунай мөрөн, Каспийн тэнгисийн хоорондох тал хээр газарт (өнөөгийн Украин, ОХУ-ын газар нутаг) XI зуунаас эхлэн суурьшин амьдарч байсан түрэг угсааны нүүдэлчид. 1239 онд Кумануудын хан Хөтэн нь IV Бела вангийн үед Унгар руу орогнол эрж монголчуудаас зугтсан нь монголчуудын Унгарын вант улсыг дайлах шалтгаан болжээ. Ер нь Монголчууд ирэхээс өмнө Унгарууд олон зуун жилийн турш зүүнээс баруунш нүүдэллэж ирсэн түрэг угсааны аймгууд, тухайлбал Кумануудтай харилцаатай байсан байна (Vásáry, Istvan. *Cumans and Tatars: Oriental Military and the Pre-Ottoman's Balkans, 1185-1365*, Cambridge: Cambridge University Press, 2005, chs. 1-2; Мөн Florin Curta (ed.) *The Other Europe in the Middle Ages: Avars, Bulgars, Khazars and Cumans*, Leiden and Boston: Brill, 2008-аас дэлгэрэнгүй судалгаануудыг үзнэ үү). Унгарын ван II Андрей бүр 1221 оны эхээр Куманы овог аймгуудыг христийн шашинд оруулахаар оролдож доминикан ёсны христ номлогч нарыг илгээж байсан юм. Энэ нь үр дүнтэй болж Куманы зарим овог аймгийн толгойлогч нар Унгарын вант улсад үнэнчээ илэрхийлж байжээ.

11. Оросын зүүн умард хэсэгт оршиж асан Сүздаль хот. Орос, Европ руу чиглэсэн Монголчуудын хоёр дахь аян дайн 1235 оны Өгөдэй хааны хурилдайгаар эхэлсэн бөгөөд монголчууд хамгийн түрүүнд Оросын Рязань хот 1237 оны 12 дугаар сарын 21-нд, улмаар Сүздаль хот 1238 оны 2 дугаар сарын 5-8-нд тус тус эзэлжээ. Сүздалийн Оросын ван Юрий 1238 оны 3 дугаар сарын 4-ний тулалдаанд нас барчээ.

12. Юрийг хэлж буй бололтой.

13. 1235 оны Хурилдайгаар шийдсэний дагуу тэр жилийн өвөлдөө Монголчууд их цэргийн хүчийг засан бэлтгээд 1236 оны хавар аян дайнд морджээ. Чингээд 1236 оны намар, 1237 оны хаврын хооронд Бат, Сүбээдэйн удирдсан монголын их цэргийн нэг жигүүр юуны түрүүнд түрэг гаралтай аймаг улсууд руу довтолж, 1237 оны намар гэхэд Волгийн Булгаруудыг эзлэн авсан юм. Энэ хооронд Мөнхийн удирдсан өөр нэг жигүүр өөр бусад түрэг гаралтай аймгууд болох Кумануудыг баруунш шахаж, мөн 1237 оны хавраас нэгдсэн хүчээр Оросын өмнөд ванлиг улсууд руу довтолж эхэлжээ. 1238 хавраас Оросын хамгийн хүчирхэг ванлигуудын цэрэг армиудыг буулгах болж улмаар 1240 оны 12 дугаар сарын 6-нд Орос ванлигуудын цөм Киев хотыг эзлэн авснаар латин хэлт христийн ертөнцийн зах хязгаар болсон Унгар руу довтолоход

1241 оны Октобер сарын зургааны бүтэн сайн өдөр¹⁴ наран ахин хиртэхүй¹⁵ агаар тэнгэрийг түнэр харанхуй нөмрөн авч урьд өгүүлсэнчлэн гурван жилийн өмнөх наран хиртсэний адил хүн бүгд их айдас хүйдэст автсан билээ.

Тийнхүү Тартар хүмүүс үхэл дагуулсаар дөхөн айсуу чимээ Унгаруудын сонорт хүрэхэд, урьд ийм яриа олонтаа сонсогдовч юу ч эс учирсаны тул, нөгөөтэйгүүр вант улсынхаа их цэргийн хүчинд дулдуйдсаны тул тэд үүнийг тоглоом тохууд тооцох буюу хоосон зүүдэн төдийд үзвэй. Гэвч энх цагт олон жилийн турш эрх тааваар байсан тэд сулран доройтож зэвсгийн их эрдэм чадлаа алдан цэнгэл жаргалд бие автан үлбийж мохсон байлаа. Унгар нутаг бүхий л сайн сайхан эд зүйлээр элбэг баяны учир үр хүүхдүүд нь хэмжээлшгүй баян тансаг зугаа цэнгэлд умбахын шалтгаан болсон юм. Залуус гэзэг үсээ янзлах, өнгө зүсээ гоодох, эр цэргийн хуяг дуулгаас илүү эхнэр хүүхний өмсгөл зүүлтэд дурлахаас өөр юуг хийв ээ? Тоглоом наадам, тансаг зоогны хооронд бүх л өдрийг бараад үдэш унтсаар өдрийн гурав дахь цагийг¹⁶ хүргэнэ. Амьдралынхаа бүхий л цаг мөчийг эхнэртэйгээ нарлаг ой, тухлаг ширгэн дунд өнгөрүүлэх бөгөөд хатуу бэрх үйл хэрэг бус

бэлэн болов. *МНТ*-ны 270-р зүйлийн мэдээ 1235 оны хуралдайгаар ахмад хөвгүүдийн аян дайныг Мажар хүртэл явуулахаар төлөвлөсөн байсан гэдгийг нотолдог.

14. 1241 оны 10 дугаар сарын 6

15. Томас тэмдэглэлийнхээ 33 дахь бүлэгт 1239 оны 6 дугаар сарын 3-нд нар хиртсэн тухай ийнхүү өгүүлжээ: “1239 оны яг тэр үед буюу Иониум сарын гурванд наран гайхалтайгаар, аюумшигтайгаар хиртэв. Наран бүхэлдээ нуугдаж цэлмэг тэнгэр харанхуйлав. Одод шөнө буй мэт тэнгэрт гялалзан харагдаж, [тэдний дундаас] нэгэн том одон нарны ойр баруун талд нь тодрон авай. Эл их аюумшиг хүн болгоныг эзэмдэн авахуй тэд дэлхий ертөнцийн төгсгөл энэ буюу хэмээн бодож энд тэнд галзуурсан мэт хашгиран гүйлдж байв. Энэ өдөр шинийн арван гурван, гарагийн Венера [тав дахь] өдөр байсан болой. Энэ хиртэлт бүх Европоор үзэгдсэн ч Ази, Африкд үзэгдсэнийг өгүүлж эс хэлнэ. Яг тэр жилд урт-үст одон [сүүлт од] Унгарын вант улсын дээгүүр умардад гялалзан олон өдрийн турш үзэгдвэй. Үүнийг их гайт үйл болохын ёр хэмээв. Тэр өдрүүдийн турш аймшигт нүргээн алс чанадад тархаж Тартар хэмээгч хөнөөлт улс Рутениагийн газар Христийн ертөнцийн хил хязгаарт дайран орсон тухай хүн бүхний сонорт хүржихүй. Гэвч үүнийг олноороо наргиа наадам төдийд үзсэн билээ” (Thomæ Archidiaconi Spalatensis - Archdeacon Thomas of Split. *Historia salonitanorum atque spalatinarum pontificum* - *History of the Bishops of Salona and Split*, latin text by Olga Perić, ed., trans. and annotated by Damir Karbić, Mirjana Matijević Sokol and James Ross Sweeney, Budapest and New York: Central European University Press, 2006, ch. 33, 228-231 (үүнээс хойш Sweeney/HS))

16. Ромын эзэнт гүрний үеэс хойш дундад зууны латин хэлт Европт хэрэглэж байсан цагийн тоололын дагуу өглөөний есөн цаг.

гагц яль шаль зүйлийг анхааран хийх болсоор дайны чимээ шуугианыг төсөөлж ч чадахаа больсон байлаа. Гэлээ ч ухаан сэхээтэй зарим нь аймшигт сураг чимээнээр цочирдон дагжиж, тэдгээр хөнөөлт улсуудын довтолгооноос айж сүрдсэн билээ. Тиймээс жигшүүрт хүмүүсийн довтолгоонд гэнэт ниргүүлж сэрэмж бэлтгэлгүйгээсээ хохирол ихээр амсуулахгүй гэсэндээ аюул хөнөөлөөс сэргийлэн болгоомжлохыг ван, хунтайж нарт бараалхан байнга сануулдаг байв.

Олны энэ чимээ шуугианд сэхээ орсон ван өөрөө гүрэн улсынхаа хязгаарыг чиглэн хөдөлж Рутен болон Унгарын заагт сүндэрлэх уулсад¹⁷ хүрэв. Улмаар Полониагийн¹⁸ хилийн чанадад одоод, цөмрөн орж болох нүх сүв бүрийг чандлан шалгасны эцэст их шугуй хуга татуулж өргөн шивээ босгон аль амар нэвтрэн ирж болох газруудыг хаав. Чингээд эргэн ирсний дараа элчидийг илгээж улсынхаа бүх хунтайж, барон, ихэс ноёдыг дуудан Унгарын цэргийн хүчинг нэгэн газар нэгтгэн цуглуулжээ¹⁹. Түүний дүү ван Коломаннус²⁰ ч бас бүх цэргийн хүчээ авч ирсэн байв. Унгарын шашны тэргүүн санваартнууд ч мөн ирэв. Тэд сүмийн номхон дөлгөөн амьдралд нийцсэн эгэл даруухан орон гэрээ сахин суухыг бодсонгүй, харин ч бэл чинээ нэмэрлэн хамаг олон хөлөг баатрыг дагуулан иржээ. Тэдний дунд Стригониумийн²¹ архбишоп Матиас²², Коллоциумийн Угринус²³ нар туслах бишопуудынхаа хамтаар хүрэлцэн ирсэн байв. Тэднийг дагаж хутагт санваартнууд ч олноороо ирсэн байсан агаад бултаар вангийн хүрээнд хуран цугларсан нь золигт гаргуулахаар хашигдсан хоньдыг

17. Карпацийн нуруу

18. Польш (лат. Polonia)

19. Христийн шашны уламжлал ёсоор Есүс ахин амилсны баяраас 40 хоногийн өмнө Их мацаг эхэлдэг бөгөөд 1241 оны Их мацагийн эхэлсэн өдөр уг үйл явдал болсон ажээ.

20. Коломаннус (лат. Colomannus, 1208-1241) бол II Андрейгийн хоёр дахь хөвгүүн, IV Бэла вангийн дүү юм.

21. Эсцтергом хот (лат. Strigonium, гер. Gran, унг. Esztergom) нь өнөөгийн Унгарын нийслэл Будапештээс баруун хойш 50 км орчим зайд хилийн ойролцоо, Дунай мөрний баруун эрэгт оршино.

22. Эсцтергом хотын Матиас архбишоп (лат. Mathias). Тэрээр өмнө нь Бела вангийн тэргүүн сайд (1235-1237), Вач хотын бишоп (1238-1240) байжээ. 1241 онд Мохы хотын тулалдаанд амь үрэгдсэн.

23. Унгарын Калоча хотын Угринус (лат. Hugrinus Collocensis) архбишоп нь II Андрей вангийн тэргүүн сайд (1217-1219, 1230-1235) байв. 1241 онд Мохы хотын тулалдаанд амь үрэгдсэн. Калоча хот (лат. Collocium, унг. Kalocsa) нь Унгарын хамгийн эртний хотуудын нэг агаад Будапешт хотоос өмнө зүгт 114 км зайд оршино.

санагдуулам байлаа. Тийнхүү нийтээр хуралдаж сураг нь айсуй Тартаруудыг хэрхэн дийлж ухраах тухай хэлэлцсээр олон өдрийг үджээ. Янз бүрийн хүмүүс янз бүрийн санаа гаргасаар хамтаар зөвшилцөвч нэгдсэн шийдэлд хүрч чадахааргүй болсон ажээ. Зарим нь хэт их аюусанаас, улс гүрнийг эзлэн ноёрхох шалтгаанаар бус гагц тонон дээрэмдэх гэсэн шуналаараа дэлхий ертөнцийг хэрэн дайтаж буй яахаас ч буцахгүй зэрлэг хүмүүс болох тэдгээр Тартаруудын өмнө цаг нь болоход байлдахгүйгээр бууж өгвөл зохино хэмээв. Бусад нь мунхаглан аюулыг үл хайхарсанаас манай цэргийн их хүчинг хармагцаа дайсан эргэж зугтаах болно хэмээв. Ийнхүү тэд нэгдэж шийдвэр гаргаж чадахгүй байсаар гэнэтийн их сүйрэлд өртөх нь тэр.

Удаан хэлэлцэн ярилцаж цаг хугацааг дэмий хоосон өнгөрөөх үес гэнэтийн элч довтолгон ирж тоолж барамгүй олон Тартарууд вант улсын нутагт нэвтрэн хэдийнээ дэргэд ирсэн тухай мэдээ дуулгаж ванг сандаргалаа. Тэр даруй ван болоод улсын ихэс ноёд хурилдайг тараан зэр зэвсгээ агсаж эхлээд янз бүрийн цэргийн толгойд даргач нарыг томилон үлэмж их цэргийн хүчинг зарлан хураалаа. Тэд Стригониум хотоос хөдлөн Данубиум мөрнийг²⁴ гэтлэн улсын хамгийн том хот болох Пестиумийг²⁵ зорин хөдлөв. Их мацагийн өмнөх дөчин өдрийн хугацаа өнгөрч Паска баяр²⁶ ойртоход Тартарын бүх цэргүүд Унгар улсад нэвтрэн орсон байлаа. Гол цэргийн манлайд явж ой шугуйг огтчин зам гаргаж нэвтрэхэд саад болох бүгдийг устган зайлуулж сэргийлсэн балт сүх агссан дөчин мянган цэрэг тэдэнд байлаа. Иймд тэд вангийн зарлигаар бэлтгүүлж өндөрлөн босгуулсан мөнөөх нүсэр том жодоо, царс модон шивээг дэрс сүрэл адил хялбархнаар тасчин хяргав. Охорхон хугацаанд тэдгээрийг эвдэж шатаагаад явж өнгөрөхөд ямар ч саад бэрхшээлгүй болгожээ. Тэд зах хязгаарт анхлан хүрээд уугуул хэрцгий догшин авир зангаа илтэд гаргасангүй, зөвхөн гацаа тосгодоор давхин өнгөрөх зуураа хүн ардын аминд их гарз хохирол учруулалгүй дээрэмдэж тоносон болой.

24. Дунай мөрөн (лат. Danubium). Цаашид Дунай хэмээн орчуулав.

25. Өнөөгийн Будапешт хотын суурь болсон Пестиум хот (лат. Pestium) XII зуунд Дунай мөрний эрэгт байгуулагдсан ажээ. Монголчуудыг довтлох үед багавтар хот байсан агаад монголчуудын дайралтын дараа 1244 онд чухал байр суурьтай хотод тооцогдох болсон байна.

26. Христийн шашны Есүс ахин амилсаны баяр. 1241 оны 3 дугаар сарын 31-нд энэ баяр тохиожээ.

Бүх цэргийг ах дүү хоёр тэргүүлэн удирдаж байсан бөгөөд ахыг нь Батус²⁷, дүүг нь Кайданус²⁸ хэмээмүй. Тэд өөрсдийнхөө өмнө нэгэн салаа морьт цэргийг явуулсан бөгөөд тэдгээр нь Унгарын хүрээнд давхин хүрч ил далд үзэгдсээр Унгаруудыг гарч ирж өөрсөдтэй нь тулах зүрх зоригтойг нь туршихыг хүсэж ирүүл тулаанд өдөөн дуудахыг оролдов. Унгарын ван шилмэл хөлөг баатруудаасаа гарч тулалдахыг тушаалаа. Тэд ч сайтар хуяглан зэвсэглээд журамлан хөдлөв. Гэвч Тартарууд гардан тулалдалгүй үтэр мордон дутааж явдал дундаа заншил ёсоороо дайснуудаа харван намнаж байв. Тэгтэл ван бүх цэргээ хөдөлгөн дутаагсадын хойноос мөшгөн хөөсөөр Тизиум мөрнийг²⁹ хүрч гэтлэв. Дайсны цэргүүдийг нутгийнхаа дээсээс гарган хөөлөө хэмээн омогшин хөөрсөн тэд Соло³⁰ хэмээх өөр нэгэн их усанд

27. Унгар сурвалжуудад Сүбээдэй баатрын нэр гардаггүй, жишээлбэл Томасын тэмдэглэлд хоёрхон монгол хүний нэр гардаг нь Батус (лат. Bathus), Кайданус (лат. Caydanus) юм. Батус бол Зүчи хааны хоёрдугаар хөвгүүн Бат (мон. Batu, 1255/6 онд нас нөгчсөн) мөн. Тэрээр Алтан ордны улсын анхны хаан (1237-1255/6) байв. Цаашид Бат гэж орчуулав. Харин Кайданус гэж Өгөдэйн зургадугаар хөвгүүн Хаданыг (мон. Qadan) хэлж буй. Цаашид Хадан гэж орчуулав. Томас архидиакон эдгээрийг ах дүү байсан хэмээн андуурсан, үнэн хэрэгтээ Бат, Хадан нар нь Чингис хааны ач хөвгүүд байв.

28. Өмнөх тайлбарыг үзнэ үү.

29. Тизиум (лат. Tysium) гэж өнөөгийн Тиса мөрнийг хэлж буй. Тиса мөрөн нь Украины нутгаас эх авч Дунай мөрөнд цутгана.

30. Соло (лат. Solo) гэж Тиса голын нэг салаа Саёо голыг хэлж буй. Томас архидиакон энэхүү Саёо голын эрэг дээрх энэ үйл явдлаар 1241 оны 4 дүгээр сарын 11-нд болсон Мохи хотын тулалдааныг өгүүлсэн ажээ. Мохи хотын тулалдааны тухай одоогоор мэдэгдэж буй хамгийн найдвартай мэдээ зангийг Томасын сурвалж өгч байна. Харин бараг хагас зуун жилийн дараа бичигдсэн *Yüan shi*-д Саёо голын буюу Мохийн тулалдааныг харьцангуй тодорхой дүрсэлж Мохийн тулалдаанд Сүбээдэй баатрын оруулсан хувь нэмрийг тодотгон бичсэн байдаг: “Su-bu-t'ai [Сүбээдэй] Ba-du-тай [Бат] хамт байсан агаад манлай цэрэг удирдав... Их цэрэг *Huo-ning* [Саёо] мөрнээ ирсэн байхуйд Ba-du урсгал нам дээд эхинээр мөрнийг гаталсан ба тэнд гүүр бас байжээ. Su-bu-t'ai усан нэлээд гүнзгий доод адгаар гатлах ёстой болж сал мод холбон гүүр барив. Энэ хооронд Ba-du дайсантай тулж гучин хүн алдсан бөгөөд түүний цэргийн даругач нарын нэг *Ba-ha-t'u* хэмээгч ч мөн алагджээ. Ba-du шантрах болж ухрах санал тавив. Гэвч Su-bu-t'ai “Хан хөвүүн минь ухрахыг хүсвээс чамд би саад эс болно. Гэвч миний хувьд *T'u-na* [Дунай] мөрөн, *Ma-ch'a* [Пест] балгасыг хүрэхээс нааш ухраагүй байхаар шийдлээ” хэмээв... ялж Монголын цэргүүд балгасунд хүрвэй. Хожим нь ихэд хуримлахуй Ba-du Su-bu-t'ai-ийг “хамтдаа *Huo-ning* мөрнээ байлдахуйд таны хоцорсноос *Ba-ha-t'u*-аа алдав” гэсэнд Su-bu-t'ai “Хан хөвүүн минь, мөрний усан чиний гаталсан хэсгээр нам байсныг чи мэднэ. Чиний өмнө хэдийнэ баригдсан гүүр байсан. Харин миний гатлах ёстой болсон газар усан гүн, тиймээс гүүр барих хэрэгтэй болсныг чи мэднэ” хэмээн хариулав. Дахин хуримлахуйд Ba-du их айраг, үзмийн дарс ууж согтоход энэ яриа ахин өрнөв. Гэвч Ba-du Su-bu-t'ai-ийг ёсоор үнэлж *k'ie-lin* нарын эсрэг дайн амжилттай болсон нь гагц Su-bu-t'ai-ийн

тулж очжээ. Гэвч Тартаруудын бүх хүч энэ усны нөгөө эрэгт хүрээлэн бууж өтгөн ойн гүнд далд газар нуугдсан байлаа.³¹ Унгарууд тэднийг бүхэлд нь бус багахан хэсгийг нь л олж харж чадаж байв. Дайсны цэргүүд голын нөгөө эрэгт хүрээлэн буусан байхыг хараад тэд наад эрэгт нь бууцгаалаа. Ван майхан асаруудыг хол таруу бус харин хаяа хатган босгохыг тушаажээ. Бүх асар майхнуудыг шахцалдуулан хороолон босгосон агаад хүрээг хамгаалах үед тэрэг, халхавчийг тойруулан хашихаар байрлуулав. Тэдгээрийг бөөр нийлүүлэн босгосноос хооронд нь бэхэлсэн дээс үдээр дундуур хөндлөн гулд явж болохооргүйгээр хэрж орооцолдсон байна. Ийнхүү хүрэн дундуур явах хөл хоригдсон цэргүүд бүхэлдээ яг л торонд орсон мэт болов. Унгарууд үүнийгээ хамгаалалт хэмээн үзэж байсан ч үнэндээ энэ нь хамгийн гайтай осол нь болон хувирсан ажгуу.

Энэ үед Тартар цэргүүдийн хоёр удирдагчийн ахмад нь болох Бат гүвээ өөд асаж бүх цэргийн байр байдлыг хянамгай тандаж ажаад өвөр эргэн ирж хэлэв: “Хүлэг баатруудаа хийморьтой байгтун. Дайсан этгээд үлэмж олон тоотой ч сэрэмжгүйтнээр удирдуулсны тул бидний гараас мултарч дөнгөхгүй. Би тэднийг уйтан хавчиг хороонд хашигдсан эзэнгүй сүрэг хонь мэт³² байхыг харлаа”.³³ Яг тэр шөнөдөө тэрбээр

гавъяад тооцов” (Bretschneider, Emilii Vasilevich. *Medieval Researches from Eastern Asiatic Sources: Fragments towards the Knowledge of the Geography and History of Central and Western Asia from the 13. to the 17. Century*, Vol. 1, London: Routledge & Kegan, 1967, 330-331). Монголын цэргийн талд болсон үйл явдлын тухай мэдээ өгч буйгаараа дээрх мэдээ маш чухал юм. Тиймээс зарим судлаачид Саёо голын эрэг дээрх тулааны цэргийн давшилтыг гурав болгон бичсэн байх ажээ.

31. Эхний үе шат нь монголын гол цэргийн шилдэг сайн харваач нэг салаа цэрэг дайсны гол хүчийг бэхлэлт суурингаас нь өдөөн хөдөлгөж тулалдаад ялагдаж буй мэт буруулан дутаах дүр эсгэдэг дайны тактикийг ашиглажээ. Ингэхдээ дайсан этгээдээс зохих зай барьж “нохой хэрж” дутааж явахдаа тогтсон эрэмбэ журмаар арагш харван дайснаа намнадаг байжээ. Ийнхүү дайснаа явдал дундаа хүчийг нь тарамдуулсаар гол цэргийн хүч байрласан отоонд оруулж авчираад “нуман түлхүүр”, “цүүц хатгаа”, “нүүр дээрээс нь асгах” олон хувилбараар шийдвэрлэх цохилт өгдөг байв (Маш олон судлаачид энэ талаар бичсэнээс Базарсүрэн, Ж. *Чингис хааны цэргийн тухай өгүүлэл*, Улаанбаатар: Соёмбо 2007; Timothy May. *The Mongol Art of War: Chinggis Khan and the Mongol Military System*, Yardley: Westholme 2007 үзнэ үү). Адил тактикийг ашиглан Батын цэргийн хүч Мохийн талд Унгарын вант улсын цэргүүдийг ялсан байна.

32. Библийн Шинэ гэрээний Матай IX:36, Марк VI:34-т энэ хэллэг тохиолддог.

33. Сурвалжийн эхэд: “Bono animo nos esse oportet, o sotii, quia licet magna sit multitudo gentis istius, tamen quia improvido reguntur consilio, non poterunt effugere manus nostras. Vidi enim eos quasi gregem sine pastore in quodam artissimo stabulo interlusos.”

цэргүүдээ дэг ёсоор нь байрлуулаад Унгарын хүрээнээс холгүй орших голын хоёр эргийг холбосон гүүрийг дайрч эзлэхийг тушаав. [Энэ үед] оргож зугтсан Рутенийн нэгэн цэрэг ванд хүрч ирээд “Яг энэ шөнө Тартарууд голыг гатлан довтолхоор зэхэж байна. Тиймээс сэрэмжтэй байх аваас тэд та нарыг гэнэдүүлэн цохиж чадахгүй” хэмээв. Ван Коломаннус байлдах цэргүүдээ зэвсэглээд хүрээнээс хөдлөн гарахуйд архбишоп Угринус шадар цэргүүдийн хамт дагалдав. Тэр ч бас үнэнхүү баатарлаг, тулалдахдаа гавшгай, цөст эр байсан бөлгөө. Шөнө дунд тэд мөнөөх гүүрэнд хүрч очжээ. Гэвч дайсны цэргүүдийн зарим нь хэдийнэ голыг гатлан гарсан байв. Тэднийг үзээд Унгарууд ухасхийн давшлаа. Тэд эрэлхэгээр тулалдан тэднээс олныг хядав. Бусдыг нь гүүр рүү буцааж шахаад усанд живүүлвэй. Тиймээс тэд гүүрний эхэнд харуул тавиад их хөөр баяртай өөрсдийнхөндөө эргэж ирэв. Унгарууд баатарлаг ялалтандаа урамшин хөөрөөд нэгмөсөн ялсан мэт зэвсэг агсамжаа тайлж хаян тэр шөнийн турш сэрэмж алдан унтсан ажээ. Гэтэл Тартарууд гүүрийн адагт долоон ширхэг урвуур босгоод Унгарын харуулууд руу бул чулуу шидэж сум харвасаар алс дутаалгав. Харуулуудыг ийн хөөсөн Тартаруудын цэргүүдийн зарим хэсэг гүүрээр чөлөөтэй, аюулгүй гарахад үлдсэн зарим нь голын гармаар гатлав. Ингээд үүр гийхэд бүх Тартарууд цагаан газарт гарч талаар нэг тархав. Харуулууд хүрээ рүүгээ дутааж очоод их дуугаар хашгирсан ч гүн нойронд автан унтагсдыг сэрээж дийлсэнгүй. Эцэст нь гунигт мэдээнд цочирдон сандарч, түгшүүр аюулын үед заншсан шигээ зэвсэгээ шүүрэн агсаад мориндоо мордож дайсантай тулалдах гэж нэг их

(Sweeney/HS, 262) Батын байлдааны өмнө уулын орой дээр гарч дайснуудаа тандсан тухай мэдээ мөн Жувейни, Рашид ад-Дины сурвалжуудад дурдагддаг: “...тэдний цэрэг тоогоороо манайхаас хоёр дахин олон, үнэхээр дайнч тулаанч хүмүүс юм байна гэж мэдэгдлээ... Бат нэгэн толгойн оройд гараад бүтэн өдөр бүхэл шөнөжин хэнтэй ч уулзаж ярилцалгүй мөргөж залбирав. Тэгээд мусулмануудад бас хурж нэгдээд залбирал үйлд гэсэн зарлиг буулгав.” (Juvaynī, *Alā' al-Dīn 'Atā-Malik. The History of the World Conqueror*, vol. 1, Manchester: Manchester University Press, 1958, 268-270; Thackston, W.M. *Rashiduddin Fazllul's Jami'u't-tawarikh Compendium of Chronicles: A History of the Mongols*, vol. 2, Cambridge: Harvard University Press, 1998, 325-326. Рашид ад-Дин Жувэйнийн мэдээг ашигласан нь илт байдаг бөгөөд энэ тулалдааныг монголчууд Булгаруудтай хийсэн мэтээр эндүүрсэн байх ажээ. Түүний Жувэйний бичсэн дээр нэмж оруулсан өгүүлбэр нь “Чингис хааны үйлддэг байсан шиг” гэсэн хэллэг юм. Гэхдээ перс түүхч нарын бичсэнчилэн, Мохийн дайны талбарт үнэхээр лал шашинтнууд оролцсон эсэх нь тодорхойгүй. Энэ нь нэмэлт оруулга байсан ч байж болох юм)

яарсангүй, орноосоо яаралгүйхэн босч дадсан зангаараа ханцуйвчаа шамлаж нүүрээ угаагаад үсээ самнав.

Гэсэн ч Коломаннус ван, Угринус архбишоп болон Темплари цэргийн даргач³⁴ нар эр зоригт цэрэг шиг байв. Тэд гүн нойрондоо дугжирсангүй бүх л шөнийн турш зэвсгээ агссан хэвээр сэрүүн байж хашгирах дуу чимээг сонсмогц ухасхийн хөдөлж хүрээнээс гарсан ажээ. Зэр зэвсгээ агсаад нэгэн эгнээнд жигдрэн нэгдээд дайсны эсрэг довтлон орж хэсэг зуур эрэлхэгээр тулалдсан байна. Гэвч газраас газарт үсчин тархах голио царцааг санагдуулам³⁵ хар мянган Тартаруудтай харьцуулахад тэд маш цөөн тоотой байлаа. Нөхдөөсөө олныг алдсан Унгарууд хүрээ рүүгээ зугтаав. Ямагт ил шударгуу, цөс ихт хүний тул Угринус дуугаа өндөрсгөж их аюул гамшгийн үед өөрсдийн амь насыг авран бүх улсаа хамгаалахыг бодсонгүй хэмээн вангийн хэнэггүй байгааг буруушаан Унгарын бүх бароныг хойрго хулчгар хэмээн зэмлэв. Нэг хэсэг нь гарч нэгдсэн ч бэлэн биш байсан бусад нь айдас, гэнэтийн түгшүүрт автан ухаан санаа нь балартсан мэт юу хийх, хаана аюулгүй хоргодохоо мэдсэнгүй. Дээр дурдсан гурван даргач саатахыг үл тэвчин дайсантай ахин тулж эхэллээ. Угринус дайсны шигүү байрлал руу эрэлхэгээр дайран орсонд аянга цахилгаанаас аюух мэт тэд асар ихээр хашхиран түүнээс зайлав. Үүнд урамшсан Коломаннус болон Темплари цэргийн даргач нар өөрийн латин хөлөг баатар нөхдийн³⁶ хамт дайснуудаас үй олныг хядав. Тэгэвч асар олон дайсны дайралтыг тэсч чадахаа байгаад Коломаннус, архбишоп хоёул хүнд шархдан өөрсдийнхөн дээрээ арайхийн дутаан очжээ. Мөнөөх Темплари цэргийн даргач бүх латин нөхдийн хамт амь эрсэдсэн билээ. Унгарууд ч олноороо тэдний хамт нөгчсөн ажээ. Өдрийн хоёр дахь

34. Христийн шашны Соломоны сүмийн ядуу нөхөр-цэрэг (лат. *Pauperes commilitones Christi Templique Solomonic*) буюу Темплари цэргийн ёс. Үүнийг мөн Темплар хөлөг баатар буюу Сүмийн дэг ёсныхон гэж ч нэрлэдэг. Ромын Католик шашны энэ дэг ёс албан ёсоор 1129 онд үндэслэгдсэн бөгөөд урт цагаан цув, түүн дээрх улаан загалмай тэмдгээрээ ялгарч харагддаг. Энэ дэг ёсны цэргүүд Загалмайтны аян дайны үед хамгийн чадварлагт тооцогддог байсан билээ. Энд өгүүлсэн Темплари цэргийн даргач гэж Унгар, Слованийн нутаг дахь Сүмийн дэг ёсны даргач Монте Регалийн Якобусыг (1240-1241) хэлсэн ажээ. Түүний тухай *Der Mongolensturm: Berichte von Augenzeugen und Zeitgenossen, 1235-1250*, Graz, Wien and Köln: Styria, 1985, n. 16, 264-ыг үзнэ үү.

35. Библийн Хуучин гэрээний Египетээс гарсан нь Х:12-15

36. Унгарт байсан Темплари цэргүүдийн ихэнх нь францууд байв.

цагийн хавьд³⁷ ирэхэд Тартарын бүх цэргүүд Унгарын хүрээг тойрон бүжих мэт бүтэн хүрээлсэн байлаа. Тэд нумаа татаж бүх талаас суман мөндөр буулган зарим нь хүрээг тойруулан галдан шатааж авай.

Унгарууд дайснуудаар бүрэн хүрээлэгдсэнээ үзээд хамаг ухаан санаагаа гээлээ. Тэд цэргийн бүх хүчээ байр хийлгэж их тулаанд орохыг бодож ч чадахаа байгаад их ад түлигэнд аюун сандарч, чонын шүднээс зайлахыг оролдох хашаанд буй төлөг мэт³⁸ ийш тийш бутран гүйлдлээ. Харин дайснууд тэднийг бүчин зогсолтгүй сум харваж, жад нүүлгэж байв. Золгүй Унгаруудын олонх нь амь аврагдах аргагүй болоод юу хийхээ ч мэдэхээ байжээ. Нэг ч хүн нөгөөтэйгээ ярьж чадахгүй, хүн болгон зөвхөн амиа аргалж байсан бөгөөд нэгэнд нь ч нийтээрээ аврагдах тухай бодох сэхээ байсангүй. Тэд сум, жадан борооны эсрэг зэр зэвсгээ барьсангүй, харин нуруундаа зоолгоод их салхинд сэгсрэгдэн шидэгдэх царс модны боргоцой мэт энд тэнд үй олноороо ханаран унаж байв. Амь аврагдах бүхий л найдвар мөхөж үхэл нүд бүхний өмнүүр үзэгдэн хүрээгээр хэсүүчлэн байсан бөлгөө. Ван хийгээд дээдэс ноёд туг сүлдээ орхин аврал эрж зугтан одов. Үлдэж хоцорсон цэргүүд нь үй олон үхдэл цогцосоос цочирдон айж эргэн тойрон дүрэлзэх их галаас мэгдэн сүрдсэндээ дутаахаас өөрийг бодсонгүй. Гэвч тэд энэ их аюул түйтгэрээс зайлж зугтахыг оролдохдоо өөрсдийн үйлдсэн өөр нэг аюулт саадтай учирав. Холбож зангидсан дээс үдээр, хооронд нь шахан барьсан майхнууд замд нь үлэмж их тээг учруулж хүрээнээс гарах гэж адгахдаа нэг нь нөгөөдөө тээглэн дайсны

37. Өглөөний таваас зургаан цагийн хооронд

38. Монголчуудын хөнөөлийг “зууснаа үл тавих, олзолсоноо үл өршөөх, эцэж сульдсныг суллаж үл чөлөөлөх голио царцаа” (2 удаа) эсвэл “өлссөндөө галзууран уурсан өлөн хомхой чоно” (3 удаа) зэрэг араатан амьтантай зүйрлэсэн илэрхийлэл олон тохиолдоно. Түүний дүрсэлсэн “голио царцаа”, “чоно” мэт эдгээр араатнууд нь “хүний цуснаас өөр юунд ч үл цаддаг” (4 удаа) ба “алж талах шунал хүсэл нь дуусахгүй” (1 удаа) ажээ. Харин монголчуудын тухай бүлгүүдэд эдгээр зэрлэг араатан мэт халдан довтлогсдын хөнөөлд өртсөн “гаслант эх нутаг” Унгарын ихэс дээдэс, хүн ардыг “хөөрхийс, заяа нь хаяагсад, золгүйс, тарчлагсад” (дор хаяж 6 удаа) нь “цусанд будагдан алс уудамд улаанаар эргэлдэж байсан” бөгөөд мөн тэднийг авралгүй, хамгаалалгүй болсон “хашаанд хоригдсон эзэнгүй хонь” (3 удаа) гэх мэтээр зүйрлэсэн байдаг. Гэхдээ дээрхи библи зэрэг христийн судруудаас гаралтай үгсийг Томас дан ганц монголчуудын тухай дүрслэхдээ хэрэглээгүй, ерөөс зохиогч аливаа муу, дайсанд үзэж хандсан хүмүүсийгээ дүрслэхдээ сурвалжийн өөр бусад хэсгүүдэд ч гэсэн түгээмэл хэрэглэдэг зүйрлэл, адилтгал байв.

суманд цохигдон хиарах мэт олноороо бие бие дээрээ давхарлан унаж байв.

Харин Тартарууд Унгарын цэргүүдийг зугтахаар завдаж байхыг хараад тэдэнд зам нээж дутаан гарах боломж олгоод гээг даран мөшгин хөөсөнгүй, харин мултран зайлах боломж олголгүйгээр хоёр талаар нь хашин салалгүй дагажээ. Заяа нь хаягсад замынхаа турш эд баялаг, алт мөнгөн сав суулга, ал улаан өмсгөл хувцас, зэгсэн их зэр зэвсэг хаяв. Гэвч Тартарууд тэдгээр бүх үнэт эрдэнэсийг тонон дээрэмдэхийг үл хайхран урьд үзэгдэж дуулдаагүй хэрцгий догшин зангаараа зөвхөн хүн алж талахыг л санаархаж байв. Зугтаж буй дайснуудаа зэвсэгээ даахгүй гар нь цуцаж, алхаагаа хүчрэхгүй хөл нь туйвж эцэж байгааг мэдээд тэд араас нь жадлан цавчиж хэнийг ч үл өршөөн хядав. Тэд өвлийн навчис мэт баруунш зүүнш ханаран унаж, зам тэр чигтээ тарчлан зовогсдын хүүр цогцсоор дүүрээд их цусан гол урсаж авай. Гаслант нутаг нь хөвгүүдийнхээ цусанд будагдан алс уудамд улаанаар эргэлдвэй. Тартаруудын илдэнд өртөж үхээгүй золгүйс нэгэн намагт шахагдан хүрэв. Өөр зам олох боломж олж чадалгүй Тартаруудад дийлэгдэн Унгарууд бараг бүгдээрээ тэр намагт ороод балчиг шаварт шигдэн живж үхжээ. Тэнд үнэн алдарт Угринус нөгчив. Тэнд Стригониумын Матиас, Иориумын бишоп Грегориус³⁹ нөгчив. Тэнд олон хутагт, санваартнууд нөгчлөө.

Ай, Ертөнцийн эзэн минь та, шашныг тань залагч хутагт, албыг тань сахигч санваартнуудаа юунд ийм гаслант тавиланд унагав аа? Яагаад тэднийг ийм зовлонт үхлээр шийтгэнэ вэ? *Ял шийтгэл тань гүн агуу байдаг* нь үнэн билээ⁴⁰. Зэр зэвсэг агсан цэргийн хүрээнд шөнийг өнгөрүүлэхийн оронд ариун орондоо залран аюумшигт Эзэн дээдэс Таньд сөгдөөд эргэл мөргөл хийгч сүсэгтэн олондоо буянаа хүртээх л байсан даа, тэдгээр золгүйс тарчлагсад.

Нэгэн тулаанд зэрэгцэн байлдаж нэгэн шийтгэлээр тарчлан нөгчсөн эрхүүд санваартнууд хийгээд энгийн ардын заяа тавилан адил байлаа. Тэрхүү ангалаас зайлж чадах байлаа ч өмнө нь тосох сэлэмний хурц ирээс зайлах найдвар нэгээхэн бээр байсангүй. Газар дэлхий тэр чигтээ

39. Грегориус (лат. Gregorius) нь Унгарын Гёр хотын бишоп (1208-1241) байв.

40. Библийн Хуучин гэрээний Дуулал XXXVI:6-д адил төстэй хэллэг бий: “Таны шүүх бол их далайтай адил.”

зууснаа үл тавих, олзолсоноо үл өршөөх, эцэж сульдсаныг суллаж үл чөлөөлөх голио царцаа мэт үй олон дайснаар дүүрсэн байв. Тэд хүний цуснаас өөр юунд ч үл цадан зэрлэг араатан мэт байв. Нүдэнд торох зам харгуй бүхэн хүүр цогцсонд хучигдсан байлаа.

Нийтийг хамарсан гамшиг түйтгэрийн эхний өдөр өнгөрсөн ч үүнээс ч ёрын нажид дагасаар л байв. Үдэш болоход эцэж цуцсан Тартарууд амрахаар буцсан ч дутаан одохыг хүсэгчдэд оргон зайлах зам олдсонгүй билээ. Түнэр харанхуйн дунд хаашаа л хөдөлнө, амь нь тасрахгүй амьсгалж буй шархандаа тарчлан гасалж буй золгүйсын хүүр цогцсонд бүдчин байв. Үхдэл хүүрийн дийлэнх нь үлээсэн тулам шиг хөөж хавдаад тэрийн хэвтэнэ. Анхны тэр шөнө талаар нэг тархсан мод, чулуу мэт гулдайх тийм олон цогцос хүүрийг харахаас нүд хальтрам аймшигтай байжээ. Аюумшигт дассан хүлээлт дараах өдөр нь амь биеэ хоохойлох арга болон хувирлаа. Өдөр оргон зайлахыг зүрхлээгүй зарим нь үхэгсдийн цусанд хөрвөөж цогцос хүүрнүүдийн дунд нуугдан хэвтсэнээр шарилын дунд амь хоргодвой. Тартарууд хот, тосгодоод хичнээн их зэрлэг балмад харгислалыг өдөр өнжихгүй үйлдсэн гэх вэ? Тэд тулалдах тэнхэлгүй эмэгтэйчүүд, хөгшид, хүүхдүүдийг тууж хураагаад эгнүүлэн сөгдүүлж хувцасыг нь цусанд будуулж, мөн яргачдад төвөг учруулахгүй гэсэндээ эхлээд өмссөнийг нь тайлуулж зандалчдын өмнө тавив. Тэд хүн бүрийн гарыг өргүүлээд зүрхэнд нь мэс алгуур бүлж цөмийг хороов. Тэр бүү хэл, Тартар эмэгтэйчүүд эрчүүдийнхээ адил зэвсэг агсаж эрэлхэг догшин тулдалдаж байсан бөгөөд олзны бүсгүйчүүдэд бүр ч хэрцгий хандаж байлаа. Гоо зүс царайтан, эсвээс атаа жөтөө төрүүлэм, аль ямар нэгэн байдлаар айлгаж эмээлгэсэн хэнийг ч болов харсан даруй илдээрээ цавчин алж байв. Зарц шивэгчинд тохиромжтойд үзсэн заримынх нь хамрыг тас огтолж нүүрийг зэрэмдэглээд боолд тохоож байв. Олзны хөвгүүдийг дуудан ирүүлж тэднээр тохуурхан ийнхүү зугаацсан бөлгөө: эхлээд тэднийг өмнөө эгнэн суухыг тушааж дараа нь өөрсдийн хөвгүүдийг дуудан тус бүрт шинэхэн модны мөчрөөр үйлдсэн бэрээ өгч золгүй хөвгүүдийн толгойг цохихыг тушаав. Харин өөрсдөө тухлан суугаад хэрцгий ширүүн нүдээрээ ажиглан харж өөр хоорондоо инээлдэн зугаацаж сайн цохисон хийгээд ганц дэлсэлтээр амийг нь гартал тархийг нь хэмх балбасныг нь магтан сайшааж байв. Өөр юу ч хэлэхэв дээ? Охид эмсийг үл хүндэлнэ, хүүхэд багачуулыг үл өрөвдөнө, өвгөд хөгшидийг үл

өршөөнө. Бүгдийг нэгэн адил өршөөл энэрэлгүй хороож алсан агаад хүн төрөлтөн бус харин ад чөтгөрийг санагдуулж байлаа. Шашин номын орон газар очихуйд эрхүүд хуврага нар ялагсдад энэрэл нигүүлслийг хүсэн тахил барьцаа өргөөд зохих хүндлэлийг үзүүлдэг ёсоор ариун номын жанчаа нөмрөн магтаал дууллаа уншсаар золгон очжээ. Гэвч хүмүүн ёс, өршөөл нигүүлслийг огтоос үл мэдэх Тартарууд шашин номын дэг ёсыг доромжлон эрхүүдийн энэрэнгүй даруу байдлыг элэглэн тохуурхаж сэлмээ сугалан өчүүхэн төдий өршөөлгүйгээр толгойг нь цавчин хаяжээ. Тэгээд сүм хийд рүү дайран орж цөлмөн тонож орд өргөөг нь түймэрдэн сүм шүтээнийг бузарлав. Тэд тахилын ширээг эвдэн унагаж улмаар дээдсийн шарилыг хэмхчин хаяж ариун номын хувцасуудыг эмс хүүхнүүддээ зориулан тасчин авчээ.⁴¹

41. Томас архидиаконы хувьд монгол цэргүүд, тэдний эмэгтэйчүүд, хүүхдүүд ч гэсэн ялгалгүй “хүн бус”, “араатнууд” тул “уугуул, төрөлх хэрцгий догшин” зан авиртай ажээ. Зохиогч ямар нэг довтолгоо, дайн тулааныг дүрслэх болгондоо юм уу эсвэл ямар нэг хядлагын тухай бичих болгондоо үүнийг библиээс гаралтай уран яруу найруулга, хэллэгээр илэрхийлдэг. Жишээ нь, Мохидахь тулалдааны дараа Унгарын цэргүүд “их ад түлигэнд аюун сандарч, чонын шүднээс зайлахыг оролдох хашаанд буй төлөг мэт ийш тийш бутран” зугтсан бөгөөд “зугтаж буй дайснуудаа зэвсгээ даахгүй гар нь цуцаж, алхаагаа хүчрэхгүй хөл нь туйвж эцэж байгааг мэдээд тэд араас нь жадлан цавчиж хэнийг ч үл өршөөн хядав. Тэд өвлийн навчис мэт баруунш зүүнш ханаран унаж, зам тэр чигтээ тарчлан зовогсдын хүүр цогцсоор дүүрээд их цусан гол урсаж авай”.

Зөвхөн дайн тулааны үед бус, ерөөс “өдөр өнжихгүй” үйлдсэн Тартаруудын харгис хэрцгийлэлд өршөөл энэрэл байхгүй гэсэн санааг илэрхийлэхийг зохиогч онцгойлохыг хүсэж байсан бололтой байдаг. Тиймээс тэрээр энгийн ард иргэдийг олноор нь хядаж устгасан тохиолдлуудыг харьцангуй дэлгэрэнгүй тоочсон: Киевийн Оросыг эзлэж хүн ардыг хядаад цааш явахдаа замдаа учирсан бүгдийг хядсан тухай, Мохийн тулалдааны дараа Унгарын вант улсын хот балгадын “тулалдах тэнхэлгүй эмэгтэйчүүд, хөгшид, хүүхдүүдийг” нүцгэлэн “гарыг өргүүлээд зүрхэнд нь мэс алгуур бүлж цөмийг хороосон” тухай, мөн дараагийн том тулалдаан болох Пестийн довтолгооны дараа түүнийхээр бол “ганцхан өдрийн дотор тэр өчүүхэн жижиг газар зуун мянга гаруй хүн хэрцгийгээр алагдсан” тухай, мөн тэндээс зугтаж доминикан ёсны сүмд хоргодсон арван мянган хүнийг түймэрдэн шатаасан тухай, Дунайн эрэгт “багачуул хүүхдүүдийг шорлож хатгасан загас мэт сэрвээ жаданд сүлбээд мөрний эргээр чирч явсан тухай”, Хорватад “Унгараас олзолсон бүх хүмүүсийг нэг газар бөөгнөрүүлж эр эм, хөвгүүд охидыг ялгалгүй цөмийг нэгэн хээр талд сүрэг хонь мэт тууж аваачаад” хядсан тухай, Спалато хотын гадуур “тариан талбайд тааралдсан эмс хүүхэн, багачуул хүүхэд, настан буурай хэнийг ч, тэр байтугай уяман өвчтэй хүмүүсийн амийг ч өршөөсөнгүй цавчин алсан” тухай, эцэст нь Бат, Хаданы цэрэг Булгараас гарч явахдаа “олзны хүмүүсийг өршөөж амь хэлтрүүлж буй мэт дүр эсгэн” суллаж “бөөнөөр хоёр, гурван бээр газар явж байхуйд гэнэт тэдэн дээр морин цэрэг довтолгон ирж илдээр цавчин цөмийг алаад талаар нэг хиаруулсан” тухай нийт найман хядлагын тохиолдлыг тоочсон байна. Энэ бол эргэн тойрондоо болж буй үйл

Бела ван Эзний ивгээлээр аймшигт хөнөөлөөс хэлтрэн цөөн нөхдийн хамт Австриа⁴² руу зугтан оджээ. Түүний дүү Коломаннус ван Дунай мөрний цаад эрэгт орших Пестиум хэмээгдэх том тосгонд хүрэв. Унгаруудын дийлэнх нь болон Дунай мөрний хоёр эрэгт амьдран суудаг өөр үндэстэнүүд цэргүүд бүхэлдээ сүйрч утсан тухай дайны эмгэнэлт үр дүнг дуулж мэдээд энэ газар дүрвэж ирсэн байжээ. Тэд суугуул болон тэнд цугларсан харь хотын энгийн олон ардад итгэж байв. Гэвч Коломаннус Эзний илдийг эсэргүүцэж чадна хэмээн бодож яаравчлан хэрэг төлөвлөж байсан тэднийг ятгаж болиулсан билээ. Оронд нь тэдэнд аюул осолгүй өөр газруудыг олж зугтахыг зөвлөсөн ажээ. Гэвч тэд үүнийг ухаалаг зөвлөгөөнд үзсэнгүйд Коломаннус тэднийг орхин Дравиум⁴³ голыг гэтлэн тэндээ орогнон суув.

Өмнө дурдсан улс, ийм ард ерөөс хэтэрхий бардам байдагчлан, байр бэхлэх, шуудуу ухах, хэрэм босгох, их өргөн шивээ хороолох зэрэг дэмий олон бэлтгэл бүгдийг хийж эхлэв. Гэвч тэднийг ажлынхаа хагасыг хийхээс ч өмнө Тартарууд гэнэт цөмрөн ирэв. Тэдгээр олон Унгаруудын ухаан санааг айдас хүйдэс, сандрал балмагдал эзэмдлээ. Балмад хэрцгий дайсны цэргийн даргач нар өлссөндөө галзууран уурсан өлөн хомхой чонос хоттой хонийг отож, тойрон шогших мэт өшиж хорссон харцаар хотыг бүхэлд нь ажиглан шинжилж Унгаруудыг хэрхэн үүрнээс нь гаргаж болох эсвээс хэрхэн сэлмийнхээ ирэн дор

явдлын учир шалтгааныг ойлгон ухаарах гэхээсээ илүү харийн түрэмгийлэгчдийн дайралт довтолгоогоор нөмрөн ирж буй аюул гамшгийг үзэж мэдэрсэн анхны туршлагаа хуваалцах нь зохиогчийн гол зорилго нь байжээ гэдгийг илтгэж байна. Тиймээс зохиогчийн монголчуудын харгис хэрцгийг тоочин дүрсэлсэн болгоныг түүхэнд болсон бодитой үйл явдлууд гэж үзэх аргагүй, аливаа “эго” сурвалжуудын адил зөвхөн нэг л өнцгөөс ойлгон ухаарч бичсэн гэдгийг онцлон тэмдэглэвэл зохино. Мөн түүнчлэн монголчуудын хэрцгий догшин болох тухай зохиогчийн энэ үзэл санаа нь ерөөс тухайн үед монголчуудын дайралт довтолгоо христийн шашинт ертөнцөд апоклиптик төсөөлөл, айдас хүйдэс бүхий сэтгэгдэл төрүүлж байсны нэг илрэл юм гэж хэлж болно. Гэхдээ дундад зууны шашинлаг цаг үеийн цуу ярианы шинжтэй ийм сэтгэлзүйн илэрхийлэлүүдийн нэлээдгүй хувь нь мөнхүү үеийн монголчуудын дайтах урлагийн нэг арга мэх болох айлган сүрдүүлэх зорилгоор зохиомлоор бий болгон тархааж байсан дайны суртал ухуулгаас улбаатай байжээ гэж өнөөгийн судлаачид үздэг. Иймд Томасын дурдсан монголчуудын “хэрцгийлэлүүд” бүгдийг түүхэнд бодитой болсон хэрэг явдлууд мөн хэмээн үзэхэд эргэлзээ төрнө.

42. Томас Бела ванг Австрийн гүн Фредериктэй (1230-1246) уулзсан тухай огт мэдээлэл өгдөггүй.

43. Дравиум (лат. Dravium) гэж Дунай мөрний нэг салаа, өнөөгийн Драва голыг хэлж буй.

хүчлэн оруулахаа харгис хүйтэн сэтгэлдээ бясалган бодож байв. Ийнхүү Тартарууд хотын гадуур хүрээлэн буудаллаад хотын бүх талаас нь дотогш үй олон сум харваж жадан мөндөр нүүлгэж довтолж эхлэв. Эсрэг талд, заяа нь харьсан Унгарууд эсэргүүцэхдээ бүх л хүчээрээ хамгаалахыг хичээж хавчаахай нумаар сум харваж дайсны байрлал руу үй түмэн жад шидэж чулуун урвуураар бөмбөг нүүлгэв. Гэвч Тартаруудын хөнөөлт сум цаг ямагт байгаа онож улам найдвартайгаар үхэлд хүргэж байв. Тартаруудын гараар онилон тавьсан суманд тэсч бүтэн үлдэх хуяг, бамбай, агсамж байсангүй. Хоёр, гурван өдрийн турш хоёр талын аль алинд ширүүн тулаан өрнөв. Золгүй энэ ард үлэмжийн их хохирол амссан юм. Зэвсэг барьсан гар нь цуцах тусам эсэргүүцэл нь улам суларч байв. Байрлал нь найдвартай бэхлэгдээгүй тул Тартарууд нэг л өдөр хот руу тулалдаан, эсэргүүцэлтэй тулгаралгүйгээр дайран оржээ⁴⁴.

Тэдгээр золгүй хүмүүст өршөөлгүй харгис хандсаныг өгүүлж баршгүй. Үнэн хэрэгтээ Пестиум хот бүхэлдээ тахалд нэрвэгдсэн байв⁴⁵. Тэнд эзэн тэнгэрийн цааз шийтгэлийн илд хэмжээгүй их Христийн цусаар хилэгнэн догширов. Тартаруудыг орж ирэхэд золгүй ард гараа зөрүүлж өвдөг сөхрөн хүзүүгээ илдний дор тавихаас өөр хийх ямар зүйл үлдэхсэн билээ? Зэрлэгүүдийн харгислал хичнээн цус урсавч ханашгүй, тэдний алж талах шунал хүсэл дуусашгүй их байлаа. Цавчин тасдах дуу чимээ яг л балт сүхээр бүхэл бүтэн аварга модон ойг хярган унагах лугаа адил сонсогдож байлаа. Хэрцгий балмад үхлийн хилэнгийн очис нүдний өмнүүр жирэлзэн өнгөрч эмс хүүхнүүдийн бархиран орилох, нялхас хүүхдийн чарлан уйлах чимээ тэнгэрт хадаж авай. Бүрлээчдийг замд нь үдэх, дотно хайртай хүмүүсийнхээ хойноос нулимс унагах, оршуулж булах цаг ч байсангүй. Булт нийтээр ад түлигэнд нэрвэгдээд хүн бүр өрөөлийн бус зөвхөн өөрийн үхлийн төлөө эмгэнэхээс аргагүйд хүрсэн байлаа. Эр эм, хөгшид хүүхэд ялгалгүй хөнөөлт илдэнд ам үрэгдэв. Хамгийн золгүй, гаслант тэр өдрийн үйл явдлыг хэн өгүүлэн өчиж зүрхлэх сэн билээ? Тийм олон хүн үхэж

44. Пест хот 1241 оны 4 дүгээр сарын сүүлээр монголчуудад эзлэгджээ.

45. Лат. Pestium (хотын нэр), Pestis (тахал, хөнөөл сүйрэл) хоёр адилавар бичлэгтэй тул “Revera in Pestio tota se pestis immersit” гэсэн өгүүлбэрээр Томас архидакон монголчуудын довтолгооны учруулсан сүйрлийг тахалтай зүйрлэн тэмдэглэлийнхээ энэ бүлгийг нэрлэсэн байна.

хоргодсоныг тоолж хэн чадахсан билээ? Ганцхан өдрийн дотор тэр өчүүхэн жижиг газар зуун мянга гаруй хүн хэрцгийгээр алагдсан юм. Ай, Дунай мөрний ус тэр чигтээ хүний цусанд будагдан улаанаар эргэлдэн байхыг өчүүхэн ч энэрэлгүй харж чадах шашин номгүй харь хүмүүсийн зүрх сэтгэл хичнээн харгис хэрцгий байсан гээ!

Үйлдсэн харгислалдаа сэтгэл ханасан тэд тосгоныг орхин одохдоо хаа сайгүй галдан түймэрдсэн бөгөөд дайсны нүдний өмнө хот агшин зуур бүхэлдээ үнсэн нурам боллоо. Амьд үлдсэн зол заяагүй энгийн ард хана хэрмэнд хашигдан хоргодвол амиа хоохойлж чадна хэмээн найдаж эхнэр хүүхдийн хамт Доминикан⁴⁶ эрхүүд нэрийн амьдран суудаг газарт хүрэв. Эзэн тэнгэрийн өмгөөлөөгүй үед бэхлэлт цайз ч тэдэнд тус болохооргүй байлаа. Тартарууд тэнд ирээд хамаг хүчээрээ дайрч бүх нийтээрээ сүйрэв. Арван мянга орчим золгүй хөөрхийс байр байшин, эд хөрөнгийн хамт түймрийн дөлөнд шатжээ. Энэхүү их, аюумшигт яргалалын гэрч нь болж оршуулаагүй цогцос бүхий аварга том ясан овоо сүндэрлэн үлдсэн авай.

Энэ хооронд Тартарын цэргүүд Трансилваниаг⁴⁷ бүхэлд нь хядаж Дунай мөрний чанад этгээдэд суух Унгаруудыг алж хөөгөөд тэдгээр газруудад саатан сууж бүх л зун, өвлийг өнгөрүүлэхээр болов. Дунай мөрний нөгөө этгээдэд амьдрагсдыг айлгахын тулд үхэгсдийн үй олон хүүрийг цуглуулан мөрний эрэг дагуу асар олон овоо босгосон байна. Бусад нь багачуул хүүхдүүдийг шорлож хатгасан загас мэт сэрвээ жаданд сүлбээд мөрний эргээр чирч явжээ. Эдүгээ тэдний олзлон дээрэмдсэн нь гэвэл хэмжээ хязгааргүй. Тэр олон агт морь, мал адгуусыг тоолж хэн чадахсан билээ? Эд баялаг, үнэт эрдэнэс гээд дайсныг баяжуулж баясгасан хэмжээгүй их олзыг тооцоолж хэн чадахсан билээ? Боол шивэгчний хүнд бэрхийг үүрсэн, хатуу ширүүн гяндан шоронд хоригдсон хичнээн олон олзны хүмүүс, хичнээн олон эрчүүд эмэгтэйчүүд, хөвгүүд охид байсан гээ!

46. Доминикан ёс (лат. Ordo Praedicatorum) XIII зуунд үндэслэгдэн байгуулагдсан Христийн Католик шашны дөрвөн их ёсны нэг бөгөөд III Онориус пап 1216 онд Францын Лион хотноо албан ёсоор хүлээн зөвшөөрсөн ажээ.

47. Трансилвания (лат. Transilvania). Унгарын дорнод хэсэг бүхэлдээ 1241 оны 4 дүгээр сараас 1242 оны 3, 4 дүгээр сарын хооронд Монголчуудын мэдэлд байсан билээ.

Христийн шашинт хүмүүсийн аймшигт хувь тавиланд гүнээ шаналсан шашин номын нэгэн хүмүүн бээр католик итгэл мандан бадарч христийн сүм хийдийн нэр хүнд олноо түгэж асан цаг мөчид нь Унгарын нутгийг тэрсүүд харь хүмүүсийн илдэнд сүйрэн сөнөхийг Бүхнийг бүтээгч эзэн яагаад зөвшөөрсний учрыг мэдэхийг эрмэлзэн хүссэнд нэгэн үдэш зүүдэнд үзэгдэн ийн хариулахыг сонсвой: “Бүү гайхтугай дүү минь, эзний шийтгэлийг шударга буст бүү үзтүгэй. Энэ ард түмний олон үйлийг Дээд Эзэн тэвчин нигүүлсэж чадах ч гурван бишопын хөнөөлт хүсэл, муу үйлийг хүлцэж үл чадмуй.” Харин бишоп нарын хэнд нь хамаатуулан хэлснийг би ялгаж ухаарч чадсангүй.

Бела ван Австрийг орхин гэр болон хамжлагуудаа дагуулан Загребиа⁴⁸ хотын орчимд ирж суужээ. Тартаруудын илднээс дутааж чадсан бүх хүмүүс түүнийг тойрон цугларав. [Дайны] төгсгөл хүлээн тэндээ бүх л зуныг өнгөрөөлөө.

37. Тартаруудын тухай

Одоо энэ ард түмний авир, төрхийн тухай цөөн хэдэн зүйлийг надаас илүү сонирхон судалсан хүмүүсээс дуулж мэдэж чадсанахаа хэрээр өгүүлье. Тэдний улс дорно зүг умард зүгтэй нийлдэг газар дэлхийн тэр хэсэгт оршдог⁴⁹ бөгөөд тэдгээр хүмүүсийг өөрсдийнх нь хэлээр бол

48. Загреб хот (лат. Zagreb) нь өнөөгийн Хорватын нийслэл. IV Бела ван 1241 оны 5 дугаар сарын 18-нд Загреб хотод иржээ. Эндээс папд тусламж хүсэж захидал илгээсэн байдаг.

49. Ерөнхийдөө Плано Карпинигаас өмнө Европын нийт христийн шашинт улсууд тэднийг халдан довтлогчид болох монголчуудын уугуул нутаг орны талаар дорно зүгээс ирсэн гэдгээс өөр төсөөлөлгүй байжээ гэдгийг Томасын энэ мэдээ гэрчилж байна. Карпини “Terra quidem predicta est in ea parte posita orientis, in qua oriens, sicut credimus, coniungitur aquiloni [Газар нутаг нь бидний төсөөлдөг шиг дорно умардтай нийлдэг зүүн зүгийн тэр хэсэгт оршиж байна]” (Carpine, Giovanni di Pian di. *Storia dei Mongoli*, ed. by Enrico Menestò, Maria Cristiana Lungarotti, Paolo Daffinà, Claudio Leonardi, Luciano Petech, Spoleto: Centro Italiano di Studi sull’Alto Medioevo, 1989, ch. I/3, 229 (үүнээс хойш Menestò/Carpine); Cf. Wyngaert, P. Anastasius Van Den (ed.) *Sinica Franciscana: Itinera et Relationes Fratrum Minorum Saeculi XIII et XIV*, vol. 1, Firenze: Quaracchi, 1929, 29). Карпинигийн *Historia Mongalorum*-тай төстэй өгүүлэмж де Бридиагийн *Historia Tartarorum*-д дурдагддагыг мөн харьцуулж үзнэ үү: “Sciendum igitur quod secundum Tartaros et quosdam alios habitabilis mundi huius machina dividitur in duas principales partes orientalem videlicet et occidentalem large sumptas secundum quod sul oritur et occidit estivo tempore et brumali... Reliqua vero pars dicitur orientalis, in qua posita est terra Tartarorum ubi oriens iungitur aquiloni, habens

Манголи хэмээн нэрлэдэг⁵⁰. Хэдий тийм ч гэлээ тэдний газар нутаг Алс Индиумтай⁵¹ хиллэдэг гэх бөгөөд тэдний хааны нэр Чекарканус⁵² болой. Тэр хаан эгчийг нь доромжилон алсан хөрш залгаа хаантай дайтсан бөгөөд тэрээр түүнийг ялж хороосон ажээ⁵³. Үүнээс гадна өөр нэг хаанд зугтан одсон түүний хөвүүнийг мөшгин хөөж байлдаад түүнийг болон түүнд тусалж өөрийнхөө улсад орогнуулсан хааныг бас алжээ.⁵⁴ Дараа нь мөн гурав дахь хил залгаа улс руу цэрэглэн очиж олонтаа тулалдаж ялаад өөрийн улс руу буцсан байна. Хувь заяа түүнийг бүх дайнд ивгээж буйг үзээд зүрх нь хөөрч өөрийгөө ихэмсэг бардамд өргөв. Энэ дэлхийд сүр хүчийг нь эсэргүүцэж чадах нэгээхэн

contiguum mare oceanum aquilonis...” (Skelton, R.A. et al. *The Vinland Map and the Tartar Relation*, New Haven and London: Yale University Press, 1965, ch. I/2, 54-55).

50. *Historia Salonitana*-д Тартар хэмээх нэрийг монголчуудад голдуу хамаатуулан хэрэглэсэн ч гэсэн Томас архидиакон Тартар болон Монгол хэмээх хоёр оноосон нэрийг ялгаж ойлгож байсан нь тун сонирхолтой юм. Энд монголчууд өөрсдийгөө “монгол” хэмээн дууддаг байсныг Томас итгэлтэй мэдээлдэг бөгөөд монгол гэдэг нэр Европын сурвалжид гарч буй анхны тохиолдол юм. *MHT*-ны *mongyol* болон Карпинигийн *mongali*-аас Томасын *mangoli* нь авианы зөрөөтэй буйг Томасын авсан мэдээлэлийн сурвалж аман уламжлал дээр тулгуурлаж байсантай холбож тайлбарлаж болох юм (de Rachewiltz, Igor. *Index to the Secret History of the Mongols*, Bloomington: Indiana University, 1972, 267; Menestò/*Carpine*, ch. V/1, 252). Тэгэхээр Томасын өгсөн энэ мэдээлэл 1236 оноос эхлэн Бат хааны Европ дахь христийн шашинт улсууд руу чиглэсэн аян дайны үед, тухайлбал Карпинигийн Монголын уугуул нутаг руу жуулчлан очихоос өмнө ямар ч байсан 1241 онд Монголчууд Европынхонд *moangoal* нэрээр танигдаж байжээ гэж дүгнэж болохоор байна (Үүнтэй холбогдуулан “Монгол” нэрийн *mo'al*, *mo'yal* хувилбарын тухай дэлгэрэнгүй тайлбарыг Serruys, Henry. “Mongyol: Mogal and Mangyus: Magus,” in *Acta Orientalia Hungaricae*, 36/1-3, 1982, 475-484-аас үзнэ үү).

51. Индиум (лат. Indium) гэж Инд мөрнийг хэлж буй. Алтайн нуруунаас Инд мөрөн хүртэлх газарт монголчууд суудаг хэмээн Томас өгүүлж байна.

52. Чингис хааныг Томас Чекарканус (лат. *Cecarcanus*) хэмээн эндүү нэрлэсэн. *Historia Salonitana*-аас өмнө буюу 1237-1238 онд Их Унгариаг хайж Башкируудын нутгийг зорин одож байхдаа Орос дахь Монголчуудын довтолгоотой учирч Монголын хааны хоёр элчийг Сүздальд нүдээр харсан гэрч болох Унгарын доминикан ёсны фриар эрхүүн Юлианы папд илгээхээр бичсэн захианд Чингис хааныг Гүргүтам (лат. *Gurgutam*) гэж нэрлэдэг.

53. Энд өгүүлж буй эгч гэдэг нь үнэн хэрэгтээ Чингисийн хатан Бөртэ юм. Бөртэ мэргидэд булаагдсны дараа Чингис мэргидэд довтолж ялсныг *MHT*-нд дурдсан байдаг. Өөр нэг хувилбарыг Юлианы захианаас олж мэдэж буй. Фриар Юлианы бичсэн тэмдэглэлээр бол монголын байлдан дагуулал нь монголчуудын толгойлогчдын нэг болон өөр нэг толгойлогчийн эгчийн хооронд үүссэн зөрчлөөс үүдэн гарсан бөгөөд уг эмэгтэй эцэстээ уруу татагдаж нас нөгцсөн тухай өгүүлдэг. Юлиан болон Томас архидиакон энэ өгүүлэмжийн тухай мэдээлэл үл ялиг зөрөөтэй боловч нэг эх үүсвэртэй болох нь илт байна.

54. Томасын энэ итгэл үнэмшил нь тухайн үед Европт тархаад байсан Прэстер Жоны домогтой холбоотой юм.

бээр ард түмэн, улс байхгүй хэмээн тэрээр сэтгэж улс бүрийг толгой дараалан эзлээд алдраа дуурсгахаар шийдсэн ажээ. Тиймээс итгэж дадсан албин чөтгөрийн ивээлдээ найдаж ертөнцөд өөрийнхөө хамаг суу залиг мэдүүлэхийг хүсчээ. Тэгээд Бат, Хадан хоёр хүүгээ дуудаж ирүүлээд цэргүүдээ даатган өгч харьд одож дэлхийн бүх улс мужийг эзлэхийг тушаажээ. Тийнхүү тэд харьд одож Рутенийн нутагт, эцэст нь доошилж Унгарт ирэх хүртлээ гучин жилийн турш дорно хийгээд умардын бүх газар нутгуудаар хэрэн дайтсан ажээ⁵⁵.

Харин Тартар гэдэг нэр тэдний өөрсдийгөө дууддаг нэр биш бөгөөд тэдний нутгаар урсан өнгөрдөг усны нэрээр ийнхүү нэрлэгдсэн, эсвээс зарим нь Татар гэх ба энэ нь олон гэсэн утгатай ажээ. Хэдий тэд асар олон тоотой байсан ч үнэндээ тэр тулалдаанд Унгаруудын цэргийн хүч тэднээс ч олон байсан гэдэг.⁵⁶ Гэвч [Тартаруудаас өөр] дайтахдаа тийм

55. Гучин жил гэдгийг Сүвээдэй, Зэв жанжны удирдсан цэргүүд Оросын вангийн цэрэгтэй тулалдсан Калка голын тулалдаанаас эхлэн тооцож буй. Өмнөх 9 дүгээр тайлбарыг үзнэ үү.

56. Карпини, Марко Поло зэрэг жуулчдын тэмдэглэлийн эхүүдэд мөн адил Тартар, Татар хоёр хувилбарыг аль алийг хэрэглэсэн байдаг (Рубрук, Гийом де. *Монголын эзэнт гүрэнд зорчсон нь*, орч. Ү.Төмөрхүлэг, Улаанбаатар: Адмон, 2000, 239). Томас ч гэсэн “Тартар гэдэг нэр тэдний өөрсдийгөө дууддаг нэр биш” болохыг онцлон тайлбарласан бөгөөд тэр бүү хэл тартар болон татар хоёр нэршлийг ялгаж байсан байж магадгүй нь тун сонирхолтой. *Historia Salonitana*-гийн үлдэж хоцорсон Спалато, Будапешт, Ватиканы гар бичмэлүүдэд энэхүү мөрийн “Tartar”, “Tatar” нэрүүдийг тогтвортой ялгаж бичсэн эх бичмэлүүдийг нарийвчлан судалсан судлаачид онцолсон боловч хамгийн эртний S болон T гар бичмэлүүдэд 37, 39 дэхь бүлгүүдийн гарчигийг нэрлэхдээ “De Natura Tatorum” болон “De Sevitia Tatorum” гээд харин нөгөө хоёр бүлгүүдийн гарчигийг *Tartarorum* хувилбартайгаар нэрлэсэн байдаг. Хэрэв үнэхээр дээр дурдсан гар бичмэлүүдэд бүлгүүдийн гарчиг ийнхүү *Tatar* хувилбараар нэрлэгдэж байсан бол Томасийн үе буюу монголчуудын эхэн үеийн аян дайны үед Европчууд *Tartar* гэдэг үг нь дан ганц *Tartarus* буюу Грек, Ромын сонгодог эртний үеийн домгийн тамын орны нэрээр бус харин түүнээс өөр утгатай *Tatar* гэдэг үгээс гаралтайг ялган мэддэг байжээ гэдгийн нотолгоо болно (*Tartarus* хэмээх тамын орны нэрээр монголчуудын “чөтгөрийн, ад зэтгэрийн” шинжийг нэрлэн ойлгох болсон энэ ойлголт харьцангуй хожуу Английн Гэгээн Албанийн санваартан Матю Парисийн түүх бичлэгээс хойш Европт газар авч түгж, *Tatar* нэршлийн бичлэг, утга мартагдсныг эрдэмтэд тайлбарладаг. Үүнтэй холбоотойгоор Jackson, Peter (tr.) *The Mission of Friar William of Rubruck: His Journey to the Court of the Great Khan Möngke 1253-1255*, London: The Hakluyt Society 1990, n. 4, 16-д удирдсан бүтээлүүдийн жагсаалтыг үзнэ үү).

Харин Татар гэдэг үгийн гол усны нэрээр нэрлэгдсэн утгын талаар Томасын өгсөн тайлбар өнөө болтол батлагдаагүй байгаа юм.⁵⁶ Татар үгийн утгын талаар адил тайлбарыг *Historia Mongalorum*-д: “ipsi autem se ipsos Tartaros appellabant, a quodam fluvio qui currit per terram eorum qui Tartar nominatur [Тэдний газар нутгаар урсдаг

их туршлагатай, эр зоригоор ч ухаан билгээрээ ч дайснаа, нэн ялангуяа тал хээрийн байлдаанд хэрхэн ялан дийлэхээ тийм сайн мэддэг ард түмэн энэ дэлхийд байхгүй.⁵⁷ Түүнчлэн тэд Христийн, еврейн, сарацен аль ч шашинд хамаарагддаггүй, тиймээс үнэнч шударгуу байх чанар тэдэнд огт байхгүй, ямар ч тангарагт итгэлийг дагадаггүй.⁵⁸ Бүхий л ард

Тартар хэмээх голын нэрээр Тартар хэмээн өөрсдийгөө нэрлэдэг...” (Menestò/*Carpine*, 252 (ch. V/1), 422; Cf. Wyngaert, P. Anastasius Van Den (ed.) *Sinica Franciscana: Itinera et Relationes Fratrum Minorum Saeculi XIII et XIV*, vol. 1, Firenze: Quaracchi, 1929, 29). Харин *Historia Tartarorum*-д: “Ipsi autem appellabant se Tartaros a fluvio magno et impetuoso qui transit terram eorum et dicitur Tatar” (Skelton, R.A. et al. *The Vinland Map and the Tartar Relation*, New Haven and London: Yale University Press, 1965, ch. I/3, 56). Ижил төстэй ийм мэдээг Карпини, де Бридиа бидэнд өгдөгийг харгалзан үзвэл бидний татар хэмээх үгийн тухай эдгээр баримтуудын үнэн ба үнэн бус эсэхээс үл хамааран дээрх үгийг Европын христийн шашинтнууд тухайн үед ийм тайлбараар ойлгож ухаарч байсан явдал нэлээд түгээмэл байжээ хэмээн таамаглахад хүрч байна (Энэ хоёр түүхэн хүний болон тэдний бүтээлийн хооронд ямар холбоотой байж болохыг нэхэн судлууштай. Шмийдер Томасыг Карпинигийн тэмдэглэлийг уншсан байж магадгүй хэмээн таамагласан ч үүнийг нотлох баримт огт байхгүй (Schmieder, Felicitas. *Europa und die Fremden: Die Mongolen im Urteil des Abendlandes vom 13. bis in das 15. Jahrhundert*, Jan Thorbecke Verlag: Sigmaringen, 1994, 202 (n. 19), 289).

57. Хэдий Спалато хотын архидиакон монголчуудын хүмүүн бусын хөнөөлт хэрцгий догшин, өршөөл энэрэлгүй зан авирыг буруутган зүхсэн ч гэсэн Монголчуудын дайтан тулалдах харьцуулшгүй, эгнэшгүй ур чадварыг хүлээн зөвшөөрч, тэдний дайтах чадамж, зэр зэвсгийг сониучирхан олон зүйлийг тэмдэглэсэн байдаг. Түүний тулаан, байлдааны тухай өгүүлэмжид Монголын цэргүүд Унгарын вант улсын цэргүүдийг хүч чадлаар бус, харин ямар нэг санаанд оромгүй арга мэхээр (4 удаа), заримдаа ид шидийн гэмээр (3 удаа), эсвэл “албин чөтгөрийн” удисын хүчээр (1 удаа) ялж байсан тухай зүйрлэж бичсэн метафорууд цөөнгүй байна: Монголчуудын харвалтад өртсөн Унгарын цэргүүд “их салхинд эгсэргэдэн шидэгдэх царс модны боргоцой мэт энд тэнд үй олноороо ханаран унасан”, Карпацийн нуруугаар давж ирсэн монголын алгинч 40000 балт сүхтэй цэргүүд Унгарын вангийн бэхлэлтийг “бүхэл бүтэн аварга модон ойг хярган унагах лугаа адил” эвдсэн, монголын цэргүүд “нэг ч цэргийн хүч өмнө нь гэтлэн давж чадаагүй эзгүй ээрэм газар, эгц цавчим уулсыг туулж газраар явган бэдрэх бус, харин тэнгэрээр нисэн дүүлэх мэт” давдаг, Чингис хаан албин чөтгөрийн ивээлээр өөрийнхөө суу залиг мэдүүлэхийг хүссэн гэх мэт. Эдгээр зүйрлэлүүд хэдий уран зохиолын яруу найруулгын шинжтэй (реторик) боловч өнөөгийн түүхч, судлаачдад тухайн үед монгол цэргийн хүчин чадавх, дайтах урлагийн талаар нүдээр үзэж, чихээр сонсож байсан гэрчүүд сэтгэлзүйн хувьд хэрхэн мэдэрч ойлгож, хүлээж авч байсан тухай тун чухал баримт мэдээг өгч буй юм.

58. Энэ мэдээ нь христ, еврей, исламын шашныг шүтэх нь түүн шиг сүсэгтэн хүний хувьд хүмүүсийн хоорондын харилцаанд заавал байх ёстой үндсэн хэм хэмжээнүүдийн нэг, өөрөөр хэлбэл эдгээрийн аль нэг шүтлэг хүнд үгүй бол түүнд ёс зүйт хамгийн энгийн зан чанарын хэмжүүр болох үгэндээ хүрдэг итгэлтэй, үнэнч чанар байхгүй байна гэсэн үг гэж ойлгогдож байна. Монголчуудад ийм үнэнч шударгуу байх зан үгүй учир бүрэн утгаараа харийн хүмүүс (*gens pagana*) ажээ. Нэг

түмний ёс заншлын эсрэгээр дайны үед ч, энхийн үед ч элчин төлөөлөгчдийг хүлээж авдаггүй, мөн илгээдэггүй.⁵⁹ Тэдний нүүр царай үнэхээр аюумшигт төрхтэй. Богино хөлтэй ч аварга том цээжтэй. Нүүр нь өргөн, арьс нь цагаан. Хацар нь сахалгүй, хамар нь монхор, нүд нь нарийхан, хоорондоо хол зайтай.⁶⁰ Тэдний агсамж гэвэл бухын ширэн тушмуудыг холбон хэлхсэн хуяг байх бөгөөд тэр нь сум үл нэвтрэх маш бат бөх болой. Тэд төмөр юмуу арьсан дуулга өмсдөг, тэдний илд нь махир, ховд нумаа цэрэг маягаар бүсэлж зүүдэг. Тэдний сум манайхаас дөрвөн хуруу урт бөгөөд төмөр, яс, эврэн үзүүр бүхий зэвээр ялгагдана. Сумнуудын ховил нь бидний нумын хөвч орохооргүй нарийн байдаг. Тэдний туг богино, хар болоод цагаан өнгөтэй байх агаад оройдоо ноосон бөмбөгтэй. Агт морьд нь намхан давжаа боловч хүч тэнхээтэй, өлдөх хийгээд цуцахыг үл ажрах тэвчээртэй. Тэд хөдөөний тариачдын маягаар морь унадаг. Морьд нь тахгүйгээр хад чулуун дээгүүр зэрлэг ямаа дүүлэх мэт давхидаг. Гурван өдрийн турш тасралтгүй унасны дараа ч өчүүхэн төдий өвс тэжээлд цаддаг. Хүмүүс нь мөн адил идэж

талаар тухайн үед дундад зуунд оршиж байсан христийн шашны итгэл үнэмшил, үзэл санааг, нөгөө талаар зохиогчийн баримтын эх сурвалж авах боломж хязгаарлагдмал байсныг харгалзан үзвэл монголчуудыг *паган* буюу ямар нэг (нэн ялангуяа христийн) итгэл сүсэггүй, харийн хүмүүс хэмээн хэдэнтээ (2 удаа) тодорхойлж буй архидиаконы үгсийг бид бүрэн ухаарч болно. Үнэндээ XIII зууны эхэн үед монголчуудын дунд гүн нэвтэрсэн Европын христийн шашинтнуудын аян замын тэмдэглэлд монголчуудын үнэнч шударга, эв найртай талаар гайхан магтсан мэдээнүүдийг өгсөн байдаг (Menestò/Carpine, ch. IV/2, 347-348).

59. Элчин харилцааны тухайд дурдаж буй үед Монголын эзэнт гүрний дипломат харилцаа өндөр түвшинд хүрсэн байсныг судлаачид бичдэг. Жишээ нь, Унгарт довтлон орохоосоо өмнө Бат хаан Унгарын ванд 30 удаа элч илгээж байсан тухай Унгар санваартан Юлианы сурвалжид дурдсан байдаг. Харин 1245-1247 оны хооронд монголчуудын Европын христийн шашинт ертөнцтэй харилцах дипломат харилцаанд өөрчлөлт гарсаныг дурдах хэрэгтэй юм. Түүнээс өмнө Монголчууд Европын улсуудад тулган шаардах бичиг (ultimatum) явуулж байсныг зарим судлаачид онцлон тэмдэглэсэн (Bezzola, Gian Andri. *Die Mongolen in abendlandischer Sicht (1220-1270): ein Beitrag zur Frage der Volkerbegegnungen*, Bern and München: Francke Verlag, 1974, 99) байдаг ч үнэндээ тийм тулган шаардах бичгүүд ихэвчлэн Монголын эзэнт гүрний элчинг хороосон явдлаас үүдэн бичигдсэн байдаг билээ.

60. Монголчуудын гадаад төрхийн талаар одоогоор мэдэгдээд буй Европын анхны мэдээг *Historia Salonitana* өгч байна. Энэ мэдээг Карпинигийн тодорхойлолтой харьцуулна уу: “Тэдний гадаад байдал нь бусад бүх хүмүүсийнхээс өөр: нүдний хоорон дахь зай болон хацар нь бусад ард түмнүүдийнхээс том. Хацар нь эрүүтэй нь харьцуулбал маш өргөн. Хамар нь хавтгай, өргөн. Нүд жижиг... Цөөхөнийг эс тооцвол эрчүүд нь ерөнхийдөө туранхай, бараг бүгд намхан нуруутай. Сахал бараг бүгдэд нь бага ургасан. Гэвч зарим нь бахал болон живэр сахалтай, тэдгээрээ ховор засна” (Menestò/Carpine, ch. II/2, 340).

уухдаа маш бага санаа тавьдаг, харгис хэрцгий үйлдэл бол тэдний цорын ганц идэш болой. Талхыг үл үзэх бөгөөд махыг цэвэр, бохир ялгалгүй иддэг. Тэдний унд бол адууны цусаар өтгөрүүлсэн сүү юм.⁶¹ Дайн тулаанаар эрхэндээ оруулсан олон янзын үндэстэнүүдээс асар олон эрчүүдийг, нэн ялангуяа Кумануудыг цэрэгт татсан бөгөөд тэднийг хүчээр тулаанд оруулдаг. Айж мохох буюу үхэхдээ ухаан санаагаа бүрэн алдаж солиорох өчүүхэн төдий тэмдэг үзэгдэгдэх аваас ямар ч эргэлзээгүй толгойг нь цавчина. Тартарууд өөрсдийгөө үхэхүйд дураар ил тавьдаггүй. Хэрвээ тэдний хэн нэгэн тулалдаанд эрсдэх явдал тохиолдвол тэр даруй холдуулж зөөгөөд хамгийн нууц газарт булж оршуулдаг агаад дээрх овгорыг тэгшилж агт морьдын туурайгаар гишгүүлж оршуулгын ямар ч ул мөр үлдээлгэдэггүй.⁶² Түргэн урсгалт

61. Энэ мэдээ нь ерөнхийдөө тухайн үеийн бусад сурвалжуудын мэдээнд дурдагддагтай адил байна. Монголчууд талх иддэггүй тухайд 1223 оны эхээр монголчуудын Оросуудыг довтолсон тухай эхний мэдээ Балтийн тэнгисийн баруун эргийн хотуудад хүрч байх үед Ливонийн Хэнри хэмээгч нэгэн түүхч адил төстэй мэдээ тэмдэглэж үлдээсэн байдаг ажээ. Түүний бичсэнээр монголчууд талх иддэггүй, харин малынхаа түүхий махыг иддэг ажээ (*Heinrici Cronicon Livoniciae*, Ch. 26/1, энэ мэдээг Peter Jackson. “Medieval Christendom’s Encounter with the Alien,” in *Historical Research* 74/186, 2001, n. 52, 352-аас дам авав). Халдан довтлогсдын түүхий мах иддэг энэ мэдээ тухайн үеийн Европын христийн шашинт ертөнцөд янз бүрийн хувилбараар түгсэн байдаг. Харин Томас “харгис хэрцгий үйлдэл бол тэдний цорын ганц идэш болой”, “адууны цус уудаг” хэмээн бичсэн байх ажээ. Харин адууны цус уудаг байсан тухайд монгол цэргүүд урт аян дайны явдалд мориныхоо хөлд буусан цусыг ханаж эмчлэх юм уу зарим тохиолдолд өөрсдөө эцэж ядарсан үедээ малын цус ханаж уудаг байсныг тэмдэглүүштэй. Жишээ нь, МНТ-нд Хэрэйдийн Ван ханыг Уйгур, Тангудын газраа бядан зорчихуй унаж явсан тэмээнийхээ цусыг ханаж идэж байсан тухай тэмдэглэсэн буй (de Rachewiltz, Igor. *Index to the Secret History of the Mongols*, Bloomington: Indiana University, 1972, 69, §151).

62. Энэ мэдээг сүүлд Карпини, Рубрук зэрэг өрнө, дорнын аянчид батласан: “Нүхийг эргэн булаад тэр булшийг хэн ч, хэзээ ч дахин олохооргүй болгохоор үндэстэй нь авсан хөрсийг эргүүлэн суулгана” (Menestò/Carpine, ch. III/13, 346); “Нас барсан хүний оршуулсан газрыг үл мэдэгдүүлнэ. Язгууртан хүмүүсээ оршуулсан газрын эргэн тойронд ямагт булшыг харж хамгаалах хүмүүсийн хүрээ буудал байдаг” (Jackson, Peter (tr.) *The Mission of Friar William of Rubruck: His Journey to the Court of the Great Khan Möngke 1253-1255*, London: The Hakluyt Society, 1990, ch. VIII/4, 95); “Хүн оршуулсан газраа адуугаар гишгүүлж, газраа тэгшилдэг. Тэмүжиний онгон булшийг тойруулан сум шороог хатгаж хүрээ болгоод морьт харуул манааны хамгаалалттай юм... өвс ногоо хөхөрсөн хойно сая харуул манаагаа татаж, тэр цагт газар нь нэгэнтээ төлжиж эрүүл болсон тул түүний ормыг дахин шинжин ирэхээ больдог болно” (Баясах, Ж. *Их Монгол улсын түүхэнд холбогдох хятад хоёр сурвалж бичиг*, Улаанбаатар: Адмон, 2006, 282, Мэнда бэйлу 30а). Монголчуудын зан үйлийн талаар дэлгэрэнгүйг Pelliot, Paul. *Notes on Marco Polo*, vol. 1, Paris: Imprimerie Nationale, Librairie Adrien-Maisonneuve, 1959, 335-363-аас үзнэ үү. Ийм харуул хамгаалалттай оршуулгын газрыг *yeke qorug*, харуулыг *qorugči* хэмээдэг

голын ус тэдэнд ерөөс саад болдоггүй, мориндоо мордож гатална. Гэтэлж чадахааргүй урсгал устай тааралдвал тэр даруй сагс хайрцгуудыг сал хэлбэртэй холбож малын түүхий ширээр хулдан бүрж дотор нь эд хошоо оруулж ачаад айдас түгшүүргүй гаталдаг. Гэр майхнуудаа эсгий, арьсаар хийдэг. Агт морьдоо маш сайн гаршуулдаг ба эзэн нь нохдоо дагуулах мэт нэг л хүн агтаа олноор нь хариулан явмуй. Тэдгээрийн дунд хэлгүй юм шиг бараг дуу гаргадаггүй, гэвч чимээгүй явж чимээгүй байлддаг олон хүмүүс бий.

Эл товч удиртгалын дараа гол асуудал руугаа эргэж орохыг зөвшөөрөх амуй. Тэд Унгаруудыг эцэслэн дийлж энэхүү аймшигт сүйрэлийн тухай мэдээ асар хурдан зүг бүхэнд тархахуй дэлхий ертөнц бараг бүхэлдээ дагжин чичрэв. Бүх муж айдаст автаж хэрцгий догшин гараас нь амь мултарч чадна гэдэгт хэн ч итгэхгүй байв. Ромын эзэн хаан Фредерикус ч гэсэн эсэргүүцэхийн оронд нуугдахыг бодож байсан гэдэг.⁶³ Түүнчлэн олон номт мэргэд эртний судар шастируудын хуудсыг эргүүлж ялангуяа мартир Методиусийн⁶⁴ үгст тулгуурлан

(Barthold, V.V. "The Burial Rites of the Turks and the Mongols," in *Central Asiatic Journal* 14/1-3, 1970, 205).

Тэр ч бүү хэл, үнэхээр монголчуудын оршуулгын нууц газар Унгарт байсныг Карпини нүдээр үзэж харсан байдаг: "Тэдний газар хүн тавьдаг хоёр газар бий: Эхнийхд нь хаад ноёд, түшмэл, жанжинуудыг хаана нас нөгчсөнөөс хамаарахгүй энд зөөж авчирч их хэмжээний алт мөнгөний хамт нутаглуулна. Нөгөө газарт нь Унгарт нас барсан хүмүүсийг тэнд авчирч оршуулна. Үнэхээр тэнд тэдний олонхи нь алуулсан байдаг ажээ. Тэр газар тусгайлан томилогдсон харуул манааны хүмүүсээс өөр хэнд ч орох эрх үгүй. Хэрэв хэн нэгэн хүн орвол тэр дороо баривчлагдаад, нүцэглүүлэн ташуурдуулж зодуулна. Энэ тухай мэдээгүй бид нэгэн удаа Унгарт алуулсан хүмүүсийн оршуулгын тэр газрын хилийг санаандгүй давсанд тэнд байсан харуул манаа нь биднийг нум сумаар харвах гэсэн билээ. Гадаадын элч учир нутгийн заншил мэдэхгүйг тэд харгалзан үзэж энэ газраас холдохыг хүссэн юм." Карпинигийн дурдсан Унгар дахь оршуулгын газар нь Томасын мэдээлсэн 1241-1242 оны Унгар дахь дайн тулааны үед амь үрэгдсэн цэргүүдийн цогцсийг "холдуулж зөөсөн" оршуулгын газар байсан бололтой.

63. Ариун Ромын эзэнт гүрний хаан II Фредерикийг хэлж байна. Тэрээр 1241 оны 6 дугаар сарын 20-нд Ромын сенатад Унгарын сүйрлийн тухай мэдэгдэн, цааш Монголчуудын довтолгоог эсэргүүцэн тэмцэх бодолтой буй тухай захиа үйлдэн илгээж байжээ. Мөн 1241 оны 7 дугаар сарын 3-нд эзэн хааны удирдлагаар бүгд нийлэн хамгаалахыг уриалан Европын вангуудад захидал илгээж байсан байна. Энэ тухай Sweeney/HS, n. 1, 286-ийг үзнэ үү.

64. Гэгээн Методиусын зөгнөл. Түүнийг Хуурамч-Методиус ч (Pseudo-Methodius) гэж нэрлэдэг. VII зууны үед Сирийн Хуурамч-Методиус хэмээгчийн *Харилцан яриа* (Sermo), *Илчлэл* (Revelations) хэмээх зохиолд эртний Арабуудын байлдан дагуулалын нөлөөгөөр бичигдсэн зөгнөлт домгоос үүдсэн Гог, Магогуудын тухай домог байсан

эдгээр хүмүүс бол Антихристийг ирэхээс урьтаж ирэх ёстой тэр хүмүүс мөн хэмээн дүгнэсэн билээ. Ром хотыг чиглэн замдаа дайралдсан бүгдийг хиаруулан сүйтгэнэ хэмээн таамнаж хот цайз бэхлэн барих боллоо.

Бела вангийн тухайд тэрээр Тартаруудыг Дунай мөрнийг гатлан үлдсэн улсыг хөнөөнө хэмээн айж Албарежа⁶⁵ хот руу одоод Гэгээн Стефан вангийн цогцосийг олон сүм хийдийн үнэт эрдэнэсийн хамт авч цөмийг эрхт Мариа хатан болон хоёрхон настай Стефано хэмээх бага хөвүүнтэйгээ⁶⁶ цуг далайн эргийн нутаг руу илгээж Спалато хотын оршин суугчдаас үнэт эрдэнэсүүдийг хадгалж хатан хөвүүн хоёрыг итгэлтэй хамгаалахыг хүсэж даатгавай. Эрхт хатан ирээд Спалато хотынхонд хар элэгт хүмүүсийн ятгалгад орж Спалато хот руу орохыг хүссэнгүй, оронд нь бүх эрдэнэсийг аван Клиссиум⁶⁷ цайзад суухаар

ажээ. Хуурамч-Методиусын домог ёсоор Персийн эзэнт гүрэн мөхсөний дараа дэлхий ертөнцийг Етриб хэмээх газраас гаралтай Исмайлууд болон Их Александр хааж босгосон хаалгыг эвдэж уулын араас гарч ирсэн ариун бус ард түмнүүд эзлэн авч дөчин ес жил болж Ром хотыг эзлэх бөгөөд Антихрист ирж ертөнцийг сөнөөхөөс өмнө энэ үйл явдал болох ёстой ажээ. Түүний эдгээр зохиолд эл исмайлуудыг арабуудаар төлөөлүүлэн бичсэн тул хожим нь Лал шашинтнуудыг Өрнөдийн христийн шашинт улсууд исмайлууд хэмээн нэрлэх болсон байна. Гэхдээ энэ зөгнөл нэг их түгж дэлгэрээгүй XII зууныг хүргэж, харин энэ үед латин хэлнээ орчуулагдснаар мөнөөх Исмайлууд нь Гог, Магог хэмээгч зэрлэг хэрцгий улс үндэстнээр солигдон тухайн үед эдийн засаг, шашин, соёлын хувьд хүчээ авч нөлөөгөө дэлгэрүүлж байсан латин хэлт христийн ертөнц, түүний нөлөөний улсуудад түгж тархах болсон байна. Монголчуудыг Гог, Магогуудтай зүйрлэсэн домгийн тухай ямар нэг хэмжээгээр хөндсөн судалгааны бүтээлүүд маш олон байдагаас Jackson, 2001, 348-349; Jackson, Peter. *The Mongols and the West 1221-1410*, Harlow et al: Pearson Education, 2005, 21-22; Klopprogge, Axel. *Ursprung und Ausprägung des abendländischen Mongolenbildes im 13. Jahrhundert: ein Versuch zur Ideengeschichte des Mittelalters*, Harrassowitz Verlag, Wiesbaden, 1993, 153-169; Schmieder, Felicitas. *Europa und die Fremden: Die Mongolen im Urteil des Abendlandes vom 13. bis in das 15. Jahrhundert*, Sigmaringen: Thorbecke, 1994, 258-285; Гиессауф, Йо. “Тамын орны амьтанаас поп дууны шүлгийн баатар хүртэл. Европууд Чингис хааныг хэрхэн мэддэг болсон тухайд”, Баркманн, У.Б. (эмх.) *Чингис хаан хийгээд түүний өв*, Улаанбаатар: Адмон, 2007, 129-138-ийг үзнэ үү.

65. Албарежа хот (лат. Alba Regia, унг. Székesfehérvár) нь өнөөгийн Унгарын Сэксэфехэрвар хот бөгөөд Будапешт хотоос баруун өмнө зүгт 65 км-т оршино.

66. IV Бела вангийн хатан Мариа (лат. Maria) болон залгамжлагч ван V Стефанус (лат. Stephanus, 1270-1272 оны хооронд ванийн ширээнд суужээ). Спалато хотын латин захирагчид болон Унгарын ихэс дээдсийн хооронд таарамж муу байсан тухай энэ сэтгүүлийн өгүүлэлд миний бичсэнийг үзнэ үү.

67. Клисс цайз (лат. Clissium, хор. Klis) нь Хорватын Спалато хотын ойролцоо далайн эргээс 11 км зайд уулархаг нутагт орших бэхлэлт цайз юм.

одов. Тартаруудад эр нөхрөө алдсан олон язгууртан эмс түүнтэй хамт ирсэн байв. Гаргано подеста⁶⁸ болон Спалато хотын язгууртан ноёд эрхт хатанд очиж түүнийг хотод суурьшихыг соёрхоно уу хэмээн хичээнгүйлэн гуйсан ч хатан хүлээж авсангүй. Спалато хотынхон түүнд олонтаа айлчилж их хүндлэлийг үзүүлэн их өглөг бэлэг баривай.

Энэ үед Коломаннус ван хутгийг олж Эзэн Дээдэст одчухуй⁶⁹. Тэр бол нийтийн хэргийг захиран шийтгэхээс илүү энэрэл нийгүүлсэл шашин номд биеийг зориулсан хүн байсан бөлгөө. Түүнийг Чезма⁷⁰ хотод номлогч фриаруудын⁷¹ дунд нууц бунханд оршуулав. Ад зэтгэрийн Тартар хүмүүс христийн шашны булш бунхнуудыг бузар гараараа түйвээсэн бөгөөд тэр дундаа ихэс ноёдын оршуулгыг сүйтгэн балласан билээ.

38. Унгарууд зугтсан тухай

Нэгдүгээр сар⁷² өнгөрч ер бусын хатуу, хахир өвөл болов. Асар их хүйтэрч бүх усан хөлдөж дайснуудад амархан гэтлэх зам нээгдэв. Цусанд улайрагч Хадан даргач цэргүүдээ хураан ванг мөшгихөөр хөдөллөө. Дайсны цэргүүд асар олон байсан агаад давшин явахдаа замд дайралдсан бүгдээ хядаж байв. Эхлээд Будаалиа⁷³ хотыг үнсэн нурам болгов. Дараа нь Стригониумд хүрч хамаг хүчээрээ бүслэв. Хотыг их бэрхшээл саадгүй эзлэн авч түймэрдээд бүх иргэдийг нь цавчин алсан ч Унгарууд бүх эд хөрөнгөө өндөр цайзад нүүлгэн аваачсан байсан тул бага хэмжээгээр тонож дээрэмдэв. Тэгээд тэд хотыг орхин шууд

68. Гарганогийн тухай товч тайлбарыг 4 дүгээр тайлбараас үзнэ үү. Подеста (лат. potestas, унг. podestà) нь эрх мэдэл, хүч гэсэн утгатай латин үгнээс үүсэлтэй үг бөгөөд анх Италид XII зуунд бий болсон хотын даргачад дүйх хэргэм цол юм. Тухайн үед Унгарын вант улсын харъяанд байсан Хорватын Спалато хотынхон хотын засаглалын хэлбэрээ өөрчлөн “латин засаглал”-ыг авч хэрэгжүүлэхээр шийдээд Италийн хотуудын жишгээр хотын даргачаа подеста хэмээн нэрлэх болжээ.

69. 1241 оны 6 дугаар сар

70. Чезма хот (лат. Cesma, хор. Čazma) нь өнөөгийн Хорватын Чазма хот. Загребаас зүүн өмнө зүгт 60 км-т оршино.

71. Доминикан ёсны фриар (лат. frater ordinis praedicatorum). 45 дугаар тайлбарыг үзнэ үү.

72. 1242 оны 1 дүгээр сар

73. Томас Будаалиа (лат. Budalia) гэдэгт Унгарын вант улсын Буда хотын цайзаас хойш 4 км-т орших хэсэг хотуудыг хэлсэн болов уу хэмээн Свийнэй таамаглажээ (Sweeney/HS, n. 4, 289; *Der Mongolensturm: Berichte von Augenzeugen und Zeitgenossen, 1235-1250*, Graz, Wien and Köln: Styria, 1985, n. 36, 267-ыг үзнэ үү).

Албарежиа хот руу давшив. Тэрбээр дөнгөж ирмэгцээ хэрмийн гадна орших байр сууцуудыг галдан шатаав. Дараа нь хотыг бүсэлж хэдэн өдрийн турш хамаг чадлаараа дайрч эзлэв. Гэвч энэ газар намгийн усаар хүрээлэгдэж маш сайн бэхлэгдсэн байлаа. Мөн Латинчуудын шилдэг хамгаалалтууд тэнд байсан⁷⁴ бөгөөд тэд хаа сайгүй машин урвуур угсран босгож хамгаалав. Тэрхүү ад зэтгэрийн даргын сэтгэл гонсойж хүч хөдөлмөр нь талаар болсонд холдон явлаа. Хэдий тийм боловч тэрээр ванг барихаар яарчээ. Тэрбээр замдаа тийм ч их түйтгэр учруулж завдаагүй ч зуны аадар борооны мөндөр мэт өнгөрч гарсан газруудаа л сүйтгэж байлаа.

Дравиум мөрний их усанг гатлахаасаа өмнө ван ирж буйгаа мэдэгдэн урьдчилан зарлаад Загребийн орчимд харуулууд орхиж бүх дагалдагсдын хамт тэнгист гарав. Тийнхүү тэд зүг бүхэнд дүрвэн зайлж тэнгисийн эргийн зугтаахад дөхөм ойр бүх хотуудад тархан дайжлаа. Ван болоод үлдэж хоцорсон Унгаруудын хамгийн шилдэг цэргүүд Спалато хотын нутагт ирэв. Энэ үед ванг дагалдагсадын дунд сүм хийдийн хутагт хуврагууд, хунтайж, баронууд олноороо байв. Мөн түүнчлэн эр эм энгийн ард дүрвэгсэд ч тоолж барамгүй олон байлаа. Ван хотын хаалганд дөхөж ирэхэд хотын бүх эрхүүд, ард олон хотоос жагсан гарч зохих бүх ёслол хүндэтгэлийг түүнд үзүүлж хүссэн тоогоор нь орд өргөө бэлдэж өглөө. Түүнтэй цуг эдгээр эрхэм дээдсүүд ирсэн болой: Загребийн бишоп Стефанус⁷⁵, Стригонийн архиепископоор сонгогдож асан Вачийн Стефан⁷⁶, Албарежиагийн провост, вангийн ордны сайд, Колоченсийн бишопд сонгогдож буй Бенедиктус⁷⁷,

74. Томас архидиакон энд латинчууд гэдэгт тухайн үед Унгарын вант улсын Албарежиа хотод төвлөрөн байрлаж байсан Оспиталлер хөлөг баатруудыг холбогдуулан хэлжээ. Оспиталлер хөлөг баатруудын ёс нь 1023 онд Ерусалемд Анхны загалмайтны аян дайны үед *Ариун Нутгыг* (Terra Santa) зорих шархагдсан, ядарсан, өвдсөн мөргөлчдөд эмнэлэгт туслаж сувилах зорилгоор байгуулагджээ.

75. Загребийн бишоп II Стефан (лат. Stephanus episcopus Zagrabienensis). Папын тушаалаар 1225-47 оны хооронд Загребийн бишопоор сонгогдож байв. Тэрээр мөн вангийн тэргүүн сайд байсан ажээ.

76. Вачийн Стефан (лат. Stephanus Vacciensis, 1270 онд нас баржээ). Тэрээр Вач хотын (унг. Vač) бишоп болохоос өмнө хааны тэргүүн сайд, Вач хотын провост байжээ. Мох хот дахь тулалдааны үеэр Эсцтергомьн бишоп Матиас нас барсаны дараа түүнийг энэ хотын архиепископ болгосон байна.

77. Бенедиктус (лат. Benedictus, 1261 онд нас баржээ). 1239-1240 оны хооронд хааны дэд сайд, Буда хотын провост байжээ. Мох хотын тулалдаанд Калоча хотын

Куинкуеэक्клезиумийн бишоп Бартоломэус⁷⁸ болон бусад бишопууд. Мөн Чезмиумийн провост Угринус⁷⁹, Ахиллэс провост⁸⁰, Винценциус провост⁸¹, Томас провост⁸² болон өөр бусад энд нэрийг нь дурдах шаардлагагүй олон тооны хутагт санваартнууд байв. Бас вангийн ордны тэргүүн ноёд байв: захирагч бан Дионисиус⁸³, өмгөөлөгч гүн Владислаус⁸⁴, эрдэнэсийн сангийн даамал Матеус⁸⁵, агтын даамал Орландус⁸⁶, Димитриус⁸⁷, Маурициус⁸⁸ зэрэг өөр олон сурвалжит хүмүүс, бүгд гэр бүл, дагалдагсдын хамт байв. Подеста Гаргано ванд хичээнгүй, үнэнчээр үйлчилж хотын иргэд вангийн зарлигийг бэлхнээ гүйцэтгэж, харин өршөөлт ван хотын бүх иргэдийг нигүүлсэл хайраар тэтгэхийн аль алиныг хангахын тулд хичээнгүйлэн зүтгэсэн билээ. Үнэндээ Спалато хотын оршин суугчид нэг зүйлийг эс тооцвол вангийн таалалд бүрнээ нийцүүлсэн. Тэр нь ванг Тартаруудын хилэнгээс аврахын тулд зориулан хийх ёстой сэлүүрт завийг хүссэн ёсоор нь яаралтай бэлэн болгож чадаагүй явдал байсан юм. Энэ явдал вангийн

-
- архбишоп Угринус амь эрсэдсэн тул 1241 оны 9 дүгээр сард уг хотын архбишопоор сонгогдоод байсан байна. Хожим нь 1254 онд Эсцтергом хотын архбишоп болжээ.
78. Куинкуеэक्клезиумийн Бартоломэус (лат. Bartholomeus Quinqueecclesiensis, 1253 онд нас баржээ). Куинкуеэक्клезиум (лат. Quinqueecclesium) гэж Таван сүм гэсэн утгатай сүмийн нэр бөгөөд Унгарын Эсцтергом хотод оршино.
79. Чезмиумийн провост Угринус (лат. Huginus Cesmensis). Хожим 1244 онд Спалато хотын архбишопын суудалд вангийн нэрийн өмнөөс нэр дэвшиж байжээ.
80. Сэксфехэрвар хотын провост Ахиллэс (лат. Achilles). Хожим нь 1243 онд хааны дэд вангийн сайд болжээ.
81. Нагиварадын провост Винценциус (лат. Vincentius). Тэрээр 1244 оныг хүртэл Нагиварад хотын провост байсан бөгөөд 1244-1258 оны хооронд уг хотын бишоп байжээ. Нагиварад нь өнөөгийн Руминий баруун хойд зүгт хилийн орчим орших Ородэ хот бөгөөд X зуунд Унгарын ван үндэслэн байгуулжээ.
82. Буда хотын провост Томас (лат. Thomas). Тухайн үед дээр дурдсан Бенедиктусыг залгамжлан Буда хотын провост болоод байжээ.
83. Бан Дионисиус (лат. Dionisius banus) нь 1241-1245 оны хооронд бүх Славонийн бан байсан байна. Түүний дараа Славонийн гүнгийн хэргэмд дэвшиж вангийн гэр бүлийн гишүүн болжээ.
84. Владислаус (лат. Vladislaus) 1242-1245 оны хооронд вангийн ордны өмгөөлөгч гүн байв. Хожим 1245 онд дээр дурдсан Дионисиусыг залгамжлан бүх Славонийн бан, гүн болжээ.
85. Матеус (лат. Matheus) 1242-1246 оны хооронд эрдэнэсийн сангийн даамал байжээ.
86. Орландус (лат. Orlandus) нь үнэндээ агтын даамал бус, харин ордны даамал (1242-1245) байжээ. Хожим нь Славонийн бан хүртэл IV Бэла вангийн ордны нөлөө бүхий хэргэм, цолд дэвшиж байв.
87. Димитриус (лат. Dimitrius) нь 1232-1234, 1242-1245 оны хооронд ордны шүүгч байжээ.
88. Маурициус (лат. Mauritius) нь 1242-1245 оны хооронд вангийн өргөөний даамал байжээ.

сэтгэлийг ялимгүй түвдүүлэв. Ван Спалато хотод сууж үлдэхийг хүссэнгүй, харин эхнэр, өөрийн бүх эрдэнэсээ аван Трагуруим хот руу нүүлээ. Энэ хот арлуудтай ойрхон тул дайсны довтолгооноос илүү сайн хамгаалагдана байх хэмээн тэрбээр боджээ. Ванг ордныхон цөм дагалдан хотын ойролцоох аралд суурьшив.

39. Тартаруудын харгислалын тухай

Ад зэтгэрийн дарга [Хадан] санасанаа үл гүйцэлдүүлэн орхихыг хүссэнгүй улангасан галзуурсан цэргүүдээ яаралтай хаман цуглуулаад вангийн мөрөөр мөшгижээ. Тэрбээр вангийн цусанд зөвхөн шунаан тэчъяадах болсоны тул ванд хүрч алж устгах гагц сэтгэлд автан хилэгнэн галзуурсан ажээ. Славууд уул шугуйд нуугдсан байсан тул тэдний цусыг дэмий баахан урсгаж эс чадав. Гэвч тэрбээр нэг ч цэргийн хүч өмнө нь гэтлэн давж чадаагүй эзгүй ээрэм газар, эгц цавчим уулсыг туулж газраар явган бэдрэх бус, харин тэнгэрээр нисэн дүүлэх мэт хүрч ирэв. Ванг тэнгист сэлж зайлан одохоос урьдаж ванг довтлон барьж чадна хэмээн итгэсэндээ тэвчээр алдан адган яарч байжээ. Харин ванг тэнгисийн эрэгт аюулгүй хүрч очсоныг мэдээд явдлаа саарууллаа. Бүх цэрэг нь Сирбиум⁸⁹ хэмээгдэх нэгэн усанд хүрч ирэхэд тэрээр хэсэг зуур буудаллав. Мөнөөх хэрцгий яргачин Унгараас олзолсон бүх хүмүүсийг нэг газар бөөгнөрүүлэхийг тушаахад эр эм, хөвгүүд охидыг ялгалгүй цөмийг нэгэн хээр талд сүрэг хонь мэт тууж аваачаад зандалчдаараа толгойг нь авахуулжээ. Аймшигтайяа хашгиран орилох, чарлан уйлах дуун сонсогдож тэр чимээнд дэлхий ертөнц тэр чигтээ чичрэн дагжих мэт авай. Тариан талбайд цацсан буудайн үр мэт цогцосууд талаар нэг ханаран унасан байжухуй. Олзлон тонохын гагц шуналд үүдэгдэн энэхүү хэрцгий балмад аллагыг үйлдсэн гэдэгт итгэж ч чадамгүй ажгуу. Тэд хувцасыг тайлан авах гэж оролдсон ч үгүй, харин энэхүү тамын аймшигт хүмүүс үхдэлүүдийн эргэн тойронд хүрээлэн буудаллаад сайн үйлс бүтээж буй мэт их баяр цэнгэлтэйгээр идэж, бүжиглэж, ихэд наргиж хөхөрч байжээ. Тэгээд тэд тэндээс гарч Кроациаг⁹⁰ чиглэн явлаа. Тэд [Спалатод] ойртож ирсэн байсан ч

89. Сирбиум (лат. Sirbium) гол нь өнөөгийн Хорват, Боснийн нутгаар урсдаг Уна гол юм.

90. Кроациа (лат. Croatia) нь тухайн үед Унгарын вант улсын мэдэлд байжээ. Цаашид Хорват гэж орчуулав.

Спалато хотынхонд энэ бүгд итгэж боломгүй мэт санагдаж байлаа. Тэдний зарим хэсэг уулаас бууж ирэхүйд цөөн зарим нь хотын хэрэмний өмнө үзэгдэв. Спалато хотынхон эхлээд тэднийг хэн болохыг таньсангүй, харин Хорватууд гэж бодоод тэднийг угтахаар зэвсэглэн гарахыг боджээ. Гэвч Унгарууд тэдний тугыг хараад ухаан балартан, аюуж мэгдсэнээс цөм сүм руу бажгидан зугтаад ертөнцийн гэрэл гэгээг ахин харахаас өнгөрлөө хэмээн бодож чичрэн дагжисаар Ариун шүтээний тахилаас хишиг хүртжээ. Бусад нь эхнэр хүүхдүүдээ тэврэн авч уйлж, их орь дуу тавин ийнхүү хэлж байлаа: “Ээ халаг минь! Зугтан зайлах гэж тэмүүлэхийн хэрэг ч юусан билээ? Мөшгин хөөгчдийн илдний ирээс зайлж чадахгүй, эндээ нөгчих тавилантай юм бол хорвоог бартал туучин бэдрээд яахсан билээ дээ?” Хотын [гаднах] иргэд хэрмийн дотогш хаалга бүрийг зүглэн адуу мал, багаж хувцасаа орхин амь тэмцэн гүйлджээ. Тэдэнд үр хүүхдүүдээ хүлээх ч цаг байсангүй үхэлд туугдан аюулгүй газар хоргодохоор адган сандарч байв. Харин Спалато хотын [доторх] иргэд тэдэнд их хүнлэг сайхан сэтгэл гаргаж, гэртээ аваачаад хамаг чадахаараа тусалж байлаа. Гэвч зугтан ирэгсдийн тоо тэднийг бүгдийг орон гэрт багтааж боломгүй тийм их байсан агаад тэд гадаа гудаманд орогнож байв. Тэр бүү хэл сурвалжит хатагтай нар сүмийн эргэн тойронд гадаа орогнож байв. Бусад зарим нь харанхуй булан тохойд, зарим нь газар доорхи өрөө, хонгил дахь хог новшоо зайлуулан, бүр зарим нь майханд ч атугай хаа болох газараа толгой хоргоджээ.

Гэтэл Тартарууд тариан талбайд тааралдсан эмс хүүхэн, багачуул хүүхэд, настан буурай хэнийг ч цавчин алж авай. Тэр байтугай уяман өвчтэй хүмүүсийн амийг ч өршөөсөнгүй хэрцгий харгис үйлэндээ цэнгэн баясч байв. Тэгээд тэдний бүлэг цэрэг хотын хананд дөхөж ирээд хотын бүхэлд нь тойрч тандан судлаад өдөртөө гэдрэг буцав. Харин Спалато хотын иргэд урвуур хийж эхэлсэн бөгөөд тэдгээрээ тохирох газарт босгожээ. Тэгээд хэдэн өдөр өнгөрсөний дараа цэргийн бүх агт морьдод нь өвс тэжээл дутагдсаны тул Хадан хэсэг цэрэгтэйгээ ирэв. Энэ бол Март сарын эхэн цаг хахир хүйтэн хэвээр л байв. Гэсэн ч ванг Клиссиум хотын бэхлэлт цайзад байгаа хэмээн бодоод Тартарууд мөнөөх цайзыг тал бүрээс нь сум нисгэж, жад нүүлгэн довтлож эхлэв. Гэлээ ч уг цайз угаасаа сайтар бэхлэгдсэн тул багахан хэмжээний хохирол л учруулж чадав. Тэгээд тэд мориноосоо бууж өндөрлөг рүү

гараараа мацан авирч эхлэлээ. Гэвч цайзын хамгаалагчид тэдэн рүү чулуу нүүлгэн заримыг нь алжээ. Үнэндээ энэ саад тэднийг зөвхөн улам догшируулсан агаад тэд их хэрмийг давтал гардан тулалдав. Тэгээд байшин гэрүүдийг дээрэмдэн бага бус тонов. Ванг тэнд байхгүй байсныг мэдсэн тэд цайзыг довтлохоо больж Трагуриум⁹¹ балгасуныг морилохоор одлоо. Тэгэхэд цөөхөн нь л Спалато хот руу ирсэн юм.

[Спалато] хотын иргэд тэднээс үхтэлээ айсанаас бус харин Унгаруудын айдас хүйдэс, цөхрөл гунигт автсан байхыг хараад дагжин чичрэж байлаа. Тэдний зарим нь хотыг орхин, гэр орон,эд хөрөнгөө аван арлын аюулгүй газар одохоор болов. Тэд дэмий баахан түүх санаанаасаа зохион хоосон цуу яриа тарааж эхлэлээ. Зарим нь Тартарууд нүсэр том урвуур, асар олон байлдааны зэвсэг барьж босгоод түүгээрээ хотуудыг үнсэн товрого тухай ярьж байв. Бусад зарим нь тэднийг шороо, чулуугаар уул мэт өндөр овоо босгоод төвөг бэрхшээлгүй хотуудыг эзлэн авч чадна хэмээн нотлож байлаа.

Үнэн хэрэгтээ Тартар цэргүүд ад зэтгэрийн даргынхаа хамт Трагуриум балгасны дэргэдэх тэнгисийн эрэгт буудалласан байв. [Ван] Тартаруудыг өөрийн дутааж орогносон газарт тулж ирсэн байхыг үзээд эргийн ойролцоолцоох арлуудад байх нь аюултай хэмээн боджээ. Тэгээд хатан, хүүхдүүд, эрдэнэсээ хөлсөлж авсан хөлөг онгоцонд ачиж явуулаад өөрөө завинд сууж сэлүүрдэн эрэгт ойртож дайсныг тандан ажиглаж юу болохыг хүлээлээ. Эсрэг талд нь Хадан дарга ойрхи газруудыг бүхэлд нь тагнаж мэдээд хотын хэрмийн чанх доогуур мориор хот руу нэвтрэн орох гэж оролдов. Гэвч хотыг хуурай газраас тусгаарласан голын ус гаталж болшгүй гүн шавартайг мэдээд цэргүүдээ ухраажээ. Тэгээд мэдээ сонсохоор хот руу нэгэн элчин илгээв. Элчин хотын хэрмийн ойр ирж слав хэлээр их дуугаар өгүүлэв: “[Мөнх] тэнгэрийн [ивээлт] суут цэргийн даргач Кайданус үг ману. Бусдын цусны тулд өөрсдийг гэмд бүү учруултугай. Өст дайснуудыг гардуулж бидэнд өгөөд өрөөлд өшсөнийг хоосон [өөрсдөдөө] бүү хамааруултугай, [өөрсдийгөө] бүү хөнөөлгөтүгэй”⁹² Гэлээ ч хэрмийн

91. Трогир хот (лат. Tragurium, хор. Trogir, ит. Traù) нь өнөөгийн Хорватын Трогир агаад Спалато хотын ойролцоо Адриатын тэнгисийн эрэгт оршино.

92. “Nec dicit vobis divinus Caydanus, invicte militie princeps. Nolite reatum alieni sanguinis vobis appropriare, sed tradite adversarios ad manus nostras ne forte involmani vindicte eorum et pereatis [Үгчилбэл: “Үүнийг та нарт үл ялагдагч цэргийн даргач,

харуулууд тэдний үгэнд харуй өгөхийг зүрхэлсэнгүй. Тэдэнд нэг ч хариу бүү өг хэмээн ван зарлигдсан байв. Тиймээс бүх цэргээ босгон хөдөлж ирсэн зүгтээ одлоо. Тэд Мартиум сарын турш⁹³ Хорват, Далмацийн⁹⁴ газарт байсан бөгөөд энэ үедээ тав, зургаан удаа хотууд руу бууж тэгээд эргэн хүрээндээ буцдаг байв.

Тэд Хорватын газар нутагийг орхин Боснийн⁹⁵ мужийн гүнлигээр дайрав. Тэндээсээ Разиа⁹⁶ хэмээгдэх Сервиумийн⁹⁷ вант улсаар дайран өнгөрч Дээд Далмацийн эргийн балгадад хүрчээ. Рагузиумыг⁹⁸ хүрч багахан хохирол учруулаад дараа нь Катариум⁹⁹ хотод ирж түмэрдэн шатаав. Цааш давшин Суагиум¹⁰⁰, Дривостен¹⁰¹ балгадыг довтолж илднийхээ ирээр бүгдийг хяджээ. Хэрмийн хананд сарьсаныг ч үлдээлгүй хядав. Тэгээд бүх Сервиумаар давхин өнгөрч Булгариад¹⁰² хүрлээ. Бат, Хадан даргач хоёул цэргүүдийнхээ бүртгэлийг хийхээр шийджээ. Тийнхүү тэд хурж зөвлөлдөөд нутагтаа харихыг хүсэж буй санаа зоригоор эс олзлогдон яваа хэн ч бай даргач нарын өршөөл ивгээлээр чөлөөтэй явж болно хэмээн олзны хүмүүсийг өршөөж амь хэлтрүүлж буй мэт дүр эсгэн бүх цэргийнхээ өмнө их дуугаар зарлан тунхаглав. Асар ихээр баярлан хөөрсөн унгар, слав болон бусад олон үндэстний үй түмэн ардад тухайлсан өдөр цэргүүдийг орхин явахыг зөвшөөрөв. Тэгээд тэднийг бөөнөөр хоёр, гурван миль газар явж байхуйд гэнэт тэдэн дээр морин цэрэг довтолгон ирж илдээр цавчин цөмийг алаад талаар нэг хиаруулан одлоо.

тэнгэрлэг Кайданус хэлүүлэв. Бусдын цусны гэмийг өөрсдөд тохоохыг бүү хүсэгтүн. Өрөөлд өшсөнийг өөрсдөдөө тохоож мөхөхгүй гэвэл бидний өстөнийг бидний гарт өгтүгэй”].

93. 1242 оны 3 дугаар сар

94. Далмация (лат. Dalmatia) нь Адриатын тэнгисийн зүүн эргийн нэг хэсэг, өнөөгийн Хорват, Босни-Герцеговин, Монтенегрогийн нутаг дэвсэрийг заадаг газарзүйн нэр томъёо юм. Спалато бол Далмацийн төв хэсэгт орших хот юм.

95. Босни (лат. Bosnia)

96. Разиа (лат. Rasia)

97. Серб (лат. Servium)

98. Далмацийн хамгийн зүүн үзүүрт, Адриатын тэнгисийн эрэгт орших өнөөгийн Дубровник хот (лат. Ragusium) юм.

99. Өнөөгийн Монтенегрогийн Котор хот (лат. Cattarum) юм.

100. Өнөөгийн Монтенегрогийн Свач хот (лат. Suagium/Svadium) юм.

101. Өнөөгийн Албанийн Дришти хот (лат. Drivosten) юм.

102. Болгар (лат. Bulgaria)

Бела ван тагнуул илгээж ад зэтгэрийн хүмүүс улс орныг нь бүрэн орхин одсоныг баттай олж мэдээд цаг алдалгүй Унгарыг зорин хөдөлжээ. Гэвч хатан, залуу хунтайж хоёр Клисс цайзд үлдэж тэндээ Септембэр сарыг¹⁰³ хүртэл байв. Энэ хооронд вангийн хоёр бяцхан охин нас барсан агаад тэднийг Гэгээн Домнийн сүмд зохих ёсоор хүндэтгэн оршуулжээ.

Зэрлэгүүдийн хилэн догшин илдээрээ Унгар орныг бүхэлд нь түйвээсэн ч түүний араас золгүй ард аймшигт өлсгөлөнд нэрвэгдэн турж үхэхэд хүрсэн билээ. Тартаруудын уур хилэнгээс болж хөөрхий тариачид тариагаа ч тарьж чадсангүй, тарьсанаа хурааж авч ч хүчирсэнгүй. Тэдний хүүр цогцос тариан талбай дээгүүр, зам харгуй даган үй олноороо тэрийн хэвтэж байсан нь Унгарын ард иргэд Тартаруудын тахал мэт хөнөөлт харгислалд бус, харин өлсгөлөнгийн гаслант гамшигт сүйрсэн мэт санагдуулж авай. Тэгээд тэнд отож нуугдахаа байгаад ил задгай гэр орон руу дайран орж эхийнх нь хөхнөөс нялх нярайг хулгуулах болсон цуснаас өөр юунд ч үл цадах догшин хэрцгий чонос чөтгөр шуламын үүр агуйнаас гарч ирсэн мэт асар олноороо ирсэн билээ. Гагц нялх нярайгаар ч зогсохгүй, сүрэглээд зэвсэгтэй хүмүүс рүү ч ноцож дайраад хурц шүдээрээ тасчин идэж байв. Тийнхүү төмөр, өлсгөлөн, араатан хэмээх дээр дурдсан гурван түйтгэр Унгарын вант улсыг тэр чигт нь гурван жилийн турш тасралтгүй сүйтгэсэн бөгөөд Эзэний таалалаар үйлдсэн гэм нүглийнхээ төлөөсийг өчүүхэн төлөөгүй ажгуу.

103. 1242 оны 9 дүгээр сар

Номзүй

Анхдагч сурвалж:

- A tatárjárás emlékezete, ed. by Katona Tamás, Budapest: Európa Könyvkiadó, 1987, 211-239.
- Andreae Danduli ducis Venetiarum Chronica per extensum descripta: aa. 46-1280 d.C., in L. A. Muratori (a cura di). Raccolta degli storici italiani dal Cinquecento al Millecinquecento, vol. 12/1, Bologna: N. Zanichelli, 1938-1958.
- “April 11: De Sanctis Martyribus Dalmatis,” in Acta sanctorum quotquot toto orbe coluntur, vel a catholicis scriptoribus celebrantur, vol. 11, Parisiis et Romae: apud Victorem Palme bibliopolam 1866.
- “August 4: Sanctus Raynerius,” in Acta sanctorum quotquot toto orbe coluntur, vel a catholicis scriptoribus celebrantur, vol. 35, editio novissima, Parisiis et Romae: apud Victorem Palme bibliopolam 1866.
- Bretschneider, Emilii Vasilevich. Medieval Researches from Eastern Asiatic Sources: Fragments towards the Knowledge of the Geography and History of Central and Western Asia from the 13. to the 17. Century, Vol. 1, London: Routledge & Kegan 1967.
- Carpine, Giovanni di Pian di. Storia dei Mongoli, ed. by Enrico Menestò, Maria Cristiana Lungarotti, Paolo Daffinà, Claudio Leonardi, Luciano Petech, Spoleto: Centro Italiano di Studi sull’Alto Medioevo 1989.
- Foma Splitskij. Istorija arkhiepiskopov Saloni i Splita, ed. by Olga A. Aki mova, Moskow: Institut slavianovedeniia i balkanistiki 1997.
- Fontana, P. “Tommaso Arcidiacono di Spalato: Storia dei vescovi salonitani e spalatini,” in Archivio Storico per la Dalmazia 27, 1939; 28, 1939; 29, 1940.
- Jackson, Peter (tr.) The Mission of Friar William of Rubruck: His Journey to the Court of the Great Khan Möngke 1253-1255, London: The Hakluyt Society 1990.
- Juvaynī, ‘Alā’ al-Dīn Atā-Malik. The History of the World Conqueror, tr. from the text of Mirza Muhammad Qazvini by John Andrew Boyle, vol. 1, Manchester: Manchester University Press 1958.
- Krasovskii, A. “Istoriia salonskikh i spletskikh episkopov Fomi arkhidiakona Splitskogo,” in Trudi Kievskoi dukhovnoi akademii, Kiev, t. 3, 1876, 557-622; t. 4, 73-117; t. 5, 703-747; t. 1, 1877, 504-549.
- Lucius, Iohannes. De regno Dalmatiae et Croatiae libri sex, Amsterdam: Blaeu, 1666, 310-370.
- Der Mongolensturm: Berichte von Augenzeugen und Zeitgenossen, 1235-1250, übersetzt, eingeleitet und erläutert von Hansgerd Göckenjan und James R. Sweeney, Graz, Wien und Köln: Styria, 1985, 227-269 [Ungarns Geschichtsschreiber 3].

- Schwandtner, J. G. *Scriptores rerum Hungaricum, Dalmaticarum, Croaticarum et Slavonicarum*, Vol. 3, Lipsiae, 1746, 532-635.
- Skelton, R.A. et al. *The Vinland Map and the Tartar Relation*, New Haven and London: Yale University Press 1965.
- Thackston, W.M. *Rashiduddin Fazlul's Jami'u't-tawarikh Compendium of Chronicles: A History of the Mongols*, vol. 2, Cambridge: Harvard University Press 1998.
- Thomas, Spalatensis. *Notizie di Salona antica citta della Dalmazia estratte dalla "Cronaca Latina" inedita di Tommaso arcidiacono della Chiesa di Spalato che fioriva nel 1266*, Venezia: Alvisopoli 1843.
- Thomas Spalatensis. *Ex Thomae historia pontificum Salonitarum et Spalatinarum*, edidit L. de Heinemann, Hannoverae, 1892, 568-598 [Monumenta Germaniae Historica Scriptores 29].
- Thomas, Archidiaconus. *Historia Salonitana*, digessit Franjo Racki, Zagrabiae, in taberna libraria eiusdem societatis typographicae, 1894 [Monumenta Spectantia Historiam Slavorum Meridionalium 26].
- Thomae Archidiaconi Spalatensis. *Historia Salonitanorum pontificum atque Spalatensium a S.Domnio usque ad Rogerium (1266)*, in Atti e memorie della Società Dalmata di Storia patria, Supplemento al Volume 16, Padova: Società Cooperativa Tipografica 1988.
- Toma Arhidakon. *Historia Salonitana: povijest salonitanskih i splitskih prvosvećenika Thomae Archidiaconi Historia Salonitanorum atque Spalarinorum pontificum*, ed. by Olga Perić et al, Vols. 2, Split: Književni krug 2003.
- Thomæ Archidiaconi Spalatensis - Archdeacon Thomas of Split. *Historia salonitanorum atque spalatinarum pontificum - History of the Bishops of Salona and Split*, latin text by Olga Perić, ed., trans. and annotated by Damir Karbić, Mirjana Matijević Sokol and James Ross Sweeney, Budapest and New York: Central European University Press 2006.
- Wyngaert, P. Anastasius Van Den (ed.) *Sinica Franciscana: Itinera et Relationes Fratrum Minorum Saeculi XIII et XIV*, vol. 1, Firenze: Quaracchi 1929.

Хоёрдогч сурвалж:

- Базарсүрэн, Ж. Чингис хааны цэргийн тухай өгүүлэл, Улаанбаатар: Соёмбо 2007.
- Баясах, Ж. Их Монгол улсын түүхэнд холбогдох хятад хоёр сурвалж бичиг, Улаанбаатар: Адмон 2006.
- Гиессауф, Йо. “Тамын орны амьтанаас поп дууны шүлгийн баатар хүртэл. Европууд Чингис хааныг хэрхэн мэддэг болсон тухайд”, Баркманн, У.Б. (эмх.) Чингис хаан хийгээд түүний өв, Улаанбаатар: Адмон, 2007, 129-138.

- Рубрук, Гийом де. Монголын эзэнт гүрэнд зорчсон нь, орч. Ү.Төмөрхүлэг, Улаанбаатар: Адмон 2000.
- Чойсамба, Ч. Бат хааны байлдан дагуулал, Улаанбаатар: Битпресс 2006 [Түүхийг бүтээсэн хүмүүс цуврал].
- Balázs, Nagy. *Tatárjárás*, Budapest: Osiris Kiadó, 2003, 52-65.
- Barthold, V.V. "The Burial Rites of the Turks and the Mongols," in *Central Asiatic Journal* 14/1-3, 1970, 195-227.
- Bezzola, Gian Andri. *Die Mongolen in abendlandischer Sicht (1220-1270): ein Beitrag zur Frage der Volkerbegegnungen*, Francke Verlag: Bern and München 1974.
- Brown, Virginia. "Tommaso Arcidiacono. *Historia Salonitana*," in *Tesori della Croazia restaurati da Venetian Heritage Inc.*, Venice: Edizioni Multi graf, 2001, 166-167.
- Clark, David S. "The Medieval Origins of Modern Legal Education: Between Church and State," in *The American Journal of Comparative Law* 35/4, 1987, 672-678.
- Cocci, Alfredo. "Venezia e il Medio-Adriatico nella "Historia Salonitanorum Pontificum atque Spalatensium" (1245-1251) di Tommaso da Spalato L'Arcidiacono," in *Clio* 34/2, 1988, 365-375.
- Engel, Pál. *The Realm of St. Stephen: A History of Medieval Hungary, 895-1526*, London and New York: I.B. Tauris 2005.
- Farlati, Daniele. *Illyricum sacrum: Ecclesia Spalatensis olim Salonitana*, Vol. 3, Venetiis 1765.
- Florin Curta (ed.) *The Other Europe in the Middle Ages: Avars, Bulgars, Khazars and Cumans*, Leiden and Boston: Brill 2008.
- Giorgio Chittolini. "The Italian City-State and Its Territory," in *City States in Classical Antiquity and Medieval Italy*, ed. by Anthony Molho et al., Ann Arbor: University of Michigan Press, 1991, 589-602.
- Jackson, Peter. "Medieval Christendom's Encounter with the Alien," in *Historical Research* 74/186, 2001, 347-369.
- Jackson, Peter. *The Mongols and the West 1221-1410*, Harlow et al: Pearson Education 2005.
- Just-Verdus, Antonio. "Biografia di Tommaso," in *Atti e memorie della Società Dalmata di Storia patria* 5, 1966, 67-74.
- Klopprogge, Axel. *Ursprung und Ausprägung des abendländischen Mongolenbildes im 13. Jahrhundert: ein Versuch zur Ideengeschichte des Mittelalters*, Harrassowitz Verlag, Wiesbaden 1993 [Asiatische Forschungen 122].
- Kontler, László. *A History of Hungary: Millennium in Central Europe*, New York: Palgrave Macmillan 2002.
- Lawrence, C.H. *The Friars: the Impact of the Mendicant Orders on Medieval Society*, New York: Longman 1994.
- Marasco, G. "Tommaso da Spalato: storiografo e uomo di stato," in *Renovatio*

- 4/1, 1969, 114-119.
- Mirjana, Matijević Sokol. "Archdeacon Thomas of Split (1200-1268) – A Source of Early Croatian History," in *Review of Croatian History* 3, 2007, 251-269.
- Moore, John C. *Pope Innocent III (1160/1161-1216): To Root Up and to Plant*, Leiden and Boston: Brill 2003.
- Pelliot, Paul. *Notes on Marco Polo*, vol. 1, Paris: Imprimerie Nationale, Librairie Adrien-Maisonneuve 1959.
- Praga, Giuseppe. *History of Dalmatia*, Pisa: Giardini 1993.
- de Rachewiltz, Igor. *Papal Envoys to the Great Khans*, London: Faber and Faber 1971.
- de Rachewiltz, Igor. *Index to the Secret History of the Mongols*, Bloomington: Indiana University 1972.
- Róna-tas, András. *Hungarians and Europe in the Early Middle Ages: An Introduction to Early Hungarian History*, Budapest: Central European University Press 1999.
- Routsala, Antti. *Europeans and Mongols in the Middle of the Thirteenth Century: Encountering the Other*, The Finnish Academy of Science and Letters: Helsinki 2001 [Humaniora 314].
- Schmieder, Felicitas. *Europa und die Fremden: Die Mongolen im Urteil des Abendlandes vom 13. bis in das 15. Jahrhundert*, Sigmaringen: Thorbecke 1994 [Beiträge zur Geschichte und Quellenkunde des Mittelalters 16].
- Šegvić, Cherubino. *Tommaso Arcidiacono: il suo tempo e la sua opera*, Supplemento al *Bullettino di Archeologia e storia dalmata*, Spalato: Tipografia Leonina 1914.
- Salem, Alessandro. *Tommaso Arcidiacono e la storia medioevale di Spalato*, Zara: Tipografia E. de Schönfeld 1933.
- Serruys, Henry. "Mongyol: Mogal and Mangyus: Magus," in *Acta Orientalia Hungaricae* 36/1-3, 1982, 475-484.
- Sweeney, J.R. "Thomas of Spalato and the Mongols: A Thirteenth-Century Dalmatian View of Mongol Customs," in *Florilegium* 4, 1982, 156-183.
- Sweeney, J.R. "'Spurred on by the Fear of Death': Refugees and Displaced Populations during the Mongol Invasion of Hungary," in *Toronto Studies in Central and Inner Asia* 1, 1994, 34-62.
- Timothy May. *The Mongol Art of War: Chinggis Khan and the Mongol Military System*, Yardley: Westholme 2007.
- Vásáry, Istvan. *Cumans and Tatars: Oriental Military and the Pre-Ottoman's Balkans, 1185-1365*, Cambridge: Cambridge University Press 2005.
- Verger, Jacques. "The Universities and Scholasticism," in *The New Cambridge Medieval History*, ed. by David Abulafia, Vol. 5, Cambridge: Cambridge University Press, 1999, ch. 10, 256-276.